

**СОЁЛЫН ЖИМЭЭР
СОЁЛ СУДЛАЛЫН ТӨВ**

Volume.I

Fasc. 1-5

THE CULTURAL WAY

Ботийг эрхэлсэн: Тогос Э.Итгэл

УЛААНБААТАР
2022

ISSN: 2791-1446

Редакцын зөвлөл:

Доктор (Sc.D)	Д.Бадамдорж	(Монгол)
Доктор (Ph.D)	Л.Чулуунбаатар	(Монгол)
Доктор (Ph.D)	Н.Мягмар	(Монгол)
Доктор (Ph.D)	Л.Хурцбаатар	(Герман)
Доктор (Ph.D)	Л.Хасбаатар	(БНХАУ)
Доктор (Ph.D)	Б.Болд	(Япон)
Доктор (Ph.D)	Залгаабаяр	(БНХАУ)

“СОЁЛЫН ЖИМЭЭР”

Соёлын Жимээр ССТ-ийн эрдэм шинжилгээний сэтгүүл

ΣΟΔΟΝ

ΣΟΨΟΔ

PUBLISHING

УЛААНБААТАР

2022

CULTURAL WAY
CENTER FOR CULTURAL STUDIES

ISSN: 2791-1446

CULTURAL WAY

WORKS IN RESEARCH

Volume. 1

Edited by: Itgel. E

Editorial board:

Doctor (Sc.D)	Badamdorj. D	(Mongolia)
Doctor (Ph.D)	Chuluunbaatar. L	(Mongolia)
Doctor (Ph.D)	Myagmar. N	(Mongolia)
Doctor (Ph.D)	Qurčabaatar. L	(Germany)
Doctor (Ph.D)	Qasbaatar. L	(China)
Doctor (Ph.D)	Bold. B	(Japan)
Doctor (Ph.D)	Zalgaabayar	(China)

2022

ГАРЧИГ

Хасбаатар. Л, Наргил. *Ринчиний Чойномын захидлын нууцыг тайлах нь.....1*

Жаргал. *Коминтерн ба Монгол улсын харилцаан дахь Тагна Урианхай орны тухай нягтлах нь.....36*

Тэргэл, Кань Хай Ин. *БНХАУ дахь утга зохиолын монгол орчуулгын ерөнхий тойм.....48*

Ургаа. *Дөрвөлжин үсгийн хичээнгүй тиг ба түүний бичлэг зурлагын онцлог.....71*

Билиг, Кань Хай Ин. *Шашин шүтлэгийн нөлөөн дэх монгол төвөд уран зохиолын хүүрнэл.....84*

Мэдээ, мэдээлэл

CONTENT

Qasbaatar. L, Nargil. *Decrypting a letter of Choinom Rinchin*

Jargal. *An Examination of the Tagna Uriankhai country in Comintern-Mongolia relations*

Tergel, Kan Hai Ying. *Overview of Mongolian translation of literature in Chinese*

Urgaa. *The diligence of the Phags-pa script and its drawing features*

Bilig, Kan Hai Ying. *A narrative of Mongolian-Tibetan literature influenced by religion*

NEWS

РИНЧИНИЙ ЧОЙНОМЫН ЗАХИДЛААС ТҮҮНИЙ НУУЦЫГ ТАЙЛАХ НЬ

Л. Хасбаатар *

Наргил *

ХУРААНГУЙ

Ринчиний Чойномын уран бүтээлтэй системтэй танилцаж эхлээд бараг 30 жил болжээ. Түүний “Сүмтэй бударын чулуу” шүлгийн түүвэр нь 1989 онд анх Улаанбаатар хотод хэвлэгдэн гарснаас эдүгээ хүртэл маш олон товхимол номууд болон шинэ шинэ бүтээлийг нь хэвлэжээ. Үүнд бүгдийг багтаан тоочихын аргагүй, харин монгол улсад “Чойномын өд сан”-аас цувралаар гаргасан 14 боть “Р.Чойном” нэгэнт хэвлэгдэн гарав (Р.Чойномын бусад бүтээлийн хэвлэгдээгүй тэнд буй). Өвөр Монголын Соёлын хэвлэлийн хорооноос 2016 онд “Р.Чойномын зохиол бүтээлийн хураангуй” таван боть нь энэ их зохиолчийн уран бүтээлийн одоогоор олдоод буй гар бичмэл 60-70 хувь нь хэвлэгдэн гарсан гэж хэлэх учиртай. Мөн түүнчлэн түүний зохиосон дууны үг ая, зурсан зураг, сийлсэн сийлбэр, баримал, орчуулгын ажлууд нь бас судлагдаагүй байсаар байна.

Түлхүүр үгс: Р.Чойном, захидал, уран бүтээл

Р.Чойномын тухай найз нөхөд, ахан дүүс, төрөл төрөгсөд нарын дурсамжийн цуврал нэлээд гарчээ. Р.Чойномоор сэдэвлэж “Р.Чойном хаана байна?” кино, дуулиан тарьсан “Р.Чойномын нүүрийн хэв” зэрэг бүтээлүүд гарсан байна.

1. Р.Чойном судлалын тал дээр Л.Хасбаатар: “Яруу найрагч Ринчиний Чойномын амьдрал уран бүтээл” Улаанбаатар 1997

2. Л.Хасбаатар: “Р.Чойномын зохиол бүтээл дэх монгол эмэгтэйчүүдийн чөлөөлөлтийн тухай” Алтан гарди 1996 №4

* Доктор, профессор (ӨМИС, Монгол Судлалын Дээд Сургуулийн багш).

* Сэтгүүл зүйн ухааны магистрант (ӨМИС, Монгол Судлалын Дээд Сургууль).

THE CULTURAL WAY

3. Л.Хасбаатар: “Солгой хөгжим шиг цагийг сөрж явсан найрагч”, Улаанбаатар 1997

4. Л.Хасбаатар: “Р.Чойном судлал жич түүний шүлгүүд”, ӨМСХХ 1996

5. Солонгод Л.Хасбаатар: “Р.Чойном, Л.Чулуунбаатар” Герман 2015

6. Л.Хасбаатар: “Цагийн жаварт бөхөөгүй зул”, Улаанбаатар 2009

7. Д.Ганболд: “Р.Чойномын гар бичвэр судлал”, 2018 докторын өгүүлэл ... зэрэг бүтээлүүд буй.

Яруу найрагч Р.Чойномын зохиол бүтээлийг өнгөрсөн зууны 90-ээд оноос эхлэн жинхэнэ албан ёсоор хэвлэн нийтэлж, 90 онд төрийн шагналыг нэхэн олгосноор монгол улс жинхэнэ ардчилалын замаар замнаж эхлэв. Уран бүтээлийн шүүмж судалгаа нь ч шинэ уур амьсгалтай болж, өнгөрсний хэт зүүний үзэл, хэлмэгдүүлэлт хилсийг цагаатгаснаар эхлэв.

Бид нэг хүнийг тахин шүтэх үзэл, гуйвуулан магтах, хэтэрхий өргөх хэв журмаас бүрэн салж уран зохиолч ба уран зохиолыг чөлөөтэй шүүн хэлэлцэх цаг хүч ирэв.

Р.Чойном цагаатгагдсанаас тухайн хүний хувь түүх, уран бүтээл, ертөнцийг үзэх үзлийн тухай нэлээд бүрэн талаар судалгаа хийгдэж эхлэв. 1997 онд Ордос нутгийн Л.Хасбаатар “Чойномын амьдрал уран бүтээл” ганц сэдвээр монгол улсын шинжлэх ухааны академийн хэл зохиолын хүрээлэнд докторын зэрэг хамгаалж, Р.Чойномын монголын уран зохиолд эзлэх байр суурь, ур чадварыг хамгийн анх удаа зоригтой дурдан гаргаж мөн нотлолт хийж өгч билээ. Түүнээс бараг 20 жилийн дараа 2016 онд монгол улсын “Р.Чойномын өд сан”-г үүсгэн байгуулагч Д.Ганболд нь “Р.Чойномын гар бичвэр судлал”-аар докторын зэрэг хамгаалсан байна.

Хэдийгээр Р.Чойномын зохиол бүтээлийн хэсэг олдвор түүнчлэн олон гар бичмэлийн хуулбаруудаас нэг хэмжээний баталгаа нотолгоо гаргасан нь чамлашгүй юм. Өнөө цагт манай уран зохиолын гол дурсгалт баримтат шинж бүхий сэдвээр голлож бичдэг болсноор барахгүй манай уран зохиол шүүмж судалгааны ажил ч гэсэн өнгөрсний тухайн зохиогчийн хэдэн зохиол бүтээлийн задлалт хийгээд түүний зохиол бүтээлийн олон суурийг тухайн цаг үе, орчин тойрон, газар нутгийн бодит онцлогоос гардаж судлах нь маш чухал хэмээн үзэж байна. Иймээс

THE CULTURAL WAY

энд миний бие Р.Чойномын дотоод сэтгэлгээг илэрхийлж болохуйц нэгэн сэжим – захидлын тухай шинжилгээ хийхийг зорьлоо.

Мэдээж Р.Чойномын уран бүтээл яруу найрагт нь ч гэсэн захидлын хэлбэр бүхий шүлэг найраглалууд олон байдгийг миний судалгааны ажил дээр түүнийг “Илгээлтийн шүлэг”-ийн хэлбэрийн гол зорилго нь тухайн цаг үеийн гажуу доголдол, алдаа адлыг хойч үеийнхэндээ сургах хэлбэрээр зад шүүмжилж байсан байна. Гэвч хэвлэлээр дамжиж иймэрхүү бүтээл гарна гэдэг тухайн үед даанч бүтэшгүй хэрэг байсан.

Р.Чойномны хувьд авч үзвэл “зүгээр сууж чаддагүй, байнга юм оролдож байдаг” зан араншин нь түүнийг хожим хойшид юмыг маш оновчтой бодон шинжлэх, төсөөлөн бодох олон ур чадвартай болгон хөгжүүлжээ. Энэ нь түүний зохиол бүтээлээ хэр олон удаа, олон жил хугацаагаар тунгаан бодож явдаг, даацтай агаад туйлбартай хэмжээнд хүргэж байж сая бийр тавин бүтээлээ буулгадаг зантай болгосон байлаа. Түүний олон жил бодож явсан зүйлүүдээ найз нөхөддөө сул ярих биш, зайлшгүй илгээлтийн шүлгийн хэлбэр буюу захидал чимээндээ чухалчлан оруулж хэлдэг учраас сая бодож санаж байдаг тэр гүн нууц зүйлүүдийг эрэн гаргахад арай ойрхон байж таарна.

Р.Чойном хэдий богино насалсан ч түүний хүмүүстэй найзалж, нөхөрлөн үерхсэн нь цөөнгүй. Тэгээд ч бүгд уран зохиол урлагийн ажилд сонирхолтой, авьяастай хүмүүс зонхилно. Түүнд Р.Чойном нь бараг арав шахам жил эмнэлэг ба шоронд байлцсан, байнгын тогтворгүй газарт цөлөгдөх буюу аялан тэнэж явснаас хүмүүс хоорондын харилцаа нь зайлшгүй захидлаар харилцах шаардлагатай болгодог. Тэр үеийн цагдаа сэргийлэх болон тагнуулын байгууллагынхны хардалт сэрдлэг, гуйвуулан мушгилт газар авч байсан учир энэ олон төвөгтэй зам шугамаар захидал чимээгээр харилцдаг байжээ. Түүний бусдад бичсэн захидал маш олон байдаг бөгөөд сүүлчийн тусгай цуглуулгаар нэлээд нь бөөгнөрөн хуримтлагдсан боловч аль тэр болгоныг олж чадах нь ч юу л бол доо. Харин Ш.Дулмаа найрагчийн хэвлүүлсэн “Мөнх зул” ном ба билиг танхай яруу найрагч Тангадын Галсангийн эмхэтгэн хэвлүүлсэн “Нууц захидлууд” нь бидний гол судалгааны материал болох юм.

Р.Чойномын захидал чимээг ерөнхийд нь ажиглахад бидний мэдэхээр, монгол улс нь тусгаар тогтносноос 20 дугаар зууны 90-ээд он хүртэл бүх далаад жилийн түүхэн явцад ЗХУ-ын нөлөө хязгаарлалд бүх

THE CULTURAL WAY

үйл ажиллагаа нь колончлолын байдалд явж байсан тул их хэмжээний хэлмэгдүүлэлтийн балмад ажиллагаа болж өнгөрөв. Үүний дотор улс төрийн зүтгэлтэн эх оронч үзэл суртал уран зохиолч нарыг маш олон хэлмэгдүүлжээ. Энэхүү хар бараан сүүдрийн дунд эх орны хөгжил бадралыг маш ихээр хүсэн мөрөөдөж байсан Р.Чойном мэтийн олон олон халуун сэтгэлтэн хилсээр шоронгийн хаалгыг татаж байв. хэдийгээр шоронгийн торны цаана эрх чөлөөт амьдралаас бүрэн тусгаарлагдсан боловч Р.Чойном нь хилс гүжирт гоморхон шаналж зүгээр хэвтсэнгүй. Энэ хар торны цаана ч гэсэн эрх чөлөөт хүн ардынхаа төлөө гүнээ шаналж, зайлшгүй тэмцэх халуун зориг санаагаа ил тод илэрхийлсээр ирсэн билээ.

“Хүн хэн нэгэндээ зориулан тусгасан халуун сэтгэлийг захиа хэмээн”

“Захидал гэдэг баяр баясгалан

Залуу хүний хайрын сэтгэл

Заримдаа бас, хэн нэгэн дээр

Задран дэлбэрэх хүнд бөмбөг юм”¹

“... Алга дарамхан захидлын дугтуйд

Алах дайсан, аврах нөхөд

Амрагийн дунд чулуудсан яс

Амьдралын замд булсан хавх

Хахуул амласан бялдуучлалын ембүү

Халдвар ихтэй сэтгэлийн дампуу

Ханилал, хагацал, инээд, нулимс

Хамаг хорвоо бүгд багтдаг байна”²

Р.Чойномын захидал чимээ бол даруй түүний “нууц ертөнц”-ийг тайлах түлхүүр мөн эж Т.Галсан гуай нэгэнт хэлсэн нь буй.

Нэг. Би шүлэггүй төрж, шүлэгтэй үхэх өндөр аз тавилантай хүн

Уран бүтээлч Р.Чойном энэ ертөнцөд төрж амьдрах өөрийн хувь тавилангаа: “Би шүлэгт сайхан хүүхэнд дурлахаас ч олон хувь дуртай. Шүлэг бол миний амьд явахын утга учир болж мах цусанд шингэжээ. Би шүлэггүй төрж, шүлэгтэй үхэх өндөх аз тавилантай хүн юм”³ хэмээн

¹ Б.Дамдинсүрэн. “Р.Чойномын шүлэг зохиолын хураангуй”, боть V, ӨМСХХ 2014, х 469

² Б.Дамдинсүрэн. “Р.Чойномын шүлэг зохиолын хураангуй”, боть V, ӨМСХХ 2014, х 469

³ Б.Дамдинсүрэн. “Р.Чойномын шүлэг зохиолын хураангуй”, боть V, ӨМСХХ 2014, х 470

THE CULTURAL WAY

дүгнэж ярьснаар барахгүй шүлэг найргаар энэ замбуулин хорвоотой ид үзэлцэн явж билээ. Ер нь шүлэг найраг оролдоод бараг 33 жил дамжин махарсан түүхтэй. Тэрбээр энэ бараан орчлонг анх яруу найргийн нүдээр харахдаа:

... Хайртайхан Долгор минь

Хархан нүдтэй юм

Хайрлаж явсан би чинь

Хархан дээлтэй юм гэж бүр бага балчир насандаа гэнэтийн онгодоор цалгиж эхэлснээ өврийн тэмдэглэл буюу яруу найрагтаа хэдэндээ дурдсан нь буй. Тэр яруу сайхан шүлэг бичихийн төлөө өөрийн амьдарч явсан бүхийл цаг хормыг тэр л үйлсийн төлөө зориулсан билээ. Эмнэлэгт, шоронд, наранд амьдарч буй аль ч үедээ тухайн тэрхүү хавчигдмал боогдмол орчинд ч гэсэн дэлхийн сонгодог ном бүтээл, шинэ хэвлэлийн сонин сэтгүүл, шинэ ном ботиуд, кино драм, жүжиг урлагийг аль болох бүхнийг олж уншдаг, орчуулдаг, ойлгодог мөртлөө бусадтай илэн далангүй хуваалцаж, мөн өөрийн үзэл бодлоо шулуун шууд илэрхийлдэг байв. түүний уншсан ном хэчнээн байдгийг үнэхээр төсөөлөхийн аргагүй. Нэгэн түүх сөхвөл:

... 1955 онд Өндөрхаан хотод Цагаан-Өвгөн гуайн хариуцаж байсан номын сангийн номыг нэг л өвлийн хугацаанд бараг бүгдийг уншиж дуусгасан гэдгийг сурвалжлагын явцад Цагаан-Өвгөн гуай надад гайхан дурсаж билээ.

Ээжийнх нь ярьсанчлан – Багаасаа ерөөс зүгээр суудаггүй, юм оролдож л байдаг хөдөлгөөнтэй хүүхэд байсан гэх зэргээр тэрээр бүхийл боломжтой цаг болгоныг маш ухаалаг ашиглаж ном гэдгийг бол унд уухын жишээнд уншдаг байсан түүхтэй, мөн номынхоо тухайд маш оновчтой дүгнэлт хийж үздэг бөгөөд давуу тал болоод сул хүрэлцээгүй зүйлийг нь цаг даруйд нь хэлж байдаг билээ.

“... Та нөхөд надад, орос хэвлэлийн шинэ дугаар бүхнээс эхэнд заавал явуулж байгаарай ! би хэвлэлээр ангаж үхэх нь байна”⁴

“... Би өөрийн муу биеийг шоронд хийгээд өнгөрье. Монгол шүлгийг шоронд хийгээд яах вэ дээ! Ямраар ч бичиж болдог монгол шүлэг хэв хэзээд эрх чөлөөтэй байх болтугай! Энэ сайхан хэлээр, энэ баялаг шүлгийг үүнээс хойш бичиж чаддаг хүн бичиж байх болтугай!”⁵

⁴ Б.Дамдинсүрэн. “Р.Чойномын шүлэг зохиолын хураангуй”, боть V, ӨМСХХ 2014, х 436

⁵ Б.Дамдинсүрэн. “Р.Чойномын шүлэг зохиолын хураангуй”, боть V, ӨМСХХ 2014, х 444

THE CULTURAL WAY

*“... Мэндийн хариугүй байна гэдэг бол том доромжлол юм шүү!
Засаг намайг доромжлоогүй байхад нөхөд намайг доромжлох цаг болж
байгаа юм байх аа!”⁶*

Р.Чойном нь анд нөхөддөө цаг алдалгүй захиа бичиж амар мэндийг нь асууж, ном хэвлэлийн тухай, сайн сайхны тухай олонтоо хэлэлцэж байдаг боловч ихэнх нөхөд нь хувийн амьдрал буюу цаг төрийн үймээнээс өөрийгөө өмгөөлөхийн тулд тэр бүрчлэн хариу бичдэггүй байсан. Түүнд нь үнэн сэтгэлээсээ гомдож олон удаагийн захиандаа иймэрхүү гомдлоо тоочсон байдаг. Цагийн өнгө гэж хэцүү юм аа. Нийлж дэрвэж, амжилт жаргалтай байх үед нөхөд найз хэмээн хундаган дотор цалгидаг олон хуурмаг найзууд байдгийг Р.Чойном нэг биш удаа Р.Чулуунбазарт бичсэн захидалдаа захин хэлж байсан нь хүн ёсны хувь дахь хичээл хүмүүжил болно.

Зохиолч хүн хэзээд гуйвшгүй байх хэрэгтэй. Зорьсон чиглэлээ тогтоосон л бол түүний төлөө үхэн хатан тэмцэх нь Р.Чойномын өргөсөн тангараг нь байдаг. Тэр захидалдаа:

“... Хүмүүсийн ямар байх тэдний орчин тойрон нийгэм төр, ёс суртахуун нь захирч мэддэг жамтай болохоор яая гэх вэ!”

... Хар бага наснаасаа хүзүүндээ тоног углах дургүй ярдаг зантай өссөн хүн, эцэстээ аль муугаа үздэг байна. Тун нарийн бодов. Тээрмийн илжиг, тэнгэрийн шувуу, хоёрын тэр нь дээрээ гэх юм алга л даа. Илжиг нисэх гэвэл харин сүйрэх нь тэр, шувуунд буулга углах гэсэн этгээд өөрөө зовно. Юм бүхэнд өөрийн зүй тогтол байхаас гадна бас хувийн зохицол тавилан гэж байх бололтой. Мод бүхэн ойд боловч бас зарим нь хотод, бүр цөөн нь айлын гэрт ч байх ажээ. Морь бүхэн наадамд уралддаггүй, зарим нь хонинд, зарим нь тэргэнд, зарим нь идиинд зориулагджээ. Хүн бүхэн шүлэгч байдаггүй. Бас шүлэгч бүхэн, ой ёслолын магтаалч байдаггүй байна.

... Урлагийн үйлтэн хүн гэдэг, энгийн хүмүүсээс түрүүлж аливаа зүйлийг сэтгэн, түрүүлж баясаж, түрүүлэн уясаж, бас түрүүлэн гомдож чаддаг, өөрөөр хэлбэл илүү мэдрэмтгий ой ухаантай ч юм уу даа.

... Тийм байж, эгэл олон санаагүйг санаж, тэдний хойноос нь бид урдаас нь хэлж өгч байдаг байх хэрэгтэй юм даа.

⁶ Б.Дамдинсүрэн. “Р.Чойномын шүлэг зохиолын хураангуй”, боть V, ӨМСХХ 2014, х 445

THE CULTURAL WAY

... Тийм мөртлөө бид бол мөнгөний шүлэгч биш. Уран бүтээлчдэд, зохиолын шагналаас гадна сэтгэл санааны энхрийлэл зайлшгүй хэрэгтэй байдаг”⁷

Ер нь 20 дугаар зуун бол дэлхий нийтийг хамарсан аз бус тохиолдол, дайн дажин, гай барцадаар дүүрсэн он жилүүд билээ. Энэ бүтэн зуун жил дэлхийн том хөрсөн дээр хэчнээн олон санаанд багтамгүй учир явдлууд гарч байсныг түүх бидэнд гэрчилж ирлээ. Хамгийн гол нь нийгмийн давхаргад том их хувиралт гарч хэчнээн мянган жилийн хугацааны боолт, феодал, хөрөнгөт нийгмийн сулрал болж дэлхийн түүхийн нийгэм журамт социализм байгуулал тогтносноос болж шинэ хуучин нийгмийн солбицлын зааг үед маш хэрцгий, харгис улс төрийн жүжгүүдийг тоглосон учир, төр засгийн өмнө фронтод дуу хоолой болон нэрлэгдсэн уран зохиолчдын эгнээнд ил далд маш олон уран зохиолчид, уран бүтээлч өөрийн зорьсон зорилгоосоо няцаж, ухарч, эсвэл шийтгүүлж байсан түүхийг сөхөх юм бол хар бараан тэрхүү утаа түймэр буу зэвсгийн аюулаас ч илт илүү байсан гэж хэлэхэд мөхөсдөхгүй буй за. Гэвч хэсэг бүлэг зохиолчид үнэн ёсны төлөө амиа хайхралгүйгээр цаг үеийн золиос болж хэлмэгдэж шийтгэгдэж бүр цаазын тавцанд гарч байсан нь ч цөөнгүй. Үүний дунд говь нутгийн хутагтын “хувилгаан” хэмээн шоронгийн хаалгыг татаж байсан Р.Чойном ч үүнээсээ няцалгүйгээр машид илэрхийлэн тэмцэж ирсэн нь өнөө цагийн гайхамшиг болон үлдсэн байна.

Түүний Ш.Дулмаад бичсэн нэгэн хувь захидалд:

Бид уулзалгүй уджээ. Гэвч, сэтгэл зүрхний бичээсийг он жилийн баллуур хэзээ ч арилгаж байсангүй, садан төрлийн өнчрөлөөс найз нөхдийн өнчрөл илүү хүнд хүчир байдаг ажээ. Намайг уучлаарай. Хамгийн дотно нөхрөөс эхлэн, хамгийн цаад захын зүс таних төдий хүнийг хүртэл, шүлгийн мөр дотор “эх орон” гэж сэтгэдэг тэр бүхэнд хандаж би уучлалт гуйх цаг нь одоо болсон байна.

Өөрийн явсан явдал, загнасан занг эргэн бодож, биеийн тамирын дэлхийн том тэмцээнийх шиг, үйл хөдлөлийг нь удаашируулан тунгааж үзлээ, ид цэцэглэлтийн үе, ид төөрөгдлийн үе хоёрт зэрэгцэн оногдсон өөрийн харамсалт хувь тавиланг ганцаараа гасланхан байж, арван жил кино болгон үзлээ.

⁷ Б.Дамдинсүрэн. “Р.Чойномын шүлэг зохиолын хураангуй”, боть V, ӨМСХХ 2014, х 450

THE CULTURAL WAY

Өнгөрсөн энэ 10 жилд би өөрийгөө өөрчлөх гэж их тэмцлээ. Гэвч чадсангүй ... намайг анх байгалиас их “гэлүлд” батлахдаа хоёр буюу гуравдугаар вариант (хувилбар - зохиогч) байхгүй, цор ганц ийм л хувиар баталсан ажээ. Одоо би та нөхдийг санан гиюурч, шүлгээ бичсээр, ном уншиж, гэрийн мухар сахин, үхэх өдрийг тэвчээртэй хүлээж сууна. Амьдралын хань, амраг гэргий гэвэл миний хамаг зовлонг хуваалцдаг ном байна”⁸

Монгол улсын ардын уран зохиолч Т.Галсан гуай “Нууц захидлын нууц” хэмээх номын өмнөтгөлд бичихдээ: Жорж Бруно “дэлхий бөөрөнхий” гэж баталсных нь төлөө шатаасан шиг Р.Чойномыг нам найрамдлын дууч болоогүйд амьдаар нь авсласан хүмүүсийг бид мартаж ёсгүй. Мартах ч ёсгүй. Эх орныхоо төлөө өөрийгөө золиослосон хүнийг түүх баатар гэдэг. Чойном бол тийм баатарлаг найрагч байсан учир Р.Чойномын нэрэмжит “Ганц хүний театр” ард түмнийг ухаарлаар угжиж, нулимсаар шагнаж байна. Р.Чойномыг цусгүй алагсад өнөө их найрагчийг үгүйсгэгчид болсон ч Р.Чойном судлал эх орондоо төдийгүй гадаадад ч дэлгэрч буйг өвөрлөгчийн эрдэмтэн Хасбаатарын бүтээлүүд батална” хэмээжээ.

Энэ бол Р.Чойном судлал байх мөртлөө зайлшгүй дэлхий нийтийн урлаг, уран зохиол судлалын нэгэн жинтэй хуудас болох ёстой гэснийг ард нийтэд зарлаж байхын шинж бүлгээ. Тийм ч байх ёстой. Түүх баатар хүнийг бүтээхдээ амьд ахуйд нь жаргал өвлүүлж өгдөггүй ч эцэс сүүлд нь дэлхийн хүн ардад үнэн ёсны төлөө тэмцлийнх нь зөв оновчтой дүгнэлтийг нь заавал олгуулж өгч байх хэрэгтэй. Энэ бол дэлхийн хэдэн мянган жилийн түүхэн туршлага болж таарна.

Тэрээр уран бүтээлийн эцсийн зорилгыг жишиж хэлэхдээ: “... *Чи харсан биз дээ? чулуун нүүрс түлж байгаад зуухныхаа ам руу шагайгаарай. Шатаж дууссан нүүрсний гал улаан цогийг харахад юу үзэгддэг билээ?*

Гал улаан навч, түймэр, ойн амьдрал харагддаг юм. Олон салаалж навчилсан ургамлын нэг туг мөчир, навчис ... энэ бол эрт баларын ой модны үнэн дүр!

Зуур цагийн зуун мянган оны их хаганд баригдан дарагдаж тэр чигээрээ чулуужиж төгссөн энэ антрацит нүүрс, галд ороод шатамхай

⁸ Б.Дамдинсүрэн. “Р.Чойномын шүлэг зохиолын хураангуй”, боть V, ӨМСХХ 2014, х 466

THE CULTURAL WAY

хаг, нягтарсан хий нь нэгэнт асаж дуусахад жинхэнэ навч мөчрийн зүйлс биет сүнс болон үлдсэн нь тэр биз ээ!, юм хэдий дарагдан, танигдашгүй болж сөнөвч цагийн шалгалтад эрт орой заавал хэзээ юу байсан нь тодрох үе буй!”⁹

Урьд өмнө 60-аад оны “Алтай”, “Залуу нас”, “Хүн” (дээд) романы хэвлэлээс хойш Р.Чойномын мянга мянган зохиол бүтээл нь монгол улсын намын төв хорооны дэргэдэх утга зохиолыг шүүх хэлтэс, зохиолчдын хэвлэлийн хорооны тусгай хяналт доор орсноор бараг нэг ч ширхэг шүлэг нь хэвлэлийн хуудсанд өртөөгүй бөгөөд монголын уншигчдаас түүний шинэ бүтээлийг албан ёсоор унших ямар ч бололцоогүй болжээ. Үүнээс хойш Р.Чойномын амьдрал, гэр бүл, албан ажил төрөл нь дотоод яамны хатуу хяналтанл орсон учир тэнүүлчийн амьдралд орсон билээ. Тэгээд цөлөлт хардалт болгон үхэн үхтэл нь үргэлжлэв. Гэвч Р.Чойном нь уран бүтээлийн төлөө хэдий зэмдэг бие ядуу тарчиг амьдарч байсан ч шүлэг зохиолынхоо төлөө зориг шантраагүйгээр барахгүй тасралтгүй өөрийгөө цэнэглэж сайн дураараа тэмцлээ үргэлжлүүлсээр явжээ.

“Одоо бол би, жинхэнэ уран бүтээлч болсон үеийнхээ анхны номыг гаргах гэж байгаа болохоор хариуцлагатай хандалгүй болохгүй. Бас, миний номыг хэвлэлээс гарангуут нь буудах гээд отож байгаа хүн ч олон буй. Олигтой юм гаргаасай гэж сэтгэл зовон хүлээж байгаа хүн бүр ч олон буй. Харин роман (Даланжаргаланг хэлж байна) 4500 мөрөөр бодож байснаа бодвол 8400 мөр болж, их шунах нь байна. Энэ л их аюултай байна.

Гэвч яах вэ! Миний хувьд, яруу найргийн шинэ үеийнхнийг ихэд сонирхож, Улаанбаатарынхны уран бүтээлийн өнөөдрийн амьсгал, чиг, өнгийг нэлээд шинжилж ажиглалаа. Эднээс сурах юм бас их байна. “Эргэж харалгүйгээр урагшаа ахихгүй” гэж хэлэх юм бол миний хувьд биеэ хэт тоосон явдал болно биз ээ. Учир нь би эдний урд биш, эд миний урд явж байна. Албан ёсны уншигчид бол миний 1962 онд бичиж суусан “Хүн” романаас хойш уран бүтээлийг уншаагүй болохоор намайг 12 жилийн өмнөх байдлаар л ойлгож, дүгнэж яваа шүү дээ. Энэ бас аль аль талдаа хөөрхийлөлтэй асуудал шүү.

⁹ Б.Дамдинсүрэн. “Р.Чойномын шүлэг зохиолын хураангуй”, боть V, ӨМСХХ 2014, х 484

THE CULTURAL WAY

Сая би Улаанбаатарт байсан 5 сарын хугацаандаа урьд өмнө үзээгүй олон зүйлээ олж харлаа. Олон орны тэргүүний сэхээтэн жинхэнэ уран бүтээлч хүмүүстэй уулзаж санал онолоо солицлоо. Эрдэмтэн сайчуултай хүртэл биеэ үгүйсгэлгүй ном хэлэлцэж үзлээ.

Намайг тэд өндөр үнэлж байгаа явдал, юу юунаас илүүгээр намайг зоригжуулж, уран бүтээлд хандах хандлагыг их өөрчиллөө. Урьд би ихэвчлэн түүхий сэхээтнүүдтэй үерхэж, бодол сэтгэлгээ миний тэдний хүрэнээс тэр болгон хэтэрч чадахгүй явсан тал байна.

... Харин уран бүтээлийн тал дээр, хий цэнэж цаг алдалгүй, насны галтайд олон түмнээр шүүлгэж байсан нь дээр юм шүү!”¹⁰

Тэр зохиол бичих уг зорилгын дагуу нэг насаа зориулснаа ийнхүү ярьж билээ:

... Гэвч би бол хэзээд одоо жаргасан ч урт наслахгүй, зовсон ч удаан зовохгүй хүн тул өөрийн санаж зорьсон уран бүтээлээ л оролдож байгаад өнгөрнө. Энэ бол ирээдүйгүй хүний ажил юм. (үг юм)

“... Гэхдээ би ард түмэнд бүр хэрэгтэй юм хийхээс илүү жаргал байхгүй. Тэр л жаргалаар би цөөн насандаа дүүрэн жаргалаа. Тийм жаргалыг мэддэггүй хүнтэй маргах гэдэг адгийн зовлон байдаг бол би тийм зовлонгоор насан турш зовлоо”¹¹

“... Зул бөхөх дөхөхдөө гэрэл нь их болдог. Юм юманд оролцож байгаад харандаа бариастай үхнэ дээ цус!”¹²

Р.Чойномыг сүүлийн үеийн эрдэмтэд “болхи шүлэгч”, “боловсрол хүртээгүй” бүр цаашилбал, гудамжны шүлэгч, архины завхуул ч гэж дуудан шүүмжлэгсэд цөөнгүй. Жинхэнэ утга дээрээ Р.Чойномын ном бүтээл уншсан, түүнийгээ цааш нь хэрхэн бодож тунгаасан, бодлогоширсон зүйл өнөөгийн бидний дунд “том гэрэл” болон мэлцийн томордог эрдэмтэн мэргэд, судлаач шүүмжлэгчдээс хол өндөр дээрээс яруу найраг, уран бүтээлийн тухай тунгаан бодсон нь буй:

“... Бид яруу найргийг уншихдаа заавал түүнийг эс бол шүтэх, эсвэл хараах ийм зарчимтай байж заншсан байна. Энэ нь согтуу аранишин бөгөөд согтуу хүн бол эсвэл сүйд болж үнсдэг, эсвэл агсамнаж загнадаг байлаа. Ийм овилгогүй зангийн хэт хөшүүн дүгнэлтийг бусдын дэргэд, бусдын уран бүтээл дээр гэж болохгүй. ... Бидний цөөхөн

¹⁰ Б.Дамдинсүрэн. “Р.Чойномын шүлэг зохиолын хураангуй”, боть V, ӨМСХХ 2014, х 506

¹¹ Б.Дамдинсүрэн. “Р.Чойномын шүлэг зохиолын хураангуй”, боть V, ӨМСХХ 2014, х 510

¹² Б.Дамдинсүрэн. “Р.Чойномын шүлэг зохиолын хураангуй”, боть V, ӨМСХХ, 2014, х 511

THE CULTURAL WAY

*монголчууд бие биеэ хайрлах хэрэгтэй гэж М.Цэдэндоржийн хэлсэн үг тун сайн үг шүү!*¹³

Тэр мөн яруу найрагчдын ур чадварын хувьд, урлан бичих арга барилын хувьд гүнзгий бодож ажигласнаа хуваалцжээ. ... Шүлэг зохиолд, ялангуяа уянгын шүлэгт, уншигчиддаа хэрхэн хандахыг одоо болтол би нарийн тогтоогүй яваа юм уу эсвэл манай хүмүүс (цензур) уянгын сэтгэлгээ нь гагцхүү зохиолч хүнд байдаг. Уншигчдад бол байхгүй гэж үздэг юм уу, эсвэл манайхан (цензур), мөн утга зохиол судлаачид уянгын философи байхгүй, хуурай тархитай улс юм уу? үгүй бол тэд жинхэнэ марксистаар сэтгэдэг юм байлгүй хөөрхий!

Харин миний хэлэх гэж байгаа зүйл бол уянгын шүлэг заавал уншигчид ном номлож, өөрийн сургаалийг тулгаж хэлэх нь бус, юу ч номлохгүй, гагцхүү үнэнхүү зураглал, өөрийн нарийн ажиглалтыг уншигчтай хуваалцах нь илүү энгийн үнэмшилтэй юм уу?

Сая би, английн Когот Роксрод гэгч шүлэгчийн нэлээд уянгыг уншлаа. Хүнд юу ч тулгаж хэлээгүй юм. Тэр ч байтугай юмсыг тийм ийм байдаг гэж нотлоогүй юм. Харин сэтгэл хөдлөм сайхнаар байгаль орчин болон хувийн сэтгэлгээгээ хэнд ч юу ч номлоогүй, тийм л сонин шүлгүүд байх юм. Тэгэхдээ сэтгэлд нэг юм хөдөлгөөд, өөрийн эрхгүй хувийн зовлон жаргалыг бодоход хүргэх ажээ. Энэ ёстой уянгын шүлэг гэгч мөн байх аа.

... Манай дорно дахин бол номлол айлдах дуртай. Орос өөрийгөө магтах дуртай. Хятад загнах дуртай юм уу даа ...”¹⁴ гэх мэтчилэн түүний уран бүтээлийн тухай төрж, түүнийхээ төлөө тэмцэж явснаа энэхүү захиа чимээндээ бас хэдэн хүнтэй – Ш.Дулмаа болон дүү Р.Чулуунбазартайгаа хуваалцан ярьсныг энд тэмдэглэв. Энэ бол социалист нийгмийн харанхуй өдрүүдийн дотор уран бүтээлч Ринчиний Чойномын үнэн үгийн зэвсэгтэн болсны нэгэн гэрч баримт юм.

Хоёр. Унших номын буянаар, бичих номын ухаан төрөх

Уран бүтээлч Р.Чойном нь өөрийгөө яруу найраггүй төрөөд, яруу найрагтай үхэх аз тавилантай хүн хэмээн нэгэнт хэлсэн нь буй. Тэрбээр зохиолоо хэрхэн бичиж боловсруулдаг, түүнийхээ төлөө хэрхэн ном уншдаг тухайгаа энэхүү захидал дотроо хуучилсан нь цөөнгүй.

¹³ Б.Дамдинсүрэн. “Р.Чойномын шүлэг зохиолын хураангуй”, боть V, ӨМСХХ 2014, х 532

¹⁴ Б.Дамдинсүрэн. “Р.Чойномын шүлэг зохиолын хураангуй”, боть V, ӨМСХХ 2014, х 541

THE CULTURAL WAY

Зорилготой юманд ганзага даруулах нь ямар их чухал байдгийг түүний туулж ирсэн зам мөрүүдээс хайж үзсүгэй.

Ш.Дулмаа дурдахдаа:

“Хөөрхий тэр сайхан амьдаръя гэж тэмцсэн, амьдралынхаа сүүлчийн мөчийг нөхдийнхөө тухай сэтгэн бодож, шүлгээ бичиж, шинэ ном уншиж байсан нь үхлийг сөрсөн түүний их тэмцэл байсныг зориуд тэмдэглүүштэй”¹⁵

Тухайн он жилүүдэд, сайн зохиол бичиж хэвлэлээр дамжин хэвлүүлэх ажил их хэцүү байсан, нэн үндэстний бахархал, эх орны хөгжил бадралын талаар үнэнийг эрэлхийлэн шүлэглэхийг хүртэл хориглодог байсан учир хэвлэл дамжих хянагчдын гарын үсгээр зөвшөөрүүлэх байтугай, “энэ хүний бүтээлийг сонин сэтгүүлээр хэвлүүлж болохгүй” гэдэг хар тамга даруулах нь юун түрүүнд өртдөг байсан. Үнэн мөрөөр Р.Чойном олонтоо явсан бөгөөд насны эцэс болтлоо жинхэнэ хэвлэлээр бүтээлээ гаргаж байгаагүй бөгөөд энд тэндэхийн яруу найргийн наадам, өдөрлөг, ойн арга хэмжээнд ч бүтээлээ өгч хэлэлцүүлж, унших эрхээ хасуулсан байв. Тэр бол утга зохиолыг дээдлэн үзэх төрийн оролцоо бус, улс төрийн хар дарсан тамгаар аливааг дардаг байсан зэлүүд бүрхэг он жилийн тэмдэг билээ. Тиймэрхүү орчин агаараас болж монголын уран зохиол тэр тусмаа яруу найргийн уянга сэдэв, шинэ сэвүүн мэдрэмж, оргилом халуун урам сэтгэлгээг няц дарж байснаас яруу найргийн шинэ хөгжил бүхий арга барилтай бүтээлүүд шигшигдэн, хогийн саванд хаягддаг байлаа. Үүний зэрэгцээ нэг бүлэг намын шүлэгчдийн эгнээ бүрэлдэж шал дэмий магтаал уриагаар амьсгаадсан хэнд ч хэрэггүй бүтээлүүд намын том сэтгүүл сонин дээр газар авч байжээ. Энэ тухай гоморхсон шинийг сэтгэгч уран бүтээлч байсныг хэлээд яахав! Р.Чойном үүний тухай ярихдаа:

... Уран бүтээлийн хувь зохиолд угаас “ард – халх” учир хоншоор дутам төрсөн миний бие, одоо ч 50 жилийн ойд Дэрэв гуай “монгол хэлний буйн газар” байгуулж, эс бусын муу сайн шүлэг шиг юмаа хэвлүүлж “монголын шилдэг” гэж нэр өгөөд, даян дэлхийд тархааж нэр гутаах явдалд лав саадгүй, айх юм үгүй болжээ”¹⁶

Тэр олдохын хэрээр сонин хэвлэлээс, радио долгионоор зохиолчдын шинэ бүтээлийг олж үзэж сонсдог, тэр бүгд хэн бүгдийн

¹⁵ Б.Дамдинсүрэн. “Р.Чойномын шүлэг зохиолын хураангуй”, боть V, ӨМСХХ 2014, х 424

¹⁶ Б.Дамдинсүрэн. “Р.Чойномын шүлэг зохиолын хураангуй”, боть V, ӨМСХХ 2014, х 442

THE CULTURAL WAY

хөөцөлдөөд байдаггүй араншингаар шинэ ном, шинэ хэвлэлийг номын дэлгүүрүүдээс ямар хурдан олж уншдаг бөгөөд тэр болгоныг шүүн тунгааж байдаг ажээ. Тэр захидалдаа зарим зүйлийн тухай ч чөлөөтэй, хуваалцаж байдаг аж.

... Би ойрын өдрүүдэд гарсан ном дахь М.Цэдэндоржийн “Галын амьсгал” үзэж их л чамлалаа. Одоо ч ер нь хүн бүхэн дэмийрч гүйцээ шив дээ. Цаадах чинь лав архины цагаан солио туссан байх аа!¹⁷

... Пүрэвдоржийн “Сэгс цагаан богд” сайхан нь сайхан боловч “Хөх даалимбан тэрлэг”-ийнхээ хаана ч хүрээгүй юм билээ. Харин тэр лениний тухай бодол нь бүр доор юм. Гэхдээ би Пүрэвдоржийг их тоодог. Тэр ч байтугай, гагцхүү уран санааны/оюуны/хулгай хийдэгт нь дургүй¹⁸.

... Чи Д.Урианхайн “Бид – дотоод шаталтын хөдөлгүүр” гэдэг найраглалыг үзээ биз дээ? миний хувьд энэ найраглал тун зөв, сайхан найраглал шиг санагдсан¹⁹.

... Октябрын 60 жилийн ойгоор “Гал морин цаг”-аа хэвлүүлэх буюу ядаж зөвшөөрүүлэх санаатай. Ингэхгүй бол, жирийн утга уянгын ямар ч сайн бүтээлээр би мэт нь хэвлэлийн хаалга татаж чадахгүй гэдгийг гүнзгий ойлголоо²⁰.

... Энд Л.Удвалын нэг шүлэг байна. Далдын хайр гэдэг шүлэг, энэ уг нь тун сайхан шүлэг болохоор юм аа. Гэтэл урлах арга барилын буюу хийцийн алдаа гаргасан тул ойлгомж муутай. Жирийн сул шүлэг болжээ²¹.

1969 оноос Р.Чойном мөрдөнд орж хилс ял сонссоноос хойш өөрийн зохиол бүтээлийн гол сэдэвлэхүүнээ аль болох социалист үзэл сурталд ойртуулах журмаар бичихийг хичээсэн нь буй. Үүнд түүний “Даланжаргалан”, “Гал морин цаг”, “Хүлэг”, “Хар цэцэг” гэхчилэн олон сайхан бүтээлүүдээ нийгэм цаг үетэй эрстүүлэн зөрчилдүүлэх биш, эе найрамдуу үзэл тийш дөхүүлэхийг зорьж бичиж байсан. Нэн адал явдлаар дүүрэн, алдартай “Гал морин цаг” нь лениний мэндэлсэн 100 жилийн ойд зориулан зөвлөлт монголын нөхөрсөг харилцааны хүрээнд их л хүч оруулан бичсэн монголын орчин үеийн яруу найргийн түүхэн дэх анхдагч сонет шүлэглэсэн роман билээ. Гэвч сүүлчээр 90-ээд онд сая

¹⁷ Б.Дамдинсүрэн. “Р.Чойномын шүлэг зохиолын хураангуй”, боть V, ӨМСХХ 2014, х 443

¹⁸ Б.Дамдинсүрэн. “Р.Чойномын шүлэг зохиолын хураангуй”, боть V, ӨМСХХ 2014, х 485

¹⁹ Б.Дамдинсүрэн. “Р.Чойномын шүлэг зохиолын хураангуй”, боть V, ӨМСХХ 2014, х 506

²⁰ Б.Дамдинсүрэн. “Р.Чойномын шүлэг зохиолын хураангуй”, боть V, ӨМСХХ 2014, х 525

²¹ Б.Дамдинсүрэн. “Р.Чойномын шүлэг зохиолын хураангуй”, боть V, ӨМСХХ 2014, х 544

THE CULTURAL WAY

угийн зохиолчдын хороон дарга байсан Д.Цэдэвийн маш урт удиртгал өмнөтгөлтэй хэвлэлийг хийхдээ олон зүйлийг тайлбарлаж байсныг бид юу андах билээ. Ямар нэг нөр хөдөлмөр зарцуулж ийм их өөрчлөлт хийж зохион бүтээж байсан ч түүнийг үхэн үхтэл нь нэг ч зохиолыг нь хэвлэж өгөөгүй, нийт арван тав зургаан жил монголын зохиолчдын эвлэлийн гишүүн болох өргөдөл өгсөн боловч хулчгар амин хувиа хичээсэн тухайн үеийн дарга эрх баригч нар түүний саналыг ерөөс тоож хэлэлцээгүйгээр ядуу тарчиг, ашиг орлогогүй, өвчин хуучны сав төдий болгож цагаан давааны энгэр тийш хөөн зайлуулж билээ.

Р.Чойном тухайн нийгэм цаг үе, төр засаг, хүн ардад гомдож шаналж явсан боловч уран бүтээлээ тасралтгүй бичихийн төлөө, хэчнээн олныг уншин үзэж, өөрийн ариун дархан яруу бүтээлдээ цагийн өнгөний хар тоос тортгийг өчүүхэн ч ойртуулалгүй явсаар байсныг түүний захидал илтэд өгүүлнэм!

... Нэгэн үедээ амжиж томоохон буюу зонхилох сэдвүүдээ зоригтой барьж авч өөрийн оргилыг бүтээх хэрэгтэй. Шүлэгч хүн шүлгийн урлахуй ухааныг ойлгох хүртэл өврийн дэвтрийн шүлэг хэлхэн эрэл дасгал хийж явдаг бөгөөд нэгэнт шүлэг бүтээж сурах сацуу өөрийн туйлын зорилго болсон гол номлол, хүссэн бүтээлээ туурвих хэрэгтэй. Эс тэгвэл оройтдог юм. Оройтсон хойно, оройгүй уул шиг хавтгай уран бүтээлч болоод өнгөрдөг.

Шүлэгч бүхэн шүлэглэх онгод (гал)-оо, хүүхэн бүхэн залуу сайхан царайгаа үүрд байх юм шиг санаж байдагтай адилхан, юу ч үгүй гэж бодож явтал нэг мэдэхэд дүү нарын үе эхэлчихсэн, өөрөө хоцрогдмол хэвшмэл шүлэгч болсон байдаг. Энэ явдал надад тохиолдсон. Намайг “Хүн” романыг хэлэлцүүлж байх 1963 онд нэг найз маань:

-Энэ бол чиний оргил байна. Би дотроо тун дургүй байсан. Шүлэгч болоод 3 жил болоогүй, шүлэг оролдоод 8 жил болж байсан цагт ид аархаж явав. Гэтэл одоо үзвэл би хэдийнээ хоцорсон хуучин шүлэгч болжээ. Оргил бол эхлээд дуусдаг бус, урт удаан оргил ч байдаг²².

*“-Орос монгол хэвшмэл үгийн словарь надад нэгийг авч тавиарай!
Би гараад хэрэглэх байх. Найз нь нэг “Хүлэг” гэж тууж бичлээ. Сая түүний үргэлжлэл болох “Хар цэцэг” тууж гэж бичсэн. Одоо тэдний*

²² Б.Дамдинсүрэн. “Р.Чойномын шүлэг зохиолын хураангуй”, боть V, ӨМСХХ 2014, х 414

THE CULTURAL WAY

дараагийн тууж болох “Одны шивнээ” гэж нэг юм бичих санаатай байна.

Үргэлжилсэн үгээр, цуврал 10 тууж бичих санаатай. Миний сайн санааг шүүх таслах хурал дээр өмгөөлөгч минь сүрхий мушгиж, хэзээ ч биелүүлж чадахгүй юм амлах дуртай, улаан солиотой этгээд гэсэн шүү юм яриад байна билээ.

Би 10 туужаа бичээд, амьд байвал өөрөө, үхвэл Хулан охиноороо тэр хүнд аваачиж барих болно. Ёндонгийн хэмжүүрээр Чойномыг хэмжиж болно гэж үү дээ”²³.

Ер нь тэр үес шүүн таслах хурал дээр Р.Чойномын өмгөөлөгч байсан өчүүхэн хуульч Ёндон нь өөрийн өмгөөлөх ёстой хүнээ өмгөөлөх нь байтугай, дандаа муулсан, хардан шинжилсэн, доош нь хийсэн үгээр “өмгөөлж” байсан бөгөөд ял тогтоох үед Р.Чойномд биш засаг төрийн талаас ялыг нь арай хугацааг нь нэмж уртасгасангүй нь болжээ! тэр цагийн хуульч ч гэж дээ намын төв хорооны заавар зарлигаас өчүүхэн ч гажуу зөрөхгүй дээдийн дээд шүтлэг болгосноос үнэн үг хэлэх, ёс мөрдөж хууль ярих эрхийг лав энэ Ёндон гэж хүн өчүүхэн ч мөрдөөгүй нь олон зүйл дээр илтэд гэрчилж болно. Иймээс Р.Чойном найдваргүй нөхдийн уршгаар хэрэгт татагдаж байхдаа ямар ч хүний дэм тусыг олоогүй олохын ч аргагүй байсан нь илэрхий гаслантай.

Тэрбээр монгол ард иргэний уламжлалт соёлын өвийг сэтгэлийн гүнээсээ хайрлан биширдэг бөгөөд яг л ардын аман зохиолын бэлэн цэцэн шүлэглэх ур чадварыг өөрийн яруу найраг тэрлэх арга барилдаа маш хүчтэй шингээж байдгийг манай уншигчид юу андах аж. Тэр уламжлалт соёлын аугаа гайхамшгийг бахархан дээдлэхээр барахгүй дэлхий дахины өрнө дахины туурвил зүйн уран яруу шүлэглэх зарчим – сонет шүлэглэх арга барилыг монголын орчин үеийн яруу найргийн хөрснөө маш эрчтэй авч ирэн туршаад амжилтыг олсон билээ. Аль тэртээ 1977 онд бичиж дуусгасан “Гал морин цаг” шүлэглэсэн сонет роман бол 365 ширхэг 14 мөрт сонетоор бүтээсэн 5110 мөр бүхий бүтээл нь бүр сүүлд 1992 онд сая хэвлэгдэн гарч уншигчдын хүртээл болсон байна. Энэ мэтчилэн Р.Чойномын яруу найрагт хийсэн дорвитой бүтээлүүд нь дандаа сүүлийн хорь гучин жилийн дараагаар сая албан ёсоор хэвлэгдэж

²³ Б.Дамдинсүрэн. “Р.Чойномын шүлэг зохиолын хураангуй”, боть V, ӨМСХХ 2014, х 443

THE CULTURAL WAY

цагаатгагдаж гарсан нь монголын яруу найргийн хөгжлийн түүхэн дэх нэгэн маш том доголдол алдаа болсныг гэрчилнэм!

Тэр ном зохиол уншихдаа, дандаа шинэчлэл өөрчлөлтийн талаас хардаг байсан, мөн дэлхий нийтэд үүсэж буй зарим үзэгдлүүдийг ч маш гярхай ажиглан ойлгохоор барахгүй эдгээр үзэгдлүүд нь хожмын манай хүн төрөлхтний соёл түүхэнд ямархуу хор хөнөөл болохуйц зүйлийг сониноор мэдэрч, Ш.Дулмаад бичсэн захидалдаа:

... Шивишиг! шивишигийн хажуугаар гуниг. Гуниг зөвхөн би биш, орчлон даяар ямар нэгэн үл мэдэгдэх гуниг юухан тархаж явах шиг санагдана.

Энэ гуниг анх энэтхэг орноос гарсан болов уу? яг хэл нь үл мэдэгдэх гомдол дүүрэн хэнгэрэгийн, зүрх мэт түгшээнийг дагаж, элэг зүрх шимирэх мэт уйлнам гинших бишигүүр болон элдэв шимирээн – ятга хөгжмүүдийн тааламжит, гунихрангуй аяс доор, эгэл амьдралын зовлон тоочиж, баяр цэнгээний доголтон нулимсийг, учрах хагацахын шарх амссан зүрхний нэрийн өмнөөс илтгэн дуулах ариухан атлаа гомдолт аялгууны хэсэг хэсэг тасархай ритмүүдийг бид амьсгал даран шохоорхож чагнадаг бус уу? энэтхэг орны эртний их ядуурлын ул мөр болсон аялгуу болон хөгжим дэлхийн бөмбөрцгийг 1908 оны Дүнгүстийн Кдастрофийн их долгион шиг, хоёр гурвантаа дуугарган доргиож, хүн төрөлхтөн тэр аяараа хөнгөн хөгжмийн түгшээнтэй агаад гуниглангуй аянд автжээ.

Энэ түгшүүртэй гуниг чинь, өнгөрсний гуниг юм уу, ирээдүйн гуниг юм уу бүү мэд. Оюун ухааны бясалган бодлоор биш, зүгээр адгуус амьтны зөнгөөр би заримдаа хүн төрөлхтөнд ямар нэгэн их гуниг түүж ирж байгаа юм даа гэж зүрх мэдрэхүйн үзүүрээр шимирэн ухаарнам. Нэг их уйлагнан түгших хөгжим, энэ их солгой үгийн үхмэл дуунууд чинь, нийт хүн төрөлхтний сэтгэл дотор нэг л эвгүй палхийгээд байгаа юм шиг бодлыг төрүүлэх юм. Газар хөдлөлт буюу их түймэр мэтийн зүйлийг зөгнөн мэдэрсэн ан гөрөөс цөм тав алдан үймж, хачин болдог шиг, өнөө цагийн урлаг тиймэрхүү аясад нэгэнт орчихжээ. ... Зуун жилийн дараа болох аюул, мянган жилийн дараа болох гай гамшиг цөм чи бидэнд хамаатай²⁴.

²⁴ Б.Дамдинсүрэн. “Р.Чойномын шүлэг зохиолын хураангуй”, боть V, ӨМСХХ 2014, х 448

THE CULTURAL WAY

Уран бүтээлч хүнийг уран зөнч билгийн мэдрэмжтэй гэж эрдэмтэд үздэг. Р.Чойномын хувьд манай дээдийн шүтээн болгон эрхэмлэдэг шалтгаан үрийн нарийн уялдаа бүхий, одоогийн үгээр бол логик зүйчлэнгүй ухаанаар ертөнц дэлхийн соёлын их хувьсгалын тухай маш гярхай ажиглаж дүгнэж байна.

Үнэндээ урлаг уран зохиолын өнөөдрийн хувьд авч үзсэн ч зарим зүйл – хип хоп эстрад хөгжим, үглээ дууны урлаг, модернист, поп модернист гэх мэтийн элдэв эсийн манай нүүдэлчин ард түмний сэтгэхүйд үл тохирох сонин хачин хэлбэрийн урлагийн төрөл зүйлүүд дэлгэрч байгааг бид маш хичээнгүйгээр судлан цэгнэх нь зүйтэй байх аа! аль тэр цагийн ганц худгийн шорон дотроос Р.Чойном анзааран мэдээд маш зөнтэйгээр дүгнэн ярьсан байхад өнөөдрийн бидний байж байгаа байдал уу. Урлагийн хөгжлийг зөв хүлээн үргэлжлүүлэх нь гүнээ бодууштай дасгал гүйцэтгэл болно шүү! та нар минь!

... Хүүе ээ Дося, чи байна шүү! М.Цэдэндоржид утсаар хэлээрэй. Миний хоёр ном, нэг нь хөдөө нэгдлийн тухай “Даланжаргалан” гэдэг шүлэглэсэн роман, нэг нь Расулын номын орчуулга “Кавказ хүүхэн” энэ дугаар нь 1974 оны төлөвлөгөөнд оруулж өгөхийг Чойном туйлаас гуйж байна гээрэй. За юу!

Би одоо Даланжаргалангаа уншаад сууж байна. “Хүн” гэж бичиж байсан тэр жилийн их шүлэгт номыг бодвол дээр болсон шив дээ. Үүнийг Чойном бичихээс өөр хүн бичихгүй юм. Юу гэвэл, миний багын нутаг энэ говь талын амьдрал, түүх, зан заншил хийгээд хүн зоныг тэр чигээр нь бичсэн юм²⁵.

... Би эдүгээ Лорд Байроны шүлгээс ганц хоёрыг орчуулж сууна. Гагцхүү орос монгол толь байхгүй жаахан хүндрэлтэй байна.

-Шоронд орсноор би наранд ер олдоогүй казах-орос словарь оллоо. Одоо Абайг авчруулж хэсэг оролдоно.

Өөрийн хувьд би, дэмий цаг алдахын оронд “Миний үзсэн хорвоо” гэдэг хувийн намтарчилсан тууж бичиж байна. Энэ бол миний хойчид хэрэгтэй юм. Түүн дээр, ухаан орсон үеэс хойш бүх л үйл явдлаа үнэн зөвөөр бичих зорилт тавьсан юм. Яах вэ дээ! тэртэй тэргүй л хүний тухай бичдэгээс хойш Чойном ч нэг хүн шүү дээ!²⁶

²⁵ Б.Дамдинсүрэн. “Р.Чойномын шүлэг зохиолын хураангуй”, боть V, ӨМСХХ 2014, х 461

²⁶ Б.Дамдинсүрэн. “Р.Чойномын шүлэг зохиолын хураангуй”, боть V, ӨМСХХ 2014, х 474

THE CULTURAL WAY

Р.Чойномын нэг гайхалтай зүйл нь тэр энэхүү хөндий харанхуй гяндан дотор өөрөө өөрийгөө аргадаж цагийг нөхцөөн хэзээ нэг гарах бол оо? гэж горьдлого тавин уйдаж бухимдан шаналах биш, харин цаг минут бүхнийг завдан тохиол олдог л юм бол бичиж уншиж, зурж сийлж л байдаг. Энэ бол зөвхөн Чойномд л байдаг тэсвэр тэвчээр бөгөөд алсдаа бас хүнд хэрэгтэй юм гэж уран бүтээлээ тасралтгүй тас бүдэг харанхуй өрөөнд, бас ажлын амралтаар бусдаас нууц хааж сая бичиж болдог нүх сүвийг алдалгүй ашиглан бичсээр байгаа нь үнэхээр хар тэргүүт хүн болсон бидний хувьд санахын ч аргагүй зориг юм шүү.

... Нэг баярлууштай зүйл гэвэл, сая 70 оны 12 сарын 7-д би нөгөө наранд байхдаа эхлээд явж байсан “Хүлэг” гэдэг хайртай туужаа дуусгалаа. Бүгд 11 бүлэг.

Эмили Жулиягийн “Мөнгө” хэмээх романыг энд сая л би уншиж дуусгалаа. Ёстой цус нь пижигнэсэн роман байна. Би халх голын тухай чиний явуулсан улаан ном, хурандаа Самданлог гэдэг монгол, орос, япон хэл мэддэг хүний бичсэн “Монгол зөвлөлтийн армиуд халх голд япоын түрэмгийлэгчдийг бут цохьсон нь” гэдэг ном, Д.Дамдиндоржийн “Ц.Шагдарсүрэн” гэдэг товхимол, жич П.Бадарчийн “Морьд” гэдэг номуудыг уншиж хэвтэнэ.

Халх голын дайны тухай “Үүнийг битгий мартаарай” хэмээх шүлэглэсэн тууж бичих санаа байх боловч чадах эсэхээ мэдэхгүй байна. Одоогоор 700 мөр шүлэг бичиж үзэж байна²⁷.

... Надад ойр зуурын маш хэрэгцээтэй байна. Үүний зарим нь:

1. “Айвгано” гэж Валдор Сэкүдтийн роман, монгол хэл дээр.

2. Сүүлийн үеийн шинэ сайхан ном юу юу байна?

3. Байроны шүлэг зохиолын ном англи хэл дээр байвал бүр сайн.

Би Байроноос орчуулж байгаа санаатай. Даанч зун цаг халуун болохоор ер дөхөхгүй юм.

Константин Фединий “Анхны баяр” гэдэг номыг олж явуулбал их сайн байна. Би “Гайхамшигт зун”-ыг нь уншиж байна. “Гал голомт”-ыг нь урьд уншсан билээ. Энэ 3 номыг нь маш сайн судалж унших хэрэгтэй байна.

Жич: Зүүнбаянгийн сургуулийн багш эмэгтэй А.Эрдэнэчимэгт гэсэн ямар нэгэн бичиг хотын сонины газраас танай тэрүүгээр ирвэл,

²⁷ Б.Дамдинсүрэн. “Р.Чойномын шүлэг зохиолын хураангуй”, боть V, ӨМСХХ 2014, х 477

THE CULTURAL WAY

түүнийг хүлээн авч надад сонирхуулаарай. Би тийм нэрээр шүлэг илгээсэн юм. Эмэгтэй хүн болж шүлэг бичиж үзье л дээ. Харин энэ нууцыг задруулж үл болно²⁸.

... Би одоо Константин Симоновын “Хал үзээж цэрэг болдог” гэсэн романыг уншиж сууна. Гайхалтай бус боловч тун сайн ном байна шүү²⁹.

... Танай сургуулийн багш Эрдэнэчимэгийн бичсэн “Андзол Девист бичсэн захидал” гэдэг найраглал “Намын үнэн” сонинд очиж байна гэнэ билээ. Овоо юм гэлцэнэ. Мөн утга зохиол сонинд түүний “Нарны шүлэг, сарны шүлэг, одны шүлэг” хэмээх 3 аятайхан шүлэг нь очсон гэсэн байна³⁰.

Ер нь Р.Чойномын нэрээр шүлэг зохиолыг нь нийтлэхгүй болсон тул заримдаа найрагч маань шүлгээ бусдад өгөх буюу бусдын нэрээр гаргадаг ч байсан. Энэ бол амь амьжирлалын хэцүү цагт хэдэн мөнгөний хувьд өөрт нь хаяа хоол залгуулах хэмжээний юм ч болдог байсан билээ.

“... Хөнгөн хөгжимд дуулж байгаа нүцгэн бүсгүй танаа” гэдэг найраглал бичив. Мөн “Амьдралд ам гарч болдоггүй” гэсэн томоохон хэмжээний шүлэг бичсэн. “Нутгийн шувуухай”, “Үүлс үрээлгэсэн түгшүүрт орой” гэсэн хоёр дуу хийв. Ая нь арай дуусаагүй дахин эргэж үзэх бодолтой байна.

Түүхийн судлал гэдэг товхимол боть олж үзлээ. Хүннү, Жужсан, Сяньби нарын тухай, монгол овогтны нэрийн тухай болон гарал үүслийн тухай дэлгэрэнгүй үзлээ. Дашдэндэв гуайн “Үүрийн цолмон” гэх романыг унших гэж үйлээ барлаа, больё оо.

Харин одоо би, зөвлөлтийн цэргийн тагнуулж эмэгтэй А.А.Кулешовагийн номыг орос хэл дээр уншиж байна. Их сайн ном юм.

Эртээд радиогоор нөгөө Ж.Доржийн нэг аятайхан шүлэглэсэн үлгэр бичсэнээ уншиж байна билээ. Би хэлээгүй юу! үлгэр шүлэглэх явдал манайд хамгийн чухал байна. Хүний мастерствог их нэмдэг шүү!³¹

... Башкирын ардын яруу найрагч Сайфи Күдэш гэдэг өвгөний шүлгийн бичсэн эмхэтгэл олоод, түүнийг монгол хэлнээ хөрвүүлэх гэж 8 дугаар сарыг авлаа. Нийт 97 шүлэглэлийн зүйл орсон уянгын бяцхан

²⁸ Б.Дамдинсүрэн. “Р.Чойномын шүлэг зохиолын хураангуй”, боть V, ӨМСХХ 2014, х 480

²⁹ Б.Дамдинсүрэн. “Р.Чойномын шүлэг зохиолын хураангуй”, боть V, ӨМСХХ 2014, х 484

³⁰ Б.Дамдинсүрэн. “Р.Чойномын шүлэг зохиолын хураангуй”, боть V, ӨМСХХ 2014, х 489

³¹ Б.Дамдинсүрэн. “Р.Чойномын шүлэг зохиолын хураангуй”, боть V, ӨМСХХ 2014, х 490

THE CULTURAL WAY

эмхэтгэл эдүгээ бүрэн монгол эх ноорог болоод байна. Энэ бол миний орос шүлэг орчуулах сургуулийн төдийгүй хэлбэр хөндөлгүйгээр зөв буулгах их сургууль болно.

Одоо би, Дажу.Байроны “Дон Жуан”-г монгол болгож сууна. ... Нийт 17 цоохор бүлгээс одоо би 9 дүгээр бүлгийг өчигдөх шөнө эхлээд явж байна. Дандаа октав хэмээх наймт шүлгээр бичсэн болохоор чөлөөт шүлгийг бодвол хэцүү дээ.

Эртний хэллэг, нэр томъёо ихтэй юм. Тэр нь ч яах вэ. Ер нь Байрон гэдэг аугаа их хүн байж дээ! өөрийн хувьд бол “Миний алаг нохойхон бодол болж байна уу даа” гэдэг уянгын шүлэг бичлээ³².

Энэ үеэр Р.Чойном нь нэгэнт шоронгоос суллагдан гарчээ. Тийм удаан хоригдол байсан хүн наранд гарна гэдэг хэчнээн жилийн мөрөөсөл болсон ахан дүүс буюу орон нутгуудаар хүрч нэгэн зэрэг энгийн хүний амьдралд шумбасан нь мэдээж! Р.Чойномыг дайлах, угтан авах, шүлгийг нь сонсохоос өгсүүлээд нэлээд ширүүн архидалт нөхөр ёсны найрсаг ширээнүүдээр пажигнасан нь ч ойлгомжтой. Тэгж дуусаад манай хүний орогнон суух гэр байшингаас өгсүүлэн алдаж орхисон ном эд зүйлс бүтээлүүдийг амжуулах мөн хараа хяналт доор эрх чөлөөтэй биш бас л нутаг заагдан зөвхөн хэнтий аймгийн цөөн хэдэн суманд аж төрж амь зуух байдалтай байхыг цагдан сэргийлэхээс, шүүхээс дахин сануулж чангалж байснаас нутагтаа байхыг зорьж юм хумаа чирсээр очжээ. Энэ дундаа тэр ном унших, орчуулах, үргэлжлүүлэн зохион бичих, цэгцлэх, хэвлэлийн газраас гуйх ажлаа хийсээр явжээ. Үүнийг тэр өөрөө дэмий дотносож байж засагт алгадуулчихсан чинь, ёстой “дэмий тэнэтлээ алгадууллаа, одоо бүр хаширлаа” хэмээн тэмдэглэн үлдээсэн нь буй.

... Расул Гамзатовын шүлгийн түүврийг иж бүрэн орчуулж дуусган ихэнхийг нь сийрүүлэн цэвэр цаасан дээр хууллаа. Мөн эндхийн номын сангаас “Соускдскаса Истүризуская (Назкалпүдит)” гэдэг сайхан ном олж, 9 ботийг нь үзэж, хэрэгтэйгээ түүн товчилж авлаа. Бас Борис Кукнилова, Васили Хэмест гэдэг оросын хоёр лут шүлэгчийн ботиудыг судлав.

Энд ирээд 50 орчим шүлэг, нэг найраглал бичлээ. Найраглалыг минь ирэх зуунд хэвлэнэ биз. ... Сая Ринчин гуайн “Сандо амбан”, Белявей-ийн “Последие человек из атлантиди” гэдэг роман, “Кохт

³² Б.Дамдинсүрэн. “Р.Чойномын шүлэг зохиолын хураангуй”, боть V, ӨМСХХ 2014, х 491

THE CULTURAL WAY

гасит сейд” гэдэг кино сценар, Юрий Бандорей-ийн “Халуун цус” роман, Б.Нямаагийн “Арандал” романыг тус тус амтархан уншив.

Халуун цус гэх роман, нүгэлтэй сайхан бичигдсэн юм байна.

Би нэг кино сценар эхлээд байна. “Өнгөрсөн шөнө зүүдэнд юу ороо вэ?” гэдэг нэртэй. Энэ өвөл асперанто хэл оролдох санаатай. Энэ өвөл би “Даланжаргалан”-аа сийрүүлэн, хуулж, нэмэлт засвар хийгээд “амь оруулна” ирэх жил хэвлэлд өгнө гэсэн. Мөн “Учиг зүүд” хэмээх роман, үргэлжилсэн үгээр эхлэх санаа байна. Атвизм роман юм.

Васили Хэмүнски гэдэг хүний бичсэн “Степа разин”-ий тухай сонирхолтой сайхан найраглал би урьд өмнө сонсоогүй шиг санагдана. Жинхэн галзуу дайчин хийгээд үгээр тоглож чадсан, өнгө аясыг нь дүрслэн үлдээж чадсан лут найраглал! орос үгэн хөгжим юм байна³³.

Ринчин гуайн “Гүнж” орос хэл дээр хэвлэгдсэн нь маш сайхан болжээ. Энд гарч байхад нь нэгийг олж авлаа. Расул Гамзатовын “Беректи друзья” гэдэг ар хавтсандаа пянзтай гоё ном олж авлаа. Сергей Ясунин-ий “Шүлэг найраглал” гэсэн гоё номыг авав. Равжаа хутагтын эмхэтгэлийг айлаас дэлсэв. Бас өөрийнхөө “Хүн” романыг нэг айлаас туугаад авч байсан чинь хүн надаас туучив. ... Монголын цахилгаан мэдээний дарга байсан Зундуй гуай надад орос номын сангаа тэр чигээр нь өгсөн. ... Расул Гамзатовыг орчуулаад ирсэн. 6800 мөр шүлэгтэй ном болсон. Одоо хэвлэлд өгч магадгүй.

Алишор (Навой)-ийн “Фэрхэд Ширин хоёр” гэдэг алдарт найраглалыг ирэх жилээс орчуулах санаа байна. ... Хот чинь тун тоогүй газар болжээ. Архичин мэхчин хоёр нь будаа мэт өсөж байна. Мөнгө ховор юм үнэтэй, хүмүүс нь чанар муутай, ийм л газар байна.

Хөдөө гэдэг чинь жаргалын орон юм байна. Ном хэвлэл элбэгтэй бол тэгээд уйдах аюул байхгүй. 1974 онд би гадаад хэвлэл 361 төгрөгөөр захиалсан, орос, украин, казах, буриад зэрэг хэл дээр олон сайхан сэтгүүл сонин авч уншина. Миний жаргал тэр!

1975 оны хэвлэлийн төлөвлөгөөнд миний ном орох болсон. Наана нь орчуулга л гарах байх. Энэ өвөл би “Алмасын тухай” роман бичих боллоо. Дамдин өвгөнтэй хамтарсан нэрээр гаргана. Алмасын тухай бүх материал миний гар дээр ирлээ. Би бичгийн машин олж авлаа. Гол ололт минь энэ дээ!³⁴

³³ Б.Дамдинсүрэн. “Р.Чойномын шүлэг зохиолын хураангуй”, боть V, ӨМСХХ 2014, х 502-503

³⁴ Б.Дамдинсүрэн. “Р.Чойномын шүлэг зохиолын хураангуй”, боть V, ӨМСХХ 2014, х 501-504

THE CULTURAL WAY

Р.Чойномын хэвлэл захиалж байгаа, ном шинэ хэвлэлүүд худалдан авч байгаа тэр тусмаа гадаад хэлний номыг хэрхэн уншиж орчуулж байгаа, мөн өөрийн зохиол бүтээлээ туурвиж буй зүйл түүний дараачийн хийх бүтээлүүдээ хэр зэрэг төлөвлөн боловсруулж төлөвлөгөө хийж байгаагаас тэрбээр үнэхээр энгийн хүний сэтгэхүйгээс давсан нөр их зохион байгуулалтаар төсөв хийж бичиж орчуулж буй зүйл нь хэчнээн их байгаа бол оо. Ёстой л Т.Галсан гуайн хэлснээр “Р.Чойномын хувьд мөнгө бол: Эд хөрөнгө, үнэт зүйлс бус сэтгэлийн буртагаа угаахад хэрэглэх барааны саван төдий зүйл байжээ. Өөрөөр хэлбэл Чойном мөнгийг солгой гарынхаа чигчий хураагаар олдог. Гарынхаа салаагаар асгадаг, тэр хэрээрээ гачигдахын эргүүлэгт үе үе тийчилдэг байсныг нөхдийнх нь дурсамжаас би гадарлана”³⁵.

Хэрэв Чойном зураг зураад – сийлбэр сийлээд, баримал цуггаад олсон мөнгөөрөө нэг өрөө байр худалдан авна гэвэл хэр хэмжээний тансаг өргөө олчих л байсан. Гэхдээ тэр маань тэгж тансаглаагүй. Тэгж тансаглах зугаа түүнд байгаа ч үгүй. Яг л тийм заяаны мөрөөр найрагч маань монголын зүүн бүсийн нутгуудаар тэнүүчлэн амьдарч, монголын өвөг дээдсийн эртний бөгөөд энгийн цэцэн мэргэн үг үгсийн эрчээр монгол шүлгийнхээ ур ухааныг сийлж явсан байжээ. Их юмны төлөө зорьж явагчийн замд тортог тоос, бүдрэх чулуу угаасаа зоолттой байдаг нь хувь заяаных ч юм уу! урьдаас бодож төлөвлөх, түүнийгээ байн байн цаг нөхцлийн өнгөнд боловсруулж цэгцлэх нь их чухал байдаг. Хэдий нугачаа бүдчээний дунд хэв журмаа алдсан байдалд өдөр хоногуудыг өнгөрөөж буй мэт Чойномын амьдралыг ажиглаад байхад, тэрбээр нөхөд найз аль байсан ахан дүүстэйгээ архидан наргиж байдаг боловч уран бүтээл туурвих үндсэн чигээ ерөөс умартаагүй, тэр эрчээрээ олонтоо тунгаан боловсруулж бичсээр л явсан байнам!

... Нөхөр Алтанбаатартай хамтарч 1968 онд гараас гаргасан, нисэхийн тухай шүлэглэсэн баримтат туужаа жаахан додомдож байгаад дуусгажээ. Одоо нэг удалгүй Дамдин гуайтай нэр хавсарч гаргах, алмасын тухай сэдэвтэй “Алтайн савдаг” хэмээх сүрт романаа барих санаатай. Энэ роман минь үргэлжилсэн үг дээр бичигдэж, эрдэм шинжилгээний зөн сэтгэмжийн роман болно. ... Дэргэд минь бичгийн хэрэглэл, хайрт номууд минь л байвал боллоо гэж санагдаад байх болжээ.

³⁵ Б.Дамдинсүрэн. “Р.Чойномын шүлэг зохиолын хураангуй”, боть V, ӨМСХХ 2014, х 471

THE CULTURAL WAY

Харин сүүлчийн өдрийг хүртэл юмаа хийх болно. Хожим “(авгай) д биш үү гэсэн уран бүтээлд үнэнч явсан хүн энэ доор амарч буй” гэсэн бичиг, миний толгой дээр тохойхон цементэнд сийлж байвал болоо!

Биеийн үхэл бол зайлиггүй бөгөөд тэгэхдээ аймшигтай буюу гутамшигтай зүйл биш, харин зориг эрмэлзлийн үхэл бол хамгийн гутамшигтай үхэл мөн³⁶.

-Монгол ардын урт богино бүх дууны дотор гардаг хүний нэрүүдийг бүртгэн сурвалжилж, түүнд шинжилгээ хийж, гарал домгийг чадвал бүрэлдүүлж, дэлгэрэнгүй тайлбар хийж хэвлүүлэх хэрэгтэй! энэ бол судлалын ямар ч гар хүрээгүй атар юм. Энэ тавдугаар таван жилийн төлөвлөгөөнд атар эзэмших тухай шийдвэр гарсан шүү дээ! атар гэдэг зөвхөн газрын нэр биш юм!

Ардын дуунд монгол түмний түүх, бүхийл цаг хугацаагаараа агуулагдсан байдаг биз ээ. Харин ойроос радиогоор зарим дуунд домог зохиож нэвтрүүлж байгаа нь сайн зүйл боловч ихэнх нь дуун доторх газар ус, хүний нэрийн онцлогийг үл анзаарсан худал хуурмаг домог бүтээсэн нь үзэгдэж байдаг. Жишээлбэл Юндэн гөөгөө болно³⁷.

Урлагийн үйлсэд үнэн зүрхнээсээ шулуудан орсон юм бол зөвхөн яруу найраг гэлтгүй, бүхийл салаа мөчир, төрөл зүйл, стильд нь гүнзгийрч орж байж, сэтгэхүйгээ тэлж чаддаг гэдгийг Чойномын захидал бас ч гэрчилж буй:

... Кино зохиол оролдсоноос Гомбо нэлээд үр дүнтэй яваа шүү дээ! залуухан буриад билээ. Овоо.

Дуурь бичих зохиолч их ховор байна. Дуурийн театрын амьдралтай бага сага танилцаж, түүгээр орж гарч явбал, дуурийн цомнол, бүжгэн жүжгийн (балетийн) либертид романс дуу, харилцаа дуу зэрэг зохиолоор их гачигдаж байдаг юм байна.

Драмын жүжиг ч гэсэн дээ! их л хэрэгтэй юм. хамгийн хэрэгцээ багатай зохиол бол орчин үеийн муу сайн шүлэг найраглал юм шив дээ!³⁸

³⁶ Б.Дамдинсүрэн. “Р.Чойномын шүлэг зохиолын хураангуй”, боть V, ӨМСХХ 2014, х 509

³⁷ Б.Дамдинсүрэн. “Р.Чойномын шүлэг зохиолын хураангуй”, боть V, ӨМСХХ 2014, х 516

³⁸ Б.Дамдинсүрэн. “Р.Чойномын шүлэг зохиолын хураангуй”, боть V, ӨМСХХ 2014, х 507

THE CULTURAL WAY

Гурав. “Р.Чойномын зүрхний шивнээс тархины бичээс амь зуулгын нууц”

Р.Чойномын өвийг хамгаалах “Өд” сангийн мэдээлснээр, дараагийн цувралдаа “Р.Чойномын нууц захидлууд”-ын хоёрдугаар дэвтэрт Чойномоос бусдад, бусдаас Чойномд бичсэн захидлуудыг хэвлэнэ гэсэн байх юм. Энэ бол Р.Чойномын дотоод ертөнцийг улам нэг алхам тодруулж гаргах охь булаг мөн буюу хэмээн миний бие үзэж байна. Бид Р.Чойномыг оршуулаад 10 хэдэн жил болсны дараа сая тэрхүү ертөнцийг анхлан ойлгож эхэлсэн билээ. Он жил улиран холдож байна. Цагийн юм цагтаа маш их хэрэгцээтэй байдаг ч бидний алдас, цаг төрийн доголдол, бүх нийгэм нийтээрээ будилснаас бид олон зүйлийг алдаж байсан нь үнэн!

Энд “Мөнх зул”, “Нууц захидал”-уудыг уншиж суухад хэчнээн их зүйлийг бид сурч ойлгож хүртээмж болгож байхаар барахгүй, тэр үеийн хүн зоны мөс чанарыг ч ил дэлгэн уншиж байна. Энэ хоёр хүнд найрагч маань өдий их зүйлийг ярьж байна гэдэг зөвхөн хувь хүний хоорондох захиа чимээ биш, бүх хүмүүст хамаарах олон сайхан илч энергитэй сэтгэлийн гүн догдлол, цээжний гүн сургамжууд тодхон үлджээ.

Р.Чойном нь уран зохиол туурвихыг бүх насныхаа утга агуулга хэмээн ухаарч, олон ч нөхөдтэй бичиж, ихэнхийг нь дурсан санагалзаж байсны дотор яруу найрагч Ш.Дулмаад онцын хүндэтгэлтэй хандаж байсан нь тэр үеийн зохиолчдын дотор ганц тооны бүсгүй зохиолчийн авьяасыг тоосноос гадна, сэтгэлийн гүнээсээ явж болох андын журамтан хэмээн үзсэн нь ойлгомжтой. Зарим хүмүүс буюу шуурагчид Чойном болон Дулмаагийн тухай буруу ташаа ойлголттой байсан байж мэднэ.

Хэдэн сарын өмнө миний бие ӨМИС-ийн Монгол Судлалын Дээд Сургуульд албан ёсны яриа илтгэл “Яруу найрагч Ринчиний Чойномыг захидал чимээнээс нь ойлгохуй” гэсэн сэдвээр хийсэн юм. Харин өчигдөр нэг найз надад – Чойном Ш.Дулмаа хоёроос нэг хүү бий гэж хүмүүс вичат/wechat/ тавцан дээр ярьж байна. Хэн хэлж байна? гэж асуухаар, чамайг илтгэлдээ ярьсан гэж байна гэх юм.

Би бүр балмагдлаа. Юу вэ? яагаад ингэж байгаа юм бэ? гэхлээр нэг бүсгүй вичатаар манай найзад:

Ш.Дулмаагийн “Хүүгийн эцэгт бичсэн захидал” шүлэг болоод Р.Чойномын “Хүүгийн ээжид бөхийн хэлэх үгс” шүлгүүдийн зургийг дараад цугт нь явуулсан байх юм аа! юу! юу! энэ бол эндүүрэл шүү!

THE CULTURAL WAY

миний илтгэлийн бичлэг нь тэр хэвээр олон нийтийн сүлжээнд одоо ч гэсэн дуу хоолойтойгоо байж байгаа шүү! яасан юмны учрыг ойлгодоггүй нөхөд вэ? энэ бол тухайн үеийн гэр бүлийн салалт, хүүхдүүдийн өнчрөл, залуу бүсгүйн дахин гэрлэлт зэрэгт хор хөнөөл авч ирж буй үзэгдлийг олон хүүхнүүд Ш.Дулмаад утасдаж энэ тухай нийгэм нийтэд нөлөө гаргахуйц хэмжээнд шүлэглэн шүүмжилж өгөгч гэсэн гуйлтын дагуу бичигдсэн шүлэг шүү! мөн Р.Чойномын бичиж байгаа шүлэг нь тэдгээр олон аавыг орлож осол буруу хүлээж бичсэн шүлэг шүү! хэмээн маш тодорхой тайлбарлаж байгаа шүү! энэ нөхөр зөвхөн шүлгүүдийг үзээд миний яриаг сонсоогүйгээс болсон хөгөө тарьсан инээдтэй явдал болж шүү!

Энэ бол эгэл нэгэн сонирхогчийн жижигхэн алдаа юм шүү! үүнээс илүү эндүүрэл бүү л гаргаарай хэмээн сануулж нэг зүйлийг товчхон хэлье.

1997 онд “Чойном судлал жич түүний шүлгүүд” номоо хэвлүүлчихээд доктор цол хамгаалах урьдчилсан ажлуудаа цэгцэлж байх үеэр Ш.Дулмаа эгчийн гэрт нь хүрч тусгай сурвалжилга хийсэн билээ. Тэгэхэд Дулмаа эгч маш сайхан яриа өрнүүлж, миний эргэлзэж асуусан асуулт болгонд хангалуун хариулт өгч надад судалгааны улам эрч зориг өгсөн юм. Дулмаа эгч халуун бууз шил архи задалж Б.Түвшинжаргал бид гурав олон зүйл ярилцан хооллов. Тэдгээр захидлуудыг тэр л үед би олзуурхан уншиж зармыг нь тэмдэглэн авсан зүйл буй. Тэгээд миний бие яаж ч болсонгүй нэгэн асуултыг асуусан юм.

-Чойном та хоёрын харилцаанаас үзээд байхад хоорондоо дурлалцсан зүйл нэлээд ажиглагдана. Энэ талаар яг үнэнээ дэлгээд өгнө үү?

Ш.Дулмаа эгч сүрхий инээж байснаа:

Чойном бол үнэхээр журмыг эрхэмлэдэг сайн хүн, хэдийгээр хэдэн удаагийн гэрлэлт нь бүтэлгүйтсэнээс түүний амраг хайрын амьдрал тэгсгээд дууссан л даа! харин энэ дундаас Нинадаа үнэхээр хайртай байсныг нь би сайн мэднэ. Бид хоёрын нөхөрлөл бол цэвэр уран бүтээлийн төлөөх андын журамтай! энэ бол хэзээ ч хаана ч хэлсэн ариун нандин нөхөрлөл гэдгээ би батлан хэлэх байна гэв.

Үнэхээр мундаг юм аа! манай өмнөх үеийн ийм сайн сайхан хүмүүсийн ул мөр өнөөгийн та бидэнд хэчнээн өвлөж нандигнамаар

THE CULTURAL WAY

сургаал аж! энэ тухай Чойном Ш.Дулмаад бичсэн захидалдаа ч үнэнийг тэмдэглэн үлдээсэн нь байдаг.

... Аяа хүмүүс минь, миний бичигдээгүй номуудын гол баатрын шүүмжлэгч, уншигчид минь, магтан хөөргөх хараан зүхэх олон түмэн минь, та бүхэн аяс нь олдохгүй олон өнгийн таавар, хэзээ ч уншиж барагдахгүй шидэт амьд номууд юм уу даа!

Миний хүндэт Дося! Энэ ертөнцөд огт танилцаагүй байхаас нэг л дургүй хүргэх шиг санагддаг хачин байдалтай хүн байдаг. Түүнчлэн эхлээд зүс танихаас, нэг л их хүн шиг санагддаг сэтгэл зүрхэн дотор битүүхэн биширэх сэтгэл төрүүлсэн хүн бас байдаг. Тийм хүний юм бүхэн нь аятайхан санагддаг, алдаа нь хүртэл сэтгэлд дотно, гаж буруу ааш гаргах нь хүртэл аятайхан ч юм шиг, ер юм бүхнийг нь уучлан хүлцмээр санагддаг байна.

Миний хувьд чи тийм хүн юм. Би олон хүнтэй найзалдаг боловч тэр бүрийг хайрлан биширэх нь ховор. Харин биширэн бахдаж, хайрлан санадаг цөөн хүн нь намайг гэх нь бас ховор байдаг юм. Энэ бол хорвоогийн жам тогтоол юм хойно харанхуй хөрсөн доорх үндэс, модыг их бие өөдөө зүглүүлж хамаг шим шүүсээ өгч байхад их бие нь мөчир лүгээ, мөчир нь найлзуур нахиа лугаа, нахиа нь навч цэцэг лүгээ, навч цэцэг нь тэнгэр, нар өөд тэмүүлэх жишээтэй. Тэгэхээр бас хаа нэгэн газар намайг хүсэн биширч, надад ойртон үл чадан хий мөрөөсөж байдаг хүн ч байхыг хэн байг гэх вэ. Харин олон буй гэвэл биеэ хэцүү муухай тоосон хүн болно.

Хүмүүс нэг нь нөгөөгөө хүсэж, нөгөө нь цаашаа өөр нэгийг гэж нэгэн насныхаа залуу зандан үед муур хулгана шиг тоглож байгаа мэт хөөцөлдсөөр олж барихаасаа хоцорч гуниглах нь илүү өнгөрдөг байна. Хэрэв чи бид хоёр эрэгтэй эмэгтэй хоёр хүний биологийн жам дагаж нийлэх ёстой байсан бол аль 1962 оны хавар – зунаар хэн хэн нь чөлөөтэй, хээрийн гөрөөс шиг явах цагтаас дураар нийлэх байсан биз дээ? гэтэл огт тэгээгүй ... тэгэх ч хэрэггүй байсан. Биологийн харьцаа хүнийг сайн юманд хэзээ ч хүргэж байсан түүхгүй билээ.

Энгийн танихгүй байхад, хиртэй гараар ч хүрэмгүй, гайхамшигийн сайхан хүн харагдаж, түүнд бүх сэтгэд зүрхээрээ сөхрөн биширч байдаг бол тэр хүнтэйгээ нэгэнт дасаж өвөр зөрүүлэн хамаг нууцад нь нэвтэрч ханасан хойно хээ яа үгүй байдаг л нэг өчүүхэн хүн, гарын доорх амьтан буюу өдий төдий сул муу талтай, яаж ч загнаж нухалж байсан

THE CULTURAL WAY

*хамаагүй, үнэ цэнэгүй амьтан болж хувирдаг. Энэ бол хамгийн муухай зүйл болох юм. Би хамгийн сайхан хүнээ гэр бүлийн явцуу хүрээлэнд барьж авч нийцүүлэх юмсан гэж боддоггүй*³⁹.

Ямар мундаг үзэл санаа буй. 20 дугаар зуунд монголын говь нутагт үнэхээр нэгэн хутагт хувилгаан гэмээр аугаа багтаамжит түүх оршин амьдарч байсныг бишрэн сүжрэхгүй байхын аргагүй. “Суут хүмүүс захиа их бичдэг араншинтай нь тэд ард түмэн лүгээ амин холбоотой, тэдэнд ч хүн зон сэтгэлийн сүүгээ аягалж байдаг нь баримт бололтой” хэмээн Т.Галсан гуай дурссан нь буй.

Р.Чойномын 37 захиа эзнээ нартаас буцсан 25 жилийн дараа уншигчдад хүрсэн нь түүний энэхүү захиан дотор Чулуунбазар хэмээх дүүгээ хүний ертөнцийн мянга түмэн үйл лайнаас аль болох ятган сургах “түүнийг архины дон, авгайн дон, алдрын нянгаас авран хамгаалсан, нэгэн ач гавьяатан байсан” хэмээжээ.

Өөрийн өнгөрүүлсэн амьдрал, алдсан алдааны сургамжаа ганц дүү (хүү) Чулуунбазартаа бус түг түмэн хойч үеийн залууст тусахуйц ухаанаар гийгүүлэн номлосныг өнөөгийн манай залуу багачууд нь ойлгон хүмүүжиж, өтөл буурал нь уухайлан дэмжмээр нандин сургаал юм.

... Айл гэр болж, амар төвшин аж төрж, насныхаа галтайд дууг нь хожим чагнаж явах үртэй болох хэрэгтэй. Эхнэрийг авахдаа шилсэнээс, авсан хойноо зөв ханилж, амьдрал болгон өөрийн биеэр хүмүүжүүлсэн нь илүү ашигтай юм уу гэж би боддог. Ханилахын өмнө шилээд шилээд сайн авгай олж авч байгаа хүнийг би лав үзээгүй.

Хоолыг амсаж мэдэхээс биш, харж мэдэхийн аргагүй шүү дээ! харин нэгэнт амссан хоолоо асгаж цутгалгүй, бас дэндүү гологдолгүй гудрах хэрэгтэй. Гэхдээ, хоолны хордлого болж үхсэн хүн ч дуулддаг л даа! энэ нь тун ховор тохиолдол.

Хүүхнийг ер сонгож авах нь зүй. Тэгэхдээ өөрөө бас хүүхэнд сонгогдох ёстойгоо мартаж болохгүй шүү. Хүн бүхэн, завхай буюу утас үйлэнд муу гэх мэтийн гол дутагдал тоолж, тиймгүй хүүхнийг сайн гэх бололтой байдаг. Миний хувьд утас үйлэнд муу гэдэг маань орчин үеийн нэгэн гол нийтлэг чанар, завхай гэдэг маань хоёрдугаар авьяас юм гэж

³⁹ Б.Дамдинсүрэн. “Р.Чойномын шүлэг зохиолын хураангуй”, боть V, ӨМСХХ 2014, х 448-449

THE CULTURAL WAY

бодлоо. Ер нь завхай хүнд би муугүй шив дээ. Хүнд сайн, цагаан, хөнгөн хүн л завхай санагддаг юм.

Харин мань мэтийн бичгийн үйлтэй хүмүүст дэндүү харанхуй хүн л бүү таараасай л гэж залбиран бас дэндүү харгис хатуу юм уу, гэр ахуйн ажилгүй амьтан л хамгийн дэмий юм чинь тэр гэж би боддог. Энд би зөвхөн, хайрт дүү чамтай жаахан ярихын хүсэл болж л энэ мэтийг бичлээ.

Түүнээс биш чиний хань болох учиртай тэр хүнд энэ бичиг ер хамаагүй. Яагаад гэвэл, чи өдийд аль хэдийн шийдчихсэн байгаа л даа.

Харин миний зүгээс та хоёрт сайн сайхныг хүсэн ерөөж, хожим намайг шоронгоос гармагц салгалж очихын цагт жинхэнэ монгол таван ширхэг бууз, нэг “нийслэл” архи өгч, сайн аашийг минь хөдөлгөж байгаад жаал буруулаарай. Би бурж өгнө өө⁴⁰.

... Нөгөө талаар 10000 мөртэй шүлэглэсэн роман гэгч ямар их хүч энерги шаардагдахыг би сайн мэдэж байна. Иймд, улсын өмнө хариуцсан ажил мэргэжлээ сулруулж, хүн амьтанд муу хэлэгдүүзэй! энэ шүлэг гэгч зүйл бол хүний сэтгэлийг хүүхнээс илүү эзэмддэг тул болгоомжтой хандахгүй бол болохгүй.

Дүү чиний уран бүтээлийн зөвхөн нэрийг нь сонсоход нэгэн зүйл таатай – яруу шүлэгч төрж, чухам тийм чиглэлийн тийм бүтээл болов уу гэсэн таамаглал ургаж байна. Гэхдээ энэ бүгдэд миний хориод нас яг хэвээрээ амтагдах шиг болж, би айлаа. Учир нь би тэр үед хэтэрхий халуун сэтгэлтэй явж, тийм халуун сэтгэл өөрийгөө түлж магадгүй байдгийг бодоогүй билээ⁴¹.

... Хүний яриаг элдвээр ашиглах амьтас захаас аваад олон болсон үе. Үгүй ядахнаа ганц үг ч гэсэн яаж ийгээд миний дайсан болох улсын сонорт хүрнэ. Иймд “дуугүй явах нь бүхнээс чухал” гэж эртний арабын их мэргэдийн сургаалийг дагахад илүүдэхгүй. Энэ далимд, Чулуунбазар чамд сануулах нь, согтсон цагтаа миний тухай, миний шүлгийн тухай хэнд ч гэсэн тэгж үр ашиггүй магтах буюу дүгнэн ярих хэрэггүй. Хэн ч дуртай байхгүй нь мэдээж. Бас хэний ч сонорт хүрч, юугаар ч буруу эргэж байж болно. Эцэст нь чамд, нялх балчир хүүхдүүдэд чинь гай тарьж, үгүй ядахдаа цалингаас чинь салгавал яана? улс төрийн талаар гэмт хэрэгт шийтгэгдэж байсан этгээдийг магтах буюу дурсан ярих

⁴⁰ Б.Дамдинсүрэн. “Р.Чойномын шүлэг зохиолын хураангуй”, боть V, ӨМСХХ 2014, х 477

⁴¹ Б.Дамдинсүрэн. “Р.Чойномын шүлэг зохиолын хураангуй”, боть V, ӨМСХХ 2014, х 486

THE CULTURAL WAY

*гэдэг уг чанар ямар их хортой гүн хүнд (сүрхий) болохыг чи эрүүлдээ сайн бодох хэрэгтэй. Эцэстээ өөр хэн ч биш, чи бид л хохирно. Очирхуяг бол яг л чам шиг намайг магтаж, согтуудаа хаширч явсан гэдгийг мартаж болохгүй. Энэ бол серёзны асуудал шүү!*⁴²

Амьдрал дундаа ид хоёул олон зүйлийг нөхөж явжээ. Ах буюу багшийн хувиас Чойном нь дүүдээ маш олон ээдрээтэй нийгмийн асуудлуудыг нэг нэгээр тайлбар жишээтэйгээр нь өгүүлэн бичиж зориуд сургасан буй. Ийм ч учраас говь нутгийн сэхээтэн хүү социалистын тэрхүү хар бараан сүүдэрт булагдан ороогүй өнөөг хүртэл хүүхдийн сайн багш, ач үрийн түшиг тулгуур нь болсон сайн өв болж үлджээ.

Мөн энэ олон захидлын дотор хэчнээн олон амь амьдрал, жижиг сажиг зүйлээс оюун санааны унд болохуйц ном судруудыг дүү хүү нь яаж ийж байгаад олж аван ахдаа ойртуулан өгдөг байсан нь тухайн үеийн мөнгө чухаг, амьдрал тарчиг байсан үед ямар их сэтгэлийг гарган шоронгийн хадаас болсон ахыгаа итгэл сэтгэлийн эрчээр тэтгэн тохинуулж байсан билээ! Р.Чойном найрагч бол найз нөхөд үнэхээр олонтой гэх нэрийн доор явах боловч үнэндээ түүнд гүнээ нөхөрлөн тусалдаг хүн нь гарын таван хуруунд багтан тоологдох тийм л хэдхэн хүмүүс байдаг юм шүү!

Чойном тэр хэдэн нөхдөө олон мянган нүүр буруулагчийн дундаас онож, сонгож чаджээ. Энэ талаараа тэр үнэхээрийн содон шилдэг сонголтыг хийж чаддаг зөнч мэргэн хүн юм! ямар ч төрөл жанраар зохиол бичнэ гэхэд, үг хэлний учир начрыг маш сайн тунгааж ойлгохын тулд Чойном минь олон зүйл дээр эрэл хайгуул хийж тайлбар хийж байжээ. Энэ бол шүлэг зохиолын үг хэлний үндэс гарвалыг хэр зэрэг эргэцүүлэн тунгаасан нь доорх жишээнд буй.

... Нууц товчоонд “Өлүг тасын сохог ус гэдэг газар” гэж гарч байдаг. Чингис, найманчуудтай байлдсан бүлэгт буй!

Тэр Өлүг тас гэдэг бол “Үхсэн уул” гэдэг нэртэй уул гэжээ. Өлүг гэдэг нь үхсэн, хүүр, сөнөсөн гэсэн түрэг үг ажээ. Одоо хасагууд нас барсан гэхийг “үлек белсын” гэж хэлдэг. Мөн эд өлгийн зүйл гэдэг нь эд ба хүүрийн (бие) зүйл гэжээ. Үлэг хүрвэл гэдэг мөн сөнөсөн гүрвэл буюу үхсэн гүрвэл гэсэн утга байна⁴³.

⁴² Б.Дамдинсүрэн. “Р.Чойномын шүлэг зохиолын хураангуй”, боть V, ӨМСХХ 2014, х 530

⁴³ Б.Дамдинсүрэн. “Р.Чойномын шүлэг зохиолын хураангуй”, боть V, ӨМСХХ 2014, х 532

THE CULTURAL WAY

... Гавьяа гэдэн үг, уг нь габига гэсэн үг биз дээ? нэг сонин таамаглал хэлье, миний “Хүн” романд “Хүнхээр аймгийн дурсгал болсон хүн чулуун хөшөө” гэж буй. Хүнхээр бол эртний түрэг гаралтныг монголчууд дээр үед нэрлэж байсан нэр гэж Ринчин гуай 50-аад онд нэгэн өгүүлэлдээ бичсэн шиг санагдана.

Гэтэл сая Пэрлээ гуайн нэг шүлгийн номыг дэмий сөхөж суутал “Хунгар” гэж венгерийн эртний нэр бөгөөд хүн – гар гэсэн юм гэж байв. Унгарыг үнэхээр Хунгар гэж латин үсгээр галигласан нь үзэгдэх бөгөөд Хун гэдэг бол хүн үү, биш үү? ямар ч байсан хүннү улсын үлдэгдэл биз, тэгэхээр монгол нутагт хүнхээр гэж яригдаж үлдсэн нэрээрээ тэд европт Хунгар-унгар-венгер болж дуудагдаж суурьшсан, хүн улсын I аймаг байлаа⁴⁴.

... Архангайн Тайхар чулууг эртний орхоны түрэг аймаг тэгж, нүцгэн хад, цулгүй чулуу гэж нэрлэж байсан юм биш байгаа? манай эрдэмтэд тайхар чулууны тухай элдэв таамаглал хийж “шинжлэх ухаан” сэтгүүл дээр, тэр жил нэг будилж байсан тохиол бий дээ.

Ш.Гаадамба гуай “Нууц товчооны нууцаас” гэдэг номдоо “Шинчи баян” гэдэг үгийн тухай нэг таамаглал хийж үзсэн буй. Гэтэл одоо хэр нь казахстанд хехиетү гэдэг ууланд шинчи баян гэдэг салбар уул буюу тийм газар буй бололтой. Тэднийхний дуунд орсон байна. Дуу нь казах хэлээрээ надад байгаа!

Селинбуугийн яам гэж манайд байсныг одоо манай ном бичигт Сүй Ляньфу ч гэнэ үү, их л хэцүү дуудаж бичдэг. Энэ нь яам штаб гэсэн хятад үг юм байна.

Төвөд (төвөд үсэг)-өөр штаб гэж бичдэг дууддаг ажээ⁴⁵.

Ийнхүү ном судар уншихад ч, нийтлэл өгүүлэл сонирхохдоо ч монгол хэлний үгийн үүсэл гарлын тухай түүний сониуч төсөөлөн бодсон, ургуулан сэтгэсэн нь их л сонирхолтой байдаг. Манай өнөөгийн зохиолчид хэрвээ энэ шинжээр үг хэл, үсэг бичгийн үүсэл гарал, хувирал хөгжил жич үгийн жинг цэнэж, шүлэг туувилаа хийдэг бол хэчнээн сайн бэ! монгол хэл маань модон хэл болж байгаа гэдгийн цаад санаа нь бид үгийн хэрэглээг үнэхээр олж сонгож оновчтой ашиглаж чадахгүй байна. Үйл үгийн үйлдэл нь бүх уран зохиолын сүнсийг тэр чигээр нь амилуулж, хөдөлгөөнт ертөнцийг буй болгодог гайхамшгийг ул мөргүй мартсанаас

⁴⁴ Б.Дамдинсүрэн. “Р.Чойномын шүлэг зохиолын хураангуй”, боть V, ӨМСХХ 2014, х 534

⁴⁵ Б.Дамдинсүрэн. “Р.Чойномын шүлэг зохиолын хураангуй”, боть V, ӨМСХХ 2014, х 540

THE CULTURAL WAY

өнөө цагийн урагш муутай, эрэмдэг зэмдэг шүлэг бичиж байхын гар тэр ээ!

ДҮГНЭЛТ

Ринчиний Чойномын ертөнцийг үзэх үзэл, хүний амьдралын амьдрал тэрчлэн хүн байж хүн зонхноо төлөө сайн сайхныг үүдэн бүтээлцэхийн тулд хэрхэн өөрийгөө боловсруулах, эрч хүчээ авах цаашдын ажил хөдөлмөрийнхөө тухай төлөвлөн төсөөлөх, бусдыгаа өөрөөсөө дутуугүй анхааран халамжлахын тулд юу хийдгийг захидал чимээ гэх аугаа ертөнцөөр хойчийн бидэнд дэлгэн үзүүлсэн байна.

Нэг. Р.Чойномын мэдээллийн бүх утга учир бол “шүлэггүй төрж, шүлэгтэй үхэх аз тавилан” юм. Яг л нэг хоосон атарт хэрхэн хур шим асгаж, үр тариа үрлүүлэх, шан хашлагаа татаж, үтрэмийн талбайг харгалзар мэтчилэн өөрийгөө яруу найргийн шинэ хөрсөн дээрээс хэрхэн илэрхийлэн гаргах, урьдын уламжлалаас хэр сайн сурч байж, хойшдын шинэчлэлийг бүтээн гаргах тухай маш хичээнгүй үйл ажил болон төсөл төлөвлөгөөгөө нарийн тоочжээ.

Хоёр. Монголын уран зохиолын 20 дугаар зуунд, адал явдлаар дүүрсэн, айдас үймээн ихтэй он жилүүдийн түүхийг үнэн зөвөөр нь тэмдэглэн үлдээхийн төлөө түүхийг хэрхэн нэвтэртэл уншиж ойлгохын тулд оюун ухаанаа зэвсэглэсэн явц буй болжээ. Тэр мөртлөө өөр бусдын сонгодог шилмэл зохиол бүтээл, оюун ухааны тунадсыг өвлөн ухаарахаар дамжин энэ ертөнцийн болох болохгүй олон үйл хэргийг яруу найраг, тууж, кино жүжгийн төрөл жанраар илэрхийлж гаргахын тулд боловсорсон бийрийн доороос маш олон гайхалтай бүтээлүүдийг туурвин гаргажээ. Энэ бол монголын уран зохиолд зуун дамжсан үлгэр жишээч зохиолыг бичиж үлдээхийн тулд өөрийгөө боловсруулан хөгжүүлж, өрөөл бусдыг дуудан сэрээх нөр их хөдөлмөр ба чөлөөтэй асгарсан авьяас билгийн тунадас мөн!

Гурав. Ертөнцөд нэг бол ухаарах гэж, нөгөө нь төдий дурлаж хайрлах гэж ирдэг аж. Р.Чойномын жижигхэн чулуунд бүдэрч тээрмийн чулуугаар даруулж, уулын чулуугаар дарамтлуулах нэг нас бол өөрийн зорилтдоо хүрэхийн төлөөх тэмцэл! зорьсон зүгтээ тойрох биш дайран орсон замнал! мэдээж! замын турш олон хавх онуул үүнийг ирлэж цоохорлосон ул мөр буй.

THE CULTURAL WAY

Бусдын төлөө зүрхний угаасаа залбиран даатгаж, бусдыгаа, бүгдийгээ эснэн босгохын тулд тэрбээр хайрлах, хайрын хариуд исгүүлэх, дахин хайрлаж, хэлж ухааруулж явсан шивнээ буй! хайр дурлал гэдэг бол их уудам өлгий юм. Жижиг зүйлээс томыг олж харуулахын төлөө тэрээр цаг ямагт найзыгаа, дүү нараа ятган додомдож, илчээ хүргэн дулаалсаар явжээ. Түүний хэлж үлдээсэн олон олон захиасын мөр бадгууд нь хожмын өсвөр үеийн эгнээн эрүүлээр өсөн бойжиход эм тангаас илүү сургаал болсон гэдгийг бэлхэн гэрчлэн үлдээжээ.

Уран зохиолын ид шид нь бусад хүмүүсийг сэтгэл зүрхний угаас нь нөлөөлөн догдлуулж тэр их эрч хүч, энергийн урсгалаар цэвэр агаарыг амьсгалж, чигч шударгаар хүмүүстэйгээ амьдран дэвжихийг уриалан дууддаг.

Р.Чойномын ил буюу далд захианы үр дагавар нь хүмүүсийг сайн сайханд хүргэх, ая зүйтэй, эв найрамдалтай гэр бүлээс энх амгалан нийгмийг буй болгох халуун илчтэй байжээ. Захидал чимээний онцлог нь уран бүтээлд шуугдаж чадаагүй төрөл, тоочин илгээхэд хэцүү олон зүйлийн ээдрээг тайлах түлхүүр билээ. Ринчиний Чойномын дотоод сэтгэлийн нууцыг эдгээр захидал илүүтэй сайн тайлж чаджээ.

THE CULTURAL WAY

НОМ ЗҮЙ

(1) Өгүүлэл

1. Асга. “Өвөр Монголын монгол шүлэг бүтээлт дэх монгол улсын нөлөө судлал – Дэлхийн утга зохиол сэтгүүлийн эргэн тойронд”, ӨМИС-ийн магистрын зэрэг хамгаалах өгүүлэл, 2015
2. Хуан Жинь. “Орчин үеийн монгол шүлгийн судлал”, докторын зэрэг хамгаалах өгүүлэл.
3. Хүүзаяа. “Монгол улсын орчин үеийн уран зохиолын дундад улс дахь нөлөө судлал (1980-1990)”, ӨМИС-ийн магистрын зэрэг хамгаалах өгүүлэл, 2015
4. Дүүтуул. “Өвөр Монголын уран зохиол дахь Р.Чойном үзэгдэл”, магистрын зэрэг хамгаалах өгүүлэл, 2015
5. Жан Рүншя. “Монгол улсын орчин үеийн утга зохиолын дундад улс дахь нөлөө судлал (1946-1979), ӨМИС-ийн магистрын зэрэг хамгаалах өгүүлэл, 2011

(2) Ном

1. Ч.Нэргүй. “Р.Чойном хан хэнтийд”, УБ., 2006
2. Буяндэгжрэх. “Монгол ард улсын утга зохиолын тойм”, ӨМСХХ, 1988
3. Б.Бүрэнбэх. “Уянгын эрэлчний тэмдэглэл”, ӨМАХХ, 1984
4. Солонгод Л.Хасбаатар. “Р.Чойном, Л.Чулуунбаатар”, Герман ImoFiF Elians e. V. Publisher 2015
5. Л.Хасбаатар. “Р.Чойном судлал жич түүний шүлгүүд”, ӨМСХХ, 1996
6. Л.Хасбаатар. “Цагийн жаварт бөхөөгүй зул”, УБ., 2009
7. П.Хорлоо, С.Лувсанвандан, Д.Мөнх, Д.Цэнд. “Монголын орчин үеийн уран зохиолын судлал шүүмжлэл”, ӨМСХХ, 2004
8. П.Хорлоо, С.Лувсанвандан, Д.Мөнх, Д.Цэнд. “Монголын орчин үеийн уран зохиолын судлал шүүмжлэл”, ӨМСХХ, 2004
9. Г.И.Михайлов. “Орчин үеийн монголын утга зохиолын түүхэн найруулал”, ӨМАХХ, 1958
10. Ван Мандаа. “Монголын орчин үеийн уран зохиолын судлал шүүмжлэлийн хураангуй”, ӨМСХХ, 2000
11. Ш.Сүрэнжав. “Сүмтэй бударын чулуу”, УБ., 1989
12. Б.Дамдинсүрэн. “Р.Чойномын шүлэг зохиолын хураангуй” боть I, (Уянгын шүлгүүд), ӨМСХХ, 2014
13. Б.Дамдинсүрэн. “Р.Чойномын шүлэг зохиолын хураангуй” боть II, (Найраглалууд), ӨМСХХ, 2014
14. Б.Дамдинсүрэн. “Р.Чойномын шүлэг зохиолын хураангуй” боть III, (Шүлэглэсэн тууж романууд), ӨМСХХ, 2014

THE CULTURAL WAY

15. Б.Дамдинсүрэн. “Р.Чойномын шүлэг зохиолын хураангуй” боть IV, (Туужсын зохиолууд), ӨМСХХ, 2014
16. Б.Дамдинсүрэн. “Р.Чойномын шүлэг зохиолын хураангуй” боть V, (Дурсамж найрууллууд), ӨМСХХ, 2014
17. О.Дашбалбар. “Гэгээн ертөнц”, боть I, ӨМСДХДШХХ, 2019
18. О.Дашбалбар. “Монгол ертөнц”, боть II, ӨМСДХДШХХ, 2019
19. О.Дашбалбар. “Хүн ертөнц”, боть III IV, ӨМСДХДШХХ, 2019
20. О.Дашбалбар. “Шидэт ертөнц”, боть V VI, ӨМСДХДШХХ, 2019
21. О.Дашбалбар. “Гунигт ертөнц”, боть VII VIII, ӨМСДХДШХХ, 2019
22. Д.Цэдэв, Мандаа. “Сономбалжирын Буяннэмэх” (4 боть), ҮнХХ, 2008
23. Ч.Чойдор, Жамба. “Монгол улсын орчин үеийн уран зохиол”, ӨМИСХХ, 1998
24. Чэнь Ганлун, Урсгал. “Д.Нацагдоржийн сонгодог тайламж”, ҮнХХ, 2009
25. “Р.Чойномын амьдрал уран бүтээл”, Чойномын мэдэлсний 70 жилийг ойг тэмдэглэх эрдэм шинжилгээний хурлын бүтээл, УБ., 2006
26. С.Баянжаргал. “Монгол язгуур урлаг – хөгжимдхүй дууны 365 нэрс”, ӨМАХХ, 2017
27. Ц.Цолмон. “Их тамучийн тэнгэр”, ӨМАХХ
28. Ц.Цолмон. “Орчлонтой яригч дорнодахины яруу найрагч”, Чэнь Ганлун, С.Урсгал. “Д.Нацагдоржийн сонгодог тайламж”, ҮнХХ, 2009
29. “Р.Чойном”, боть I, Шүлэг, УБ., 2017
30. “Р.Чойном”, боть II, Шүлэг, УБ., 2017
31. “Р.Чойном”, боть III, Найраглал, УБ., 2017
32. “Р.Чойном”, боть IV, Найраглал, УБ., 2017
33. “Р.Чойном”, боть V, Шүлэглэсэн тууж, УБ., 2017
34. “Р.Чойном”, боть VI, Шүлэглэсэн тууж, УБ., 2017
35. “Р.Чойном”, боть VII, Роман, тууж, өгүүллэг, УБ., 2017
36. “Р.Чойном”, боть VIII, Тууж, өгүүллэг, УБ., 2017
37. “Р.Чойном”, боть IX, Орчуулга, УБ., 2017
38. “Р.Чойном”, боть X, Захидал, УБ., 2017
39. “Р.Чойном”, боть XI, Дурсамж, хууч яриа, УБ., 2017
40. “Р.Чойном”, боть XII, Ярилцлага, сурвалжилга, УБ., 2017
41. “Р.Чойном”, боть XII, Судлал, шинжлэл, УБ., 2017
42. 王宁: 《管或乐法基础教程》, 高等教育出版社, 2008 年
(3) Сонин сэтгүүл
1. Ч.Эрдэнэ-Баяр. “Монгол улсын орчин үеийн утга зохиол ба зөвлөлт орос улсын утга зохиолыг харьцуулан судлах асуудалд”, ӨМИСЭШС, 2005 №4

THE CULTURAL WAY

2. Буяндэгжрэх. “БНМАУ-ын орчин үеийн яруу найргийн хөгжлийн товчоон”, ӨМҮНБДСЭШС, 1989 №1
 3. Бэй Ган. “Ч.Лодойдамбын Тунгалаг тамир ба М.Хасбаганын Засгийн хутгуур романыг харьцуулах нь”, ӨМҮНИСЭШС, 2004 №4
 4. Л.Хасбаатар. “Эмэгтэйчүүдийн чөлөөлөлт ба Р.Чойном”, Алтан гарди, 1996 №4
 5. Лагсагмаа. “Монгол улсын орчин үеийн уран зохиол БНХАУ-д”, УБИС, 2009 №4
 6. Кань Хай Ин. “Диваажингийн элчийн зөн мэдрэхүй”, ӨМИСЭШС, 2020 №1
 7. Цэнгэлтэй. “Монгол улсад явсан тэмдэглэл”, ӨМӨС, 1953.2.4
 8. Ринчин. “Монгол шүлгийн учир”, ӨМБИСЭШС, 1996 №3
- (4) Цахим сүлжээ
1. 百度文库: 交父响乐乐器介绍—图文详解》
 2. <https://wenku.baidu.com/view/2dc72fbf9fc3d5bbfd0a79563>

ABSTRACT

If we look at the sound of R. Choinom's letter in general, we know that during the seventy years of Mongolia's history from independence to the 1990s, all activities under the influence of the Soviet Union were in a state of colonization, so a large-scale repression took place. Among them, politicians and patriotic ideologues persecuted many writers.

Key words: *R. Choinom, letter, art*

КОМИНТЕРН БА МОНГОЛ УЛСЫН ХАРИЛЦААН ДАХЬ ТАГНА УРИАНХАЙ ОРНЫ ТУХАЙ НЯГТЛАХ НЬ⁴⁶

Жаргал *

ХУРААНГУЙ

Зөвлөлт орос болон монголын харьцаанд коминтерноос олон зүйлийн улс төрийн үйл хэргийг гүйцэтгэж байв. Үүнд зөвлөлт орос улсын ашиг тусыг харгалзсан урьдач нөхцөлд Тагна Урианхай орныг монгол улсын нутаг дэвсгэрээс салгасан чухал агуулгыг багтаана. Монгол улс нь өөртөө эзэрхэх бүрэн эрхээ олох ба бататгах зорилтдоо хүрэхийн төлөө зөвлөлт орос улсаас дэмжлэг хүссэн онцгой түүхэн нөхцөл байдалд Тагна Урианхай орон нь зөвлөлтийн хүчний хүрээнд орж, аажмаар ОХУ-ын нэг хэсэг болсон байна. Тус өгүүлэлд шинэхэн илрүүлсэн баримт бичгийг ашиглаж, Монгол Ардын Нам ба Коминтерны хоорондох улс төрийн харилцаагаар дамжиж, онцгой улс төрийн талбарт буй болсон Тагна Урианхайн тухай асуудал ба түүний түүхэн явц, шалтгаан, үр дүнгийн тухайд нягтлав.

Түлхүүр үгс: Коминтерн, Монгол, Тагна Урианхай орон

Чин улсын үед урианхай орныг тус тус Алтай уулын урианхай, Алтай нуурын урианхай, Тагна урианхай (Тагнын уулсын орчим нутагладаг) хэмээн гурав хувааж байсан ба тэдгээр нь Улиастайн жанжинд хамаарагдаж байв. Хаант оросоос “1909 онд түүнийг (Тагна Урианхайг) цэргийн хүчээр эзлэн авч, өөрийн засаг захиргааг байгуулсан”[Э.Хүрэлбаатар, 1996, х.49] юм. Тагна Урианхай орон бол газар нутгийн чухал ач холбогдолтойгоос гадна тарианлангийн үйл хэргийг хөгжүүлэхэд маш тохиромжтой орон билээ. “Түүхийн эдийн зах

⁴⁶ Тус өгүүлэл бол Үндэстний Дээд Сургуулийн “Умард хязгаарын үндэстний соёл судлах суурин газар”-ын бүтээл болно.

* Доктор, дэд профессор (Хөх хотын Үндэстний Дээд Сургуулийн багш)

THE CULTURAL WAY

зээлийн хувьд монголыг шууруулах болсон хаант орос албадан дагуулахыг эрмэлзэх замд төдөлгүй орсон бөгөөд энэ нь ялангуяа алс дорнодод японтой байлдаж ялагдсаны дараа улам хүчтэй болж байгалийн нөхцөл байдлаараа газар тариалан өргөн хөгжүүлэх боломжтой монголын ховор район (орон)-ы нэг болсон урианхайн хязгаарыг эзлэн [Э.Хүрэлбаатар, 1996, х.49], аажмаар өөрийн колони орноо болгожээ. Энэхүү явцад монгол ба иргэн улсын талаас урианхай орны эрх мэдлийн төлөө хаант орос лугаа олон удаа зөрчил үүсгэж байв. 1915 оны 8 сард Хүрээний эрх баригчдаас хаант оросын хүрээнд суугаа элчин сайд консул лугаа урианхайн асуудлыг хөндөж зөвлөлдсөн юм.

Хаант оросоос 1916 оны 3 дугаар сар ба 6 дугаар сард явуулсан түрэмгий ажиллагааг Тагна урианхай хошууны бүгдийг захирагч Баянбадрахаас Чэнь И-д мэдэгдэж, иргэн улсын засгийн газарт чимээ явуулав. 1917 оны 8 дугаар сараас 1919 оны 6 дугаар сарын хооронд, зөвлөлт оросоос урианхай орон дахь гар дүрэлтийг монголын талаас эсэргүүцэж, иргэн улсын засгийн ордонд тус явдлыг чухалчлан үзэхийг санаачлав. Иргэн улсын засгийн ордноос орос улсад суугаа элчин сайдын яамаар дамжуулан эсэргүүцэл илэрхийлж буйгаа илэрхийлсэн боловч бүтэмжтэй хариу олсонгүй, гадаад дотоодын хүнд нөхцөлд тулгараад байсан иргэн улсын засгийн ордон тус явдлыг ч зохимжтой шийдвэрлэж чадсангүй. 1919 онд коминтерны зохион байгуулалт байгуулагдсан нь зөвлөлт орос ба монголын харилцаа шинэ түүхэн шат үед орсныг харуулж, Тагна урианхайн асуудал нь Монгол ардын нам ба зөвлөлт оросын харилцааны чухал сэдэв болжээ. Эрдэм шинжилгээнд иргэн улс болон тагна урианхайн тухай цөөн тооны судлагаа[乌梁海问题, 2000] байдаг ч тусгайлан Монгол ардын нам ба Тагна урианхайн тухай судалгааны бүтээл хараахан үгүй байна.

Нэг. Тагна Урианхай жич Коминтерн ба Монгол ардын нам

Оросын арван сарын хувьсгалын дараа, 1918 оны 12 дугаар сарын 1-нд Москвагийн засгийн газрын гадаад харилцааны явдлын сайд А.Клочников: “Урианхай асуудлаар монголчуудтай бид учраа ололцож хэлэлцээр байгуулж чадах байх гэж бодож байна”[АВПРИ] хэмээв. Урианхайн асуудлаар нөхцөл болгон харилцаагаа зохицуулах гэсэн нь зөвлөлт оросоос монголд хандуулсан улс төрийн арга барилын чухал

THE CULTURAL WAY

агуулга болно. 1919 оноос эхлэн зөвлөлт орос нь коминтернээр гүүр болгон Тагна урианхайн асуудлыг тохируулах болжээ.

1919, 1920 онд зөвлөлт оросоос цагаан хаант оросын үед колони орон болгон эрхшээн авсан нутаг дэвсгэрүүдийг тус улсад нь буцаан өгөхөөр урьд хожид хоёр удаа тунхаглав. Үүнд 1896 оны “Дундад оросын нууц хэлэлцээр”, үүний дараах нь Бээжингийн засгийн ордон лугаа тогтоосон тэгш бус хэлэлцээрүүд жич 1907-1916 оны хоорондох хаант орос ба япон улс лугаа тогтоосон дундад орны нутаг дэвсгэрийг колонийн орноо болгосон асуудалтай холбогдсон гэрээ зурвасуудыг хүчингүй болгохоо илэрхийлэв. Хаант оросын үед колони орноо болгосон Тагна урианхайг монголын талд буцаан өгөх нь зөвлөлт оросын нийгэм журамт шинэ засгийн гадаад бодлого ба коминтерны зохион байгуулалтын улс төрийн бодлоготой зохицох юм. Үүний тухай орос эрдэмтэн С.Г.Лузянин “Цэвэр үзэл суртлын үүднээс авч үзвэл большевик удирдлага туваг монголынх юм уу хятадын хувьсгалчдын харьяалалд оруулж, ингэснээрээ зөвлөлтийн улс төрийн бодлогын интернациональч шинж чанарыг харуулах ёстой байсан болно”[Б.Доржханд, 2015, х.112] гэжээ. Гэвч Тагна урианхайн тухай коминтерноос монголд тодорхой илэрхийлсэнгүй хойшлуулаад байсан юм. Үүнд монголын хувьсгалчид коминтерн лугаа анх харилцсанаас эхлээд урианхайн явдлыг товойлгон дурдсаар иржээ.

Чойбалсан, Сүхбаатар, Данзан нараар бүрэлдсэн долоон төлөөлөгч Иркутск хотод хүрч, алс дорнодын хэрэг эрхлэх газрын дарга Гапантай уулзаж (1920 оны 8 сарын 21) зөвлөлт оросоос тусламж гуйсан ба Данзангийн зүгээс “урьд орос император (эзэрхэг түрэмгий улс, импери гэгчийн ташаа бичлэг) эзэн хаанаас эзэрхэн авсан урианхайн газрын эгүүлэн авахыг хүсмүй хэмээсэнд Гапан, эл хэргийг монголын шинэ засгийн газраас тухайд хэлэлцвээс сая болох болов уу”[УИБТК] хэмээн хойшлуулав. Энэ бол Данзан, Сүхбаатар нарын хүмүүс монгол ардын намыг төлөөлж коминтерн лугаа урианхайн тухай зөвлөлдсөн чухал чанар бүхий хэлэлцээр байж, “Зөвлөлт орос улсад томилсон ардын засгийн төлөөлөгчөөс арын монголын урианхайн нэгдмэл удирдлагын тухай чангатгаж”[青木雅浩, 2011, х.62] байв. Зөвлөлт оросын гадаад хэргийн ардын комиссарын Сибирийн төлөөлөгчийн газраас монголд гадаад харилцаа, цэргийн явдал, аж ахуйн тусламж үзүүлэх тухай монголын төлөөлөгчидтэй Иркутск хотод хэлэлцээр хийв. Үүнд

THE CULTURAL WAY

монголын төлөөлөгчдөөс урианхайн тухай “бүгд баримтаас үзсэн ч гадаад монголын харьяа нутаг байсан боловч хаант оросын булаан авсан урианхайн хязгаарын тухай асуудлыг төлөөлөгчид хөндөн тавихыг хүсэж байна. Тэрхүү булаан эзлэлтийг хүчингүй болгохыг чухал гэж бид үзэж байна. Түүнчлэн тусламж үзүүлсний төлөө нөхвөр өгөх шударга асуудлыг орос улсад дэвшүүлэв”[Э.Хүрэлбаатар, 1996, х.17] гэжээ.

Энэ нь монголын төлөөлөгчдөөс Тагна урианхай ба Зөвлөлтөөс тусламж үзүүлэхийг салган үзэж, зөвлөлт оросын тусламжийн хариу нөхвөр өгөхөө тодорхойлохын дагуу тагна урианхайг монголд буцаан өгөхийг зөвлөлт оросод чухалчлан дурджээ. Тус хуралдааны агуулгад зөвлөлт оросоос монголд тусламж үзүүлэх гэсэн боловч тусламжийн хариу монголын талаас хэр зэргийн нөхвөр авахаа тодорхой дурдсангүй. Үүнд Гапан: “...тусламжаа үзүүлэхээс өмнө нөхвөр төлүүлэх асуудлыг ярих нь эртгэдсэн зүйл гэж үзэж байна ... зөвлөлт орос улс япон буюу америк шиг тэгж шунахай зан гаргахгүй нь аяндаа ойлгомжтой шүү дээ. Зөвлөлт орос улсын хувьд хамгийн чухал нь нөхөн төлүүлэхэд биш, харин монголын хөдөлмөрчид ялан дийлсүгэй гэдэгт л байгаа юм”[Э.Хүрэлбаатар, 1996, х.17] гэв. Зөвлөлт оросын дэмжлэгийг тулгам шаардаж байсан урьдалд, тагна урианхай орны асуудлыг идэвхтэй дурдаж байсан нь монгол ардын нам нь монголын эрх мэдлийн талаар бүрэн эрхт улс болохын төлөө ба мөн урьдын алдсан нутаг орноо эгүүлэн авах гэсэн оролдлого болно.

1921 оны 3 сард монголд ардын түр цагийн засаг байгуулагдсан нь монгол болон зөвлөлт оросын хоорондох харилцаа нь монголын төлөөлөгч, монгол ардын намын хэмжээнээс давж, засгийн талаас харилцах түвшинд хүргэв. Монгол ардын түр цагийн засгийн газраас “1921 оны 4 сарын 16-нд, ардын түр цагийн засгийн газрын урианхайд суух бүрэн эрхт төлөөлөгчийн хувиар Чагдаржавыг томилов”[青木雅浩, 2011, х.62]. 1921 оны 6 сарын 14-нд, зөвлөлт оросын гадаад хэргийн ардын комиссар Г.В.Чичеринээс: “Урианхайн асуудлын тухай ... монголын ардын хувьсгалт нам (энэ үед монгол ардын намыг монголын ардын хувьсгалт нам гэж нэрлэхгүй болохоор монгол ардын нам гэвэл зохистой, зохиогчоос)-ын үйл ажиллагааны хэмжээнд ирээдүйд монголын нэгдэх явдалд төлөвлөгдсөн урианхай зүг ихэсгэх чухал байдаг уу? монголын бүгд найрамдах улсын уг ёсоор өөртөө засах урианхайн тухай хөтөлбөр гаргах нь одоогоор чухалтай болов

THE CULTURAL WAY

уу”[ДВЛСР, х.273] гэж байв. Тэгээд 1921 оны 7 сарын 1-нд монголын төлөөлөгчдийг Чичерин хүлээн авч уулзсанд монголын талаас зөвлөлт оросод монгол ба урианхай орон нэгдэн нийлэх гэсэн эрмэлзлийг дэмжихийг хүссэн шаардлага тавьжээ.

1921 оны 7 сарын 10-нд зөвлөлт оросын засгийн газраас “Монгол улсын Нийслэл хүрээнд бүрэн эрх барих төлөөний элчин ба Улиастай, Ховд, Алтанбулаг хот газар тус тус консул суулгажээ. Бас монгол ардын засгийн газар лугаа зөвлөн хэлэлцэж, бусад газар суулгаж болмуй”[МАХН, х.62] хэмээв. Урианхай орон нь чин гүрний үед улиастайн жанжны харьяанд хуваагдан захирагдаж алба барьж байв. Зөвлөлт оросын улиастайд бүрэн эрхт элчин газар байгуулахыг монголын талаас зөвшөөрсөн ийм шийдвэр нь урианхай орныг монголын эрхшээлээс холдоход хүргэж байлаа. Б.Шумяцаки 1921 оны 7 сард Чичеринд бичсэн мэдээнд: “Урианхайн хязгаарыг монголд нийлүүлэх асуудлыг одоогоор шийдвэрлэхгүй нээлттэй үлдээх нь зүйтэй”[РЦХДНИ, х.3] гэсэн сануулга байв. Одоогоор шийдвэрлэхгүй нээлттэй үлдээх гэсэн нь зөвлөлт оросоос монголын урианхайн тухай тавьсан асуудлыг хойшлуулсан явдал болно.

Данзан Москвад хэлэлцээр хийж байхдаа урианхай тухай асуудлыг тавьж монгол овогтон нэгдмэл байх гэсэн санааг илэрхийлэв. 1921 оны 9 сарын 9-нд Чичеринээс дахин урианхайн тухай шийдвэр гаргаж “Зөвлөлт орос улс энэ хязгаарыг өөрийн нутаг гэж үзэхгүй байна. Түүний өөртөө засан тогтнох эрхийг монголын чөлөөлөх хөдөлгөөнтэй холбон авч үзэх болно”[РЦХДНИ, х.73] гэжээ. Тус жилийн 10 сарын 26 – 11 сарын 5-нд болтол явагдсан зөвлөлт орос ба монголын хэлэлцээрт урианхайн явдлыг монголын төлөөлөгчид чухалчлан дурдахад, коминтерны төлөөлөгчид харин “Тагна урианхайн нутгийг (зөвлөлт орос) өөрийн нутаг гэж үзэхгүй, тэнд ямар ч санаархал байхгүй ... монгол дахь эрх чөлөөний хөдөлгөөний цаашдын ирээдүйтэй холбон үзнэ”[Ч.Батбаяр, 2013, х.66] гэжээ. Энэ нь коминтерноос өнгөрсөнд монголын төлөөлөгчдийн тагна урианхайн асуудлыг хойшлуулж байсантай адилтгавал нэг хэмжээнд тагна урианхай орныг монголын нутаг дэвсгэр болохыг зөвшөөрсөн тодорхой хариулт болно. 11 сарын 9-нд Шумяцакиаас Ринчиновт илгээсэн захидалд: “Данзангаас урианхайн газар орон бол ардын засгийн эрх мэдлийн доор харьяалагдах гэх явдлыг хэлэлцээрийн ёсоор одоогоор мэдрэх хэрэгтэй гэдгийн тухай эрс чанга шаардсан

THE CULTURAL WAY

байна”[МУУТА, х.73]. 1922 оны 1 сарын 25-нд алс дорнодын ард түмний анхдугаар их хурал дээр Ө.Дэндэвийн тавьсан илтгэлд, хаант оросын үеийн монгол дахь улс төрийн бодлогыг илчлэхдээ “хаант орос улс монголын урианхайн хязгаарыг эзэлж аваад, манжуураас хүрээ, хөвсгөл нуур хүртэлх шугамаар монголын шилдэг хэсгийг байлдан дагуулахаар бэлтгэж байв. Хаант оросын нөлөөнд автономит монгол улс оршин тогтнож ирсэн 9 жил нь Сандо амбан, түшмэл Миллер (хаант оросын гадаад харилцааны төлөөлөгч) хоёрын хооронд ямар ч ялгаагүй бөгөөд аливаа үндэстний харгис үзэлтэд аль нь ялгаагүй хүчээр төрөө барин дарлахыг эрмэлздэгийг батлан харуулав”[Э.Хүрэлбаатар, 1996, х.54] хэмээв. 1922 оны 4 сарын 17-нд монгол ардын намын төв хороонд бичсэн бичгүүдийн агуулгад тагна урианхайг багтаасан монгол угсаатан нэгдэх гэсэн агуулгыг мөн чухалчлав. Монголын нам төрийн удирдагчид монгол ардын намын анхдугаар их хуралд улсдаа монгол үндэстэн бүгдээр нийлэх гэснийг товойлгож, “монгол ардын намаас өөрийн үзэл явдлыг бүх монголд дэлгэрүүлж, эцэст нь бүгдээр нийлэхийг эрмэлзэх тул оросын цагаан хааны үесэд монголоос эзэрхэн тасалж авсан тагна урианхайг эгүүлэн өгч, нөгөөтэйгүүр бүх монгол нэгдэж улс болох доор зөвлөлт засгийн газраас ямар бодолтойг манайд мэдэгдэхийг хүсэх”[О.Батсайхан, 2009, х.133]-ийг шаарджээ.

Үүний хамт Жамсрановоос монголын газар зүйн сурах бичигт ч тагна урианхай орны асуудлын тухай агуулгыг бичиж оруулсан юм. Монгол ардын хувьсгалт намын 6 дугаар их хурал дээр коминтерны гүйцэтгэх хорооны төлөөлөгчдийн тэргүүн Б.Шмерли-ээс “Зөвлөлт социалист бүгд найрамдах холбоот улс колоничлох зорилго гэх буюу улаан империализм (эзэрхэг түрэмгийлэгчид) хэмээх цуу үг дэлгэрчээ. Жамсранов газар зүйн сурах бичигт орос улс болбоос тагна тува улсыг өөрийн колони болгожээ хэмээн бичихээс ч буцсангүй”[Э.Хүрэлбаатар, 1996, х.200] 1923 онд монгол ардын намын төв хорооноос тувагийн ардын намын төв хороо болон тувагийн засгийн газрын гадаад яаманд мэдэгдэл хүргүүлж түүнд “монгол болон тува нэгдэх”[Вес-Ази, 1911, х.74-76] тухай хүсэлт гаргасан юм. Монголд коминтерны тусгай зөвлөх сургагчийг томилж улс төрийн талаар ихэд нөлөөлж байсан ч монгол ардын нам өөрийн чиг баримтлалаа боловсруулж, онцгойлон тагна урианхай орны явдалд өөрсдийн үзлийн талд бат зогсож байжээ.

THE CULTURAL WAY

Хоёр. Тагна Тува бүгд найрамдах улс байгуулагдсан ба монголын эсэргүүцэл

Хэдийгээр 1921 оны 8 дугаар сард тагна тува бүгд найрамдах улс байгуулагдсаныг зөвлөлт орос мэдсэн боловч монголын талаас эгүүлэх ажиллагаагаа хийсээр байсан ба үүн лүгээ харгалзсан зөвлөлт оросыг эсэргүүцсэн бослого үүсгэв. Тухайлбал, 1923 оны 6 дугаар сард урианхай оронд тувагийн засгийн газар болон зөвлөлт оросын нөлөөг эсэргүүцэх бослого гарав. 1924 оны 4 сарын 2-3 өдөр зөвлөлт оросын эсрэг бослого дахин үүссэн байна. 1924 онд Хаймчигийн бослого үүсэж, тувагийн хошуунд зөвлөлт оросыг эсэргүүцсэн бослого мөн гарчээ. “Өмнө хошуунд монголын талыг баримталсан үзэл санааг харгалзан бослогын удирдагч Содномбалжир БНМАУ-ын засгийн газарт хандан туваг монголын бүрэлдэхүүнд багтаан авахыг хүсэн өргөдөл бичсэн”[Ученые, 1960, х.103] ба монголын талаас зөвлөлт орос “алтайн хязгаарыг монголд эргүүлж өгөхийг шаардаж”[Б.Доржханд, 2015, х.455] байв. МАН-ын төв хорооноос “Алтайн муж чин улсын үеэс эхлэн ховдын амбаны захиргаанд байсан. Алтайн урианхайчууд болон бусад хошууд, хасагийн олон овог аймгууд өмнөх автономит монголын үед тэдний захиргаанд нэгдэж байсан юм. Хошуудын ард олонд өнөөгийн монголын засгийн газарт захирагдах ба удаа дараалан илэрхийлж”[Kitad, 1924, х.26-28] байна хэмээв.

Зөвлөлт оросын тусгай албаны нэгэн нууц мэдээнд: “Энэхүү хөдөлгөөний улс төрийн өнгө аяс бол урианхайн хязгаар болон монголын харилцааны ээдрээт байдлаас үүссэн бөгөөд орон нутгийн хүн ам тагна тувагийн засгийн газраас явуулж байгаа бодлогод дургүй байдгийн нэг илрэл юм. Энэ хөдөлгөөнийг удирдаж үзэл суртлын нөлөө үзүүлж байх хүч нь баруун монгол юм”[РЦХИДНИ, х.109] гэжээ. Иймэрхүү монголчуудын бослогын зорилт нь шууд тагна урианхай орныг буцаалгах асуудалд чиглэжээ. Монголын талын олон удаагийн шахалт ба урианхайчуудын монгол руу нэгдэх хандлагын нөлөөнд коминтернээс монголд өгсөн хариулт нь “Урианхайн хязгаарт монголын засгийн газраас явуулсан улс төрийн үйл ажиллагаа нь хятадын нөлөөн доор явагдсан учраас үүнийг зөвшөөрөх боломжгүй. Иймд өргөөгийн засгийн газар энэхүү шийдвэрээсээ татгалзахыг бид уриалж байна”[АВПРИ, х.72] гэжээ. Энэ нь дээр дурдсан урианхай орныг монголын эрх чөлөөний явдал гэж байснаас хятадын нөлөөнөөс болсон

THE CULTURAL WAY

хэмээх нэр зүүж, монголын урианхай оронд улс төрийн ажиллагаа явуулахыг шууд хориглосон байна. Энэ нь иргэн улс, монголын аль ч талаас харсан ч урианхай орныг зөвлөлт орос улсаас эзэмших нь колонийн ажиллагаа явуулсанд тооцогдоно. Ийм байдалд, 1924 оны 8 сарын 16-нд Улаанбаатар хотод монгол улс, тувагийн бүгд найрамдах улсын хооронд хэлэлцээр хийгдэж хоёр талын харилцаа тогтоож, монгол улс тагна тувагийн бүгд найрамдах улсыг хүлээн зөвшөөрсөн байна. 1925 оны 8 сард коминтерны гүйцэтгэх товчоо тагна тувагийн ардын намын хөтөлбөрийн төслийг боловсруулсан байна. Уг хөтөлбөрт “тувагийн ардын хувьсгалт нам болон БНТУ монгол ардын хувьсгалт нам, монголын засгийн газраас харьяат бус биеэ даасан юм гэдгийг тодруулж өгсөн”[РЦХИДНИ, х.1-4] байна.

1921 оноос монгол ардын намаас тагна урианхай орныг буцаах гэсэн оролдлого нь 1925 он хүртэл даруй коминтерны нөлөөг гүн хүртсэн монгол ардын хувьсгалт намын 4 дүгээр их хурал (1925.9.23-10.2)-ын үеийн түүхт явдал болно. Энэ нь мөн коминтернээс монголд анги ялгаварлах бодлого улмаар хэцүүдэж, хувьсгалын дотоодод “баруунтан” хэмээн ялгаж цохилт өгч байсан үе юм. Дару тагна урианхай орныг монголдоо буцаах гэсэн оролдлого хийсэн этгээдэд баруунтны ял нөмрүүлжээ. Ийм байдалд, 1925 онд монгол улс нь БНТУ улсын тусгаар тогтнол нь хүлээн “зөвшөөрөгдөх”-өөс өөр аргагүй болов. “Лениний сургаал хүчтэй байсны үндэс болсон ар монгол дахь цагаан цэргийн хүчийг шүүрдэн арилгаж, дараа нь улаан цэргээр ар монголыг эрхшээж, тагна урианхай орныг илбэн дагуулж гартаа оруулах”[外蒙古事情, х.20] гэсэн төлөвлөгөө нь бодит түүхэн явдал болжээ. 1925 оны монгол улсын 2 дугаар их хуралд БНТАУ-ын тусгаар тогтнол нь зөвшөөрсөн тунхагийг нийтэлж, 1926 оны 8 сарын 16-нд Улаанбаатар хотод БНМАУ, БНТУ-ын хооронд нөхөрсөг харилцааны гэрээ байгуулсан юм. Тагна урианхай орныг монголоос салгаж БНТУ болгон байгуулсан нь япон зэрэг улсын элчин сайд нарын анхаарлыг татав. 1928 оны 7 сард японы элчин сайдын яамны 2 дугаар нарийн бичгийн дарга Миякава, цэргийн захирагч Күмэзүбэрэ нар москва дахь монголын элчин нарийн бичгийн дарга Гомбо, Галт нартай уулзаж тагна урианхай оронд БНТУ байгуулагдсан тухай асуув. Даруй “Тагна урианхай аль үндэстнийх болох, тусгай улс болсны учир юу вэ?, түүнийг оросын харьяат болсон хэмээх учир юу вэ?, танай төлөөлөгч байгаа эсэх, хаагуур хэрхэн харилцдаг”[Ч.Батбаяр, 2013, ISSN: 2791-1446

THE CULTURAL WAY

х.131] гэх мэтийн асуулт тавьж байв. 1929 оны 5 сард “Тагна тува болон БНМАУ-ын хилийн заагийг тогтоон тодруулах асуудлаар монгол – тувагийн комиссын хурлын протоколд гарсан үсэг зурсан”[АВПРИ, х.21-24] байна. Гэвч монгол тувагийн харилцаанд хилийн асуудал бүрмөсөн шийдвэрлэгдээгүй юм. 1932 онд ЗХУ-ын зуучлалаар монгол тувагийн хилийн комиссын хуралдааны гэрээнд гарын үсэг зурсан байна. Тус гэрээгээр газар нутгийн асуудал маргаантай бөгөөд бүрэн баталгаажаагүй үлдсэн”[РЦХИДНИ, х.61] юм. 1944 онд зөвлөлт орос тува бүгд найрамдах улсыг эрхэндээ оруулав. Одоогоор тагна урианхай орон оросын сибирийн холбооны улсын харьяанд багтаж, тува бүгд найрамдах улс (17 мянгаас дээш дөрвөлжин километр орчим) хэмээгдэх болов.

Яан Күйсүн (杨奎松 *yangkuisong*) “Дундад улс хийгээд зөвлөлт оросын холбоо байгуулсан ба үндэстний үзлийн зөрчил” гэх өгүүлэлдээ: “Аливаа улсын коммунист нам бол мөн чанартаа бүр үндэстний үзэлтэн мөн. Өөрөөр хэлбэл тэд нь улсын дотоодын улс төрийн асуудалд аль чадахаар эв хамтын үзлийн нөлөөг бадруулж, гадаад харилцааны талаар ихэнхдээ үндэстний үзлийн зориг санааг тусгадаг”[杨奎松, 2012, х.4] гэжээ. Энэ нь зөвлөлт орос, коминтерн ба монголын харилцаанд тагна урианхайг эзэлсэн явдал дээр бүрэн гэрчлэгдэнэ. Зөвлөлт орос улсаас коминтернээр хэлхээс болгож монголын өөртөө эзэрхэх эрхийг олох ба бататгах явцад дэмжлэг үзүүлсэн бодит түүхэн явдлыг үгүйсгэж болохгүй. Коминтерны зохион байгуулалтаас жижиг буурай хоцронгуй үндэстний нутагт тусламж үзүүлэх халхавч доор зөвлөлт орос нь монголын нутаг дэвсгэрээр золиос болгож, өөрийн ашиг тусаа харгалзаж байсан далдын улс төрийн зорилготой байсныг тагна урианхайн явдлаас харж болно.

ДҮГНЭЛТ

Зөвлөлт орос болон монголын харьцаанд коминтерноос олон зүйлийн улс төрийн үйл хэргийг гүйцэтгэж байв. Үүнд зөвлөлт орос улсын ашиг тусыг харгалзсан урьдач нөхцөлд Тагна Урианхай орныг монгол улсын нутаг дэвсгэрээс салгасан чухал агуулгыг багтаана. Монгол улс нь өөртөө эзэрхэх бүрэн эрхээ олох ба бататгах зорилтдоо хүрэхийн төлөө зөвлөлт орос улсаас дэмжлэг хүссэн онцгой түүхэн нөхцөл байдалд Тагна Урианхай орон нь зөвлөлтийн хүчний хүрээнд орж,

THE CULTURAL WAY

аажмаар ОХУ-ын нэг хэсэг болсон байна. Тус өгүүлэлд шинэхэн илрүүлсэн баримт бичгийг ашиглаж, Монгол Ардын Нам ба Коминтерны хоорондох улс төрийн харилцаагаар дамжиж, онцгой улс төрийн талбарт буй болсон Тагна Урианхайн тухай асуудал ба түүний түүхэн явц, шалтгаан, үр дүнгийн тухайд нягтлав.

THE CULTURAL WAY

НОМ ЗҮЙ

1. Э.Хүрэлбаатар. “Коминтерн Ба Монгол”, УБ., 1996
2. 【俄】Е. А 别洛夫著、陈春华译的《乌梁海问题》及《1915年至1919年期间争夺乌梁海的斗争》.《中国边疆史地研究》2000年第1.3期。
青木雅浩: モンゴル近現代史研究: 1921—1924年—外モンゴルとソビエト.コミンテルン.早稲田大学出版部.2011年3月.(第一部、第一章、第三节)
王春良 李蓉:《简论沙俄侵占中国唐努乌梁海》.聊城大学学报.2007年1期。
姚建明:《沙俄侵占我国唐努乌梁海地区》.历史学习.2002年3期。
赵云田:《唐努乌梁海历史资料汇编》评介.中国边疆史地研究.2001年9期。
樊明方:《1914年俄国侵占了唐努乌梁海哪些地方》.中国边疆史地研究导报.1989年
潘世宪:《唐努乌梁海与中原地区的关系》.内蒙古大学学报.1978年8期。
3. АВПРИ, ф Миссия в Пекине, оп 761/4, д 88
4. С.Г.Лузянин. “ХХ зууны эхэн хагас дахь Орос, Монгол, Хятад”, орч: Б.Доржханд, УБ., 2015
5. Монгол ардын үндэстний хувьсгал анх үүсэж байгуулагдсан товч түүх. I, УИБТК
6. 青木雅浩: モンゴル近現代史研究: 1921□1924年□外モンゴルとソビエト.コミンテルン.早稲田大学出版部. 2011年
7. ДВЛСР
8. МАХН-ын их ба бүгд хурлын тогтоолууд
9. РЦХИДНИ, ф.495, оп.152, д.97
10. Ч.Батбаяр. “Монгол ба их гүрнүүд 20 дугаар зууны эхэн хагаст”, ОУМССН, 2013
11. МУУТА.ф.445-д.1-х \ н .20-х .10; РГАСПИ, ф.495-оп.152, д.9
12. О.Батсайхан. “Монгол бүрэн эрхт улс болох замд”, ОУМССН, 2009
13. Вестник Ази -1911. №8
14. Ученые записки Тувинского научно-исследовательского института языка, литературы и истории.- Кызыл, 1960. Выл. 8
15. Kitad-ип tugai-NeyisIeI Kuriyen; MonggoI agad-un nan-un Keblel, olan-a ergugdegsen-u arban dorbeduger on 1924
16. АВПРИ, ф Миссия в Пекине, оп.761/4, д.887
17. 滿洲事情案内所編:《外蒙古事情》—外蒙の變遷とソ聯の外蒙侵略.滿洲事情案
18. АВП РФ.ф Референтура по Монголии, оп12, пор.4, пап 7, Д.100
19. 杨奎松:《中苏结盟与民族主义的碰撞》, 江淮文史, 2015

THE CULTURAL WAY

ABSTRACT

The Communist International plays a very important role in the relationship between Russia and Mongolia. On the premise of representing the interests of Soviet Russia, the Tannu Uriankhai areas were separated. In order to obtain independence, Mongolia asked the Soviet Union for help. The Tannu Uriankhai area was cut off and annexed by the Soviet Union. This paper refers to the newly discovered archives. By analyzing the relationship between the people's Revolutionary Party of Mongolia and the Communist International, this paper studies the historical causes and consequences in the Tannu Uriankhai area under special historical circumstances.

Key words: *Communist International, Mongolia, Tannu Uriankhai area*

**БНХАУ ДАХЬ УТГА ЗОХИОЛЫН МОНГОЛ ОРЧУУЛГЫН ЕРӨНХИЙ ТОЙМ
(1976-2000)⁴⁷****Тэргэл*****Кань Хай Ин*****ХУРААНГУЙ**

Тус өгүүлэлд Хятад улс дахь өнөөгийн утга зохиолын монгол орчуулгыг “Монгол орчуулгын утга зохиолын түүх”-ийн байдлаас системтэй судлахын учир шалтгаан ба судлагдахууны эргэн тойрон дахь өмнөх судлаачдын судалгааны байдлыг тоймлон өгүүлснээр суурь болгон 1976-2019 он хүртэлх хугацааны хятад улс дахь утга зохиолын ном, сэтгүүл, сонин зэргээр дамжин монгол хэлэнд орчуулагдсан байдлыг тодруулав.

Түлхүүр үгс: Орчуулгын утга зохиол, Монгол орчуулга, Түүхчлэл

Шинэ дундад улс (БНХАУ) байгуулагдсаны сүүлээр, хятад улс дахь өнөөгийн утга зохиолын монгол орчуулга нь хөгжлийн хүчээ авсан бөгөөд өнөөгийн монгол хятад утга зохиолын хамтын хөгжилд чухал нөлөө үзүүлжээ. Монгол орчуулгын утга зохиолын түүхийн талаас утга зохиолын монгол орчуулгыг системтэй шинжлэх нь монгол утга зохиолын түүх зүйн бүрэн шаардлага болж байгаа бөгөөд монгол хятад уран зохиолын харьцаа холбооны шинжлэлийн чухал агуулга болно.

**Нэг. Хятад улс дахь утга зохиолын монгол орчуулгыг судлахын
учир**

Библи (*Bibli-аруун ном, хуучин гэрээ*) бол орчуулгын эх үүсвэрийн тухай домог, хүн төрөлхтөн библиээс өмнөх цаг үед хэл адил

⁴⁷ Тус өгүүлэл бол Улын гүн ухаан нийгмийн шинжлэх ухааны судалгааны төсөл “Дундад улсын одоо үеийн утга зохиолын монгол орчуулгын түүх судлал”-ын суурь чанартай бүтээл болно. **Зөвшөөрсөн дугаар (21XZW036).**

* 2019 оны магистрант (ӨМИС, Монгол Судлалын Дээд Сургууль).

* Доктор, дэд профессор (ӨМИС, Монгол Судлалын Дээд Сургуулийн багш).

THE CULTURAL WAY

байжээ. Сүүлээр нь тэнгэр тулам “библи” суваргыг босгохоор оролдож, хурмастыг хилэгнүүлсэн учир сүүлд хэл нь өөрчлөгдөж, бүх газар оронд тархаагджээ. Үүний дараа, библийн дараах цаг үед шилжсэн байна. Энэ нь даруй орчуулгын цаг үе болно.

Монгол хэл дээр ном орчуулсан анхны мэдээ араб хэлээр бичиж байсан зохиолчдын номд байна. Энэтхэгийн алдарт үлгэр “Панчантра” (таван шастир)-ын нэг хэсэг Кэлил Димна хоёрын үлгэрийг 13 дугаар зууны дунд үед перс хэлнээс монгол хэлэнд ираны монголч эрдэмтэн Ифтихар Аддин Мухамид [Ц.Дамдинсүрэн, 1957, 2016, х.169] орчуулсан байна. Монгол орчуулгын түүхээс шинжилбэл, монголчууд уйгур, хятад, санскрит, төвөд зэрэг харь хэлний утга зохиолын зохиол бүтээлийг монгол хэлэнд орчуулж, монгол уран зохиол тус биеийн гол хөгжил ба хөндлөнгийн баялагжлыг ахиулж байжээ. Үүнд, хятад уран зохиолын орчуулга бол монгол орчуулгын уран зохиолын систем дэх өвөрмөц түүхэн дэвсгэр бүхий нэг салбар болно. Монгол хэлээр хятад үндэстний зохиол бүтээлийг орчуулсан түүхийн асуудлыг Юань улсын үе хүртэл мөшгөж болно. Гэвч юань улсын үеийн хятад хэл дээрхийг монголчлох илэрхий нэгэн онцлог гэвэл улс төрийн түүхэнд холбогдох зохиол бүтээлийн орчуулгаар голлож, утга зохиолын орчуулгын тухай тэмдэглэл байхгүй билээ [云峰, 1994, х.53]. Мин улсын үеийн 200 гаруй жилийн ноёрхлын хугацаанд умард юань улстай дайсагналын харьцаатай байсан тул монгол хятад орчуулга нь зогсонгуйрлын шатанд орж, зөвхөн “Монгол Нууц Товчоон”-ыг мин улсын бичгийн мэргэдийн хүрээлэнгийн шижян (侍讲 shi jiang) хариуцагч нараар хятад хэлэнд авиачлан орчуулжээ. Чин улсын ноёрхлын дунд ба сүүл (18-20 дугаар зууны эх) үед монгол хятад үндэстний ард түмний хоорондох харилцаа өдөр ирэхүй нягтрахтай зэрэгцэн хятадыг монголчлох ажил хүчтэй явагдах болов. Энэ үед их хэмжээний хятад шилдэг бүтээлүүд орчуулгаар дамжин монголын ард түмэнд танигдах болжээ [云峰, 1994, х.54]. Монгол үндэстний орчуулагч, утга зохиолын онолч Хасбуу “Улаан асрын зүүд”, “Эрт эдүгээгийн гайхамшигт үзэгдэл” зэрэг бүтээлийг монгол хэлэнд орчуулж, монгол үндэстний их зохиолч Инжинаш хятад уран зохиолын нөлөөгөөр “Нэгэн давхар асар”, Улаанаар уйлах танхим” зэрэг роман бүтээлийг туурвиж, хятадын хэмжээт шүлгийн сэдэлт дор монголжуу хэмжээт шүлгийг үүдгэсэн нь мөн энэ үеийн үйл хэрэг юм. Иргэн улсын үед хятадын хуучин туужийн орчуулга үргэлжилснээр үл

THE CULTURAL WAY

барам ардын дундах хэвлэлийн ажил хөгжиж, чин улсын үед гар бичмэл дэвтрээр тархаж байсан орчуулгын бүтээл нь хэвлэн тархаагдах болжээ.

Хятад уран зохиолын монгол орчуулга нь шинэ хятад улс байгуулагдсаны сүүлээр дахин хөгжлийн замдаа орсон байна. 1954 оны 8 сарын 19-ний өдөр, хятад улсын зохиолчдын нийгэмлэг жич ардын утга зохиолын хэвлэлийн хороо хамтарч, анх удаагийн бүх улсын утга зохиолын орчуулгын ажлын хурлыг хийжээ. Мао Дүнх тус хуралд “Утга зохиолын орчуулгын үйлсийг хөгжүүлэх ба орчуулгын чанар чансааг дээшлүүлэхийн төлөө” [查明建, 谢天振著, 2007, х.558] хэмээх сэдвээр илтгэл тавьсан байна. Энэ нь улсын орчуулгын ажлын сэргэлтийн илрэл болно. Үүний дараагаар, хятад уран зохиолын монгол орчуулга нь шинэ хөгжлийн шатанд шилжсэн бөгөөд өнөөгийн монгол хятад уран зохиолын солилцооны чухал хэлбэр болсон байна. Хятад улсын уран зохиол, ялангуяа 17 жилийн хугацааны уран зохиол бол Мао Зедун нөхрийн “Хэлсэн үг”-ээр хөтөлбөр болгосон нэг цогц дүрэмжүүллийн тогтолцооны бүтээгдэхүүн юм [Хайран, 2020, х.24]. Энэ нь өнөөгийн монгол хятад уран зохиолыг ондоо шинж чанар бүхий ижил бүтцэд систем (异质同构 yi zhi tong gou) –ийн шинж чанартай болгожээ. Хятад улсын өнөөгийн уран зохиолын монгол орчуулга нь энэхүү хөгжлийн ахицад өвөрмөц нөлөө үзүүлсэн байна. 50, 60-аад оны хөдөө тосгоны сэдэвт уран зохиол, хувьсгалт уран зохиолын орчуулга, шинэ эриний сүүлээр шарх сорвийн уран зохиол, бодлогошролын уран зохиол, өөрчлөлтийн уран зохиолын орчуулга зэрэг нь монгол хятад уран зохиолын хамтын хөгжлийн чиглэлтэй нийлж байдаг. Эдгээр орчуулгын ажиллагаа ба монгол утга зохиолын харилцаа холбоог монгол орчуулгын утга зохиолын түүхийн талаас системтэй судлах нь монгол утга зохиолын түүх зүйн системийн цогцлолын дотоод шаардлага болох бөгөөд өнөөгийн монгол хятад утга зохиолын харьцаа холбооны шинжлэлийн чухал агуулга болох юм.

Өнөөгийн орчуулга судлал хийгээд харьцуулсан утга зохиол судлалын хөгжилт нь манай судалгаанд онолын суурийг тавьж өгчээ. 1972 оны Копенгагенд болсон гурав дахь удаагийн олон улсын хэрэглээний хэл шинжлэлийн хуралд АНУ-ын эрдэмтэн Жеймс Холмес (James Holmes) илтгэлдээ “Орчуулга судлалын нэр ба үнэн” (The Name and Nature of Translation Studies) гэх талаар өгүүлсэн нь орчуулга судлалын тусгай шинжилгээний салбар болж хөгжихийн тунхаг болсон

THE CULTURAL WAY

гэж үздэг [谢天振主编, 2018, х.169]. Үүний дараагаар Итамар Зохар (Itamar Even Zohar)-ын олон ишт системийн онол (The Polysystem Theory) жич Лефевере (Andre Lefevere), Сузан Басснетт (Susan Bassnett) нараар төлөөлүүлсэн захирах (manipulation) онолыг дэмжигчид орчуулгын тухай ойлгогдохууны хувьсалыг буй болгожээ. Өмнөх судлаачдаас орчуулгыг хэлний суралцах арга барил хэмээн үзэж, түүний утга зохиол, соёл жич нийгмийн бүтцийн хоорондох будлиантай харьцааг үл ойшоож байжээ. Энэхүү хэлбийх үзлийг тэвчихийн туст, Лефевекийн зүгээс орчуулга бол нэг төрлийн өөрчилсөн бичиглэл (改写 gai xie), шүлэг зүй ба үзэл ухамсрын нөлөөг хүртэнэ гэжээ. Орчуулга судлалын соёлын эргэлт нь орчуулга судлалыг хэл шинжлэлийн хүлээслэлээс аварч, судалгааны шинэ орон зайг нээж өгсөн байна [杨乃乔, 2014, х.346-347]. “Харьцуулсан утга зохиол судлаачдаас орчуулга судлалыг чухалчилж, орчуулга судлалд чухал нөлөө үзүүлсэн нь харьцуулсан утга зохиолын шинжилгээний салааны шинж чанартай нягт холбоотой. Олны мэдэхээр харьцуулсан утга зохиолын гол судлагдахуун бол адил бус улс үндэстний хоорондох утга зохиол нь харьцаа үүсгэх – хүлээн авч нөлөө тусгал гаргах гэвэл, заавал хэлний давааг давах хэрэгтэй. Үүнд орчуулга чухал нөлөө үзүүлж, харьцуулсан утга зохиол судлаачдын хамгийн анхаарах судлагдахууны нэг болсон байна” [谢天振, 2015, х.45]. “1931 онд, францын харьцуулсан утга зохиол судлалын эрдэмтэн Тиегем (Van Tieghem)-ийн Харьцуулсан утга зохиолын онол хэмээх бүтээлийн Зууч гэх долдугаар бүлэгт орчуулгын бичвэр ба орчуулагчийн асуудлыг тусгажээ [谢天振, 2020, х.186]. Уламжлалт нөлөө судлалын баримтлагчдын үзэхээр, харьцуулсан утга зохиол бол олон улсын утга зохиолын харьцааны түүх, орчуулга нь нэг зүйлийн утга зохиолын уламжлал тархаалтын арга хэлбэр болохын хувьд адил бус улс үндэстний утга зохиолын бодит харьцаа үүсгэсний гэрч баримт, мөн харьцууллын үндэслэл болно. Одоогоор харьцуулсан утга зохиол судлалын тал дахь орчуулга судлал нь нэн өргөн агуулахуунтай болжээ. Тэр нь нэг зүйлийн утга зохиол судлалын буюу соёл судлал [谢天振, 2015, х.47], “аливаа орчуулгын ажиллагааны үр дүн (орчуулгын бичвэр)-г нэгэн бодит хэргийн хувьд хүлээн авсан (даруй харьцуулсан утга зохиолын орчуулга судлалын хамгийн чухал нь өртгийн магадлал биш)-ы суурин дээр, утга зохиолын солилцоо, нөлөө, хүлээлт, тархалт зэрэг асуудлыг шинжилж

THE CULTURAL WAY

задална” [谢天振, 2015, х.49]. Орчуулгын утга зохиолын түүх судлал нь зөвхөн түүхэн материалын бөөгнөрөл төдий биш юм. Харин уран зохиолын түүхийн логикийн урьдач нөхцөлд олон тал, олон шатлалаас орчуулгын утга зохиол ба үндэстний утга зохиолын харьцаа, адил бус үндэстний утга зохиолын солилцоо зэрэг үзэгдлийн ард нуугдаж байх гүн давхаргын үндэс шалтгааныг тодруулах нь чухал байдаг.

Хоёр. Хятад улс дахь утга зохиолын монгол орчуулгын судалгааны байдал

“Хятад улс дахь өнөөгийн утга зохиолын монгол орчуулга” хэмээх судлагдахууны эргэн тойронд урьдах судлаачдын судалгаа нь дотоод логик харьцаа бүхий гурван чиглэлээр хөгжжээ. Нэгд, утга зохиолын орчуулгын онол судалгаа. Хоёрт, монгол орчуулгын утга зохиолын түүх судалгаа. Гуравт, өнөөгийн монгол хятад уран зохиолын харьцуулсан утга зохиолын судалгаа зэрэг болно.

(Нэг) Утга зохиолын орчуулга ба онолын судалгаа

Утга зохиолын орчуулгын онол нь нэг зүйлийн онцгой орчуулгын онолд харьяалагдана. Нэг талаар тэр нь орчуулгын ухааны нэг салбар, нөгөө талаар тэр нь утга зохиолын онолын нэг салбар буюу утга зохиолын онолын нэг зүйлийн үргэлжлэл, нэг зүйлийн нөхвөрлөл юм [王向远, 2015, х.224]. Өмнөх үед монгол утга зохиолын орчуулгын онолын тухай судалгаа нь орчуулгын ухааны тусгай бүтээлд хамрагдах буюу зарим нэг судалгааны өгүүлэл нийтлэгдэж байв.

1. Орчуулгын ухааны тусгай бүтээлд хамрагдсан байдал

М.Баясгалан, Ринчений “Орчуулгын ухааны суурь” (Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо, 1989 он) гэх бүтээлийн олон төрлийн зохиолын орчуулга хэмээх зургадугаар бүлэгт уран зохиолын орчуулгын тухай энгийн онцлог, баримжаа, орчуулгад тавих шаардлага, үлгэрийн зохиолын орчуулга жич шүлэг дууллын орчуулга зэрэг талаар өгүүлжээ. Пэрэнлэйн “Монгол орчуулгын найруулга” (ӨМАХХ, 1992 он) гэх бүтээл дэх “Улаан асрын зүүдний орчуулгын тухай” хэмээх тусгай өгүүлэл нь зохиогч хувь хүний орчуулгын үйлдэл дундаас онолжуулан өгүүлсэн зүйл болно. С.Хичээлтийн “Орчуулгын ухааны үндсэн онол” (ӨМАХХ, 2002 он) гэх бүтээлийн хоёрдугаар бүлэгт монгол хэлний орчуулгын онол судалгааны түүхэн уламжлалын тухай өгүүлэхдээ утга зохиолын орчуулгад холбогдох агуулгыг хамруулжээ. Жинхуарын

THE CULTURAL WAY

“Орчуулга зүй” (Өвөр Монголын Их сургуулийн хэвлэлийн хороо, 2004 он) гэх бүтээлийн Олон төрлийн орчуулга хэмээх дөрөвдүгээр бүлэгт уран зохиолын орчуулгын тухай, онцлог, орчуулагчид тавигдах шаардлага жич шүлгийн орчуулга зэрэг талаар өгүүлсэн нь М.Баясгалан, Ринчений “Орчуулгын ухааны суурь” лугаа адилавар бүтэцтэй болжээ. Ү Юй-ийн “Орчуулгын ухааны суурь мэдлэг” (Үндэстний хэвлэлийн хороо, 2009 он) гэх бүтээлийн Олон төрлийн орчуулга гэх хэсэгт туужийн зохиолын орчуулга ба шүлгийн орчуулгын тухай өгүүлж, мөн “Нэгэн давхар асар”, “Улаанаар уйлах танхим” зэрэг зохиолын хятад орчуулгын тухай, уран зохиолын орчуулгад тухайн үндэстний онцлогийг хадгалбал зохино гэх зэргээр хураангуйлан өгүүлсэн байдаг.

Дээр дурдсан олонх их дээд сургуулийн орчуулгын ухааны тусгай мэргэжлийн заах материалын шинжтэй бүтээл, утга зохиолын орчуулгын онолыг тусгай судалсан бүтээл байхгүй. Орчуулгын зохиол бүтээлийн тухай судалгаа нь хэт орчин үеийн хятадын сонгодог бүтээлийн орчуулгаар голлож, өнөөгийн орчуулгын зохиол бүтээлийн тухай судалгаа байхгүй байна.

2. Судалгааны өгүүлэл

Утга зохиолын орчуулгын онолд холбогдсон судалгааны өгүүлэл гуч гаруй нийтлэгдсэн байна. Судалгааны агуулгаас нь үзвэл, утга зохиолын орчуулгын шинж чанар, баримжаа жич орчуулах арга зэрэгт холбогдсон онтологич судлал ба орчуулагч, орчуулгын бичвэр ба орчуулгын шүүмж зэрэгт холбогдох гадаад судалгаа хэмээн хоёр төрөлд хувааж болно.

А, Онтологич судлал

Гончигийн “Уран зохиолын орчуулгын тухай товч өгүүлэх нь” (ӨМИС-ийн эрдэм шинжилгээний сэтгүүл, 1980.1), Сайшаалтын “Орчуулгад хэв маягийг илтгэх тухай” (Монгол хэл утга зохиол, 1988.1), Ү Юй-ийн “Монголжуу орчуулга гэх дурдалтын тухай” (Монгол хэл бичиг, 1991.4), С.Өлзийбатын “Уран зохиолын орчуулга дахь хоёр чиглэл” (Монгол хэл бичиг, 1996.8), “Яруу найргийн орчуулгын зарим асуудалд” (Монгол хэл бичиг, 1999.4), Яан Шяохуа-ийн “Шүлгийн орчуулгын тухай өчүүхэн үзэлт” (Монгол хэл бичиг, 2002.3), Мэргэнгуагийн “Утга зохиолын орчуулгын хэв маягийн тухай” (Монгол хэл бичиг, 2003.9), Ариунаагийн “Уран зохиолын орчуулгын шинж чанарын тухай” (Алтан түлхүүр, 2013.5) зэрэг өгүүлэлд утга зохиолын

THE CULTURAL WAY

орчуулгын утга зохиолын бус орчуулгаас ялгагдах өвөрмөц онцлог шинж, орчуулгын баримжаа, орчуулах арга ба орчуулгын хэв маяг зэргийг шинжилжээ. Судлаачдын уран зохиолын орчуулгын бүтээлч чанарыг нотлон өгүүлэх талаар үндсэндээ нэгджээ. Гэвч хэрхэн орчуулах вэ? гэсэн дэлхийн чанартай өнө удаан жилийн маргаантай асуудалд, шууд орчуулах (直译 zhi yi) буюу утгачлан орчуулах (意译 yi yi), адилтган орчуулах (归化 gui hua) буюу ондоошуулан орчуулах (异化 yi hua) сонголтод зөрөөтэй үзэл байдаг.

Эрдэмтийн “Уран зохиолын орчуулга дахь бүтээлч чанартай сэргээчлэлтийг таних учир – Translation study талаас монгол хятад орчуулгад шинэ агуулга нэмэрлэх нь” (Өвөр Монгол Үндэстний их сургуулийн ЭШС, 2015.3) гэх өгүүлэлд, уран зохиолын орчуулга дахь бүтээлч чанартай сэргээчлэлтийн үзэгдлийн тухай орчуулагч, хүлээн авагч ба хүлээн авах хэлний орчин зэрэг гурван талаар өгүүлж, уран зохиолын орчуулга нь нэгэнт уг зохиогч, орчуулагч, уншигчид жич хүлээн авах орчин тойрон зэрэг олон элементэд холбогдох эргэлзээтэй үйл ажиллагаа болсон хэмээн үзсэн байна. Хань Тан-ийн “Уран зохиолын орчуулга дахь бүтээлч сэргээчлэлийн илрэх хэлбэрийн тухай” (Монгол хэл бичиг, 2015.8) гэх өгүүлэлд, уран зохиолын орчуулга дахь бүтээлч сэргээчлэл нь өвөрмөц орчуулах, буруу орчуулах ба гээж орхигдуулах, сонгож орчуулах ба найруулан орчуулах, дам орчуулах ба өөрчилж орчуулах зэрэг бодит илрэлтэй байгааг өгүүлжээ. Ойрын жилд нийтлэгдсэн энэ хоёр өгүүлэл бол манай улсын харьцуулсан утга зохиол судлалын эрдэмтэн, орчуулгын онолч Ше Тяньжэнь 1999 онд “Орчуулга зүй” гэх бүтээлдээ анх дурдсан бүтээлч чанартай сэргээчлэл (创造性叛逆 chuang zao xing pan ni)-ийн онолын хүлээлт болно. Энэ нь монгол утга зохиолын орчуулгын онол судалгааны талыг дэлгэрүүлснээр үл барам, хэлний давхаргын шинжлэлээс нэн гүн давхаргын соёл, гоо зүйн шинжлэл зүг эргэлт эсэхийг ахиулсан байна.

В, Гадаад судалгаа

Орчуулагчийн судалгаанд М.Эрдэнэсангийн “Орчуулгын үйл хэрэгт ихийг бүтээгч оргил” (Монгол хэл бичиг, 1987.10), Тогтохын “Манай улсын соёлын гарамгай зүтгэлтэн алдарт орчуулагч Анчинхүүгийн тухай тэмдэглэх нь” (Монгол хэл бичиг, 1991.3), Сарангуагийн “Монгол орчуулгын үйлсийг нээлцсэн хүн – хянан орчуулагч Ринченкава-ийн тухай тэмдэглэв” (Монгол хэл бичиг, 1991.5),

THE CULTURAL WAY

С.Эрхэмийн “Үйлсийн замдаа жавхаа төгөлдөр яваа хүн – хянан орчуулагч Дүйнхоржавыг тэмдэглэв” (Монгол хэл бичиг, 1994.1) зэрэг зохиол нийтлэгдэж, нэр хүндтэй орчуулагчийн намтар, орчуулгын зохиол бүтээл, монгол орчуулгын үйлсэд үзүүлсэн гавьяа зүтгэл зэргийг нь дурдан өгүүлсэн байна. 2002 онд Өвөр Монголын ардын хэвлэлийн хорооноос хэвлүүлсэн “Монгол судлалын нэвтэрхий толь, утга зохиолын боть” –д өнөөгийн зохиолч ба орчуулагчийг хамтатган 131 нэрс жагсаан бичсэн байна. Энэ нь орчуулагчийн чухал чанар, нийгмийн байр суурь жич үнэ цэнийн тухай нэг хэмжээний нотолгоо болох боловч тусгай судалгааны бүтээл биш юм.

Өнөөгийн утга зохиолын орчуулагчийн тухай судалгаа нь Лю Шисань-ий “Содбилэгийн орчуулгын судлал” (Баруун хойдын үндэстний их сургууль, 2005 он) гэх магистрын өгүүллээс эхэлсэн байна. Тус өгүүлэлд, Содбилэгийн орчуулгын үйлсийг бүх талаар тоочин өгүүлж, шүлгийн орчуулга ба үлгэрийн зохиолын орчуулгынх нь хэв маягийг шинжилжээ. С.Бүрэнбаярын “Монгол орчуулгын үйлсэд үзүүлсэн Дугарсүрэнгийн гавьяа зүтгэл” (Алтан түлхүүр, 2011.4) гэх өгүүлэлд, Дугарсүрэнгийн хятад шүлгийг монголчлох үзлийн тухай өгүүлжээ. Ү.Начины “Орчуулгын тухай Н.Сайнцогтын үзэл баримтлалыг шинжлэх нь” (Хэл ба орчуулга, 2017.3) гэх өгүүлэлд, орчуулга ба хэлний орчин, орчуулга ба соёл заншил, орчуулга ба шинэ үгсийн бүрэлдэхүүн, орчуулагчдын эгнээ, монгол зохиолыг хятадчилах асуудал, орчуулгын ажиллагаан дахь хариуцлага зэрэг зургаан талаас Сайнцогтын орчуулгын тухай үзэл баримтлалыг өгүүлсэн байна. Ма Шүжэнь-ий “Б.Осорын орчуулгын онцлогийг товч шинжлэх нь” (Монгол хэл бичиг, 2018.7) гэх өгүүлэлд, Цэцэгт тал өгүүллэгийн орчуулгын талаар жишээлэн Осорын орчуулгын үг сонгох тал дээр хатуу хянамгай, монгол хэлний баялаг үгсийн санд суурилан урсам ойлгомжтой илтгэх, монгол сонгодог зохиолын хэл хэллэгийг элбэг сайхан хэрэглэх зэрэг онцлогийн тухай өгүүлжээ. С.Урсгалын “Чэнь Найшюн-ий хятадчилсан Б.Бүрэнбэхийн задгай шүлэг” (Монгол хэл бичиг, 2019.12) гэх өгүүлэлд Чэнь Найшюн-ий орчуулсан “Алтан уул”, “Өвлийн дотор хавар”, “Толь”, “Хавар эрт” зэрэг хятад орчуулгын оновч, амьдлаг, уянгалаг хэв маягийн тухай дэлгэрэнгүй гаргажээ.

Орчуулгын бичвэр судалгаанд Досономын “Ойлгох, илтгэх, хянах бол орчуулгын үйл ажиллагааны гурван явц мөн – Эцэс төгсгөлийн

THE CULTURAL WAY

монгол орчуулгын үг өгүүлбэрийн буруу орчуулгын жишээнд” (Хэл ба орчуулга, 2006.2) гэх өгүүлэлд Эцэс төгсгөл романы монгол орчуулга дахь үг өгүүлбэрийн алдаатай орчуулгыг өгүүлэхээр дамжин орчуулгын үйл ажиллагаан дахь ойлгох, илтгэх, хянах гурван явц жич хоорондын харьцаа холбоог шинжилжээ. Болорын “Улаанхадын орчуулгыг товч өгүүлэх нь” (Хэл ба орчуулга, 2013.2) гэх өгүүлэлд Улаанхад романы монгол орчуулга нь уг зохиолд үнэнч байхыг баримталсан суурин дээр, монгол хэлний илтгэх хэлбэрийг эрхэмлэн, зөв ойлгосон суурин дээр оновчтой илтгэх аргыг чухалчилсан тухай өгүүлэв. “Чоно тотем” романы монгол орчуулгын тухай товч шинжлэл – нэгдүгээр бүлгийн жишээн дээр” (Монгол хэл бичиг, 2015.4) гэх өгүүлэлд тус романы Ван Шю Ин нарын орчуулга ба монгол улсын Д.Болдбаатарын орчуулгыг харьцуулан шинжилж, үг хэрэглэлтийн талаарх ялгаа зөрөө байгаа эсэх шалтгааныг эрэлхийлэв. У.Төмөрбатын “Шүлэг найрууллын орчуулгад орон нутгийн соёлын элементийг хэрхэн улируулан зохицуулах тухай – Лю Лянчэнь-ий “Шиньжянд” хэмээх найрууллын түүврийг монголчилсон жишээн дээр” (Хэл ба орчуулга, 2017.3) гэх өгүүлэлд, шүлэг найрууллын орчуулгад орон нутгийн соёлын элементийг улируулан зохицуулах тухай үгсийн утга, үг өгүүлбэрийн санаа, өгүүлбэр зүй жич хөг айзам зэрэг талаар өгүүлсэн байна. Ургамалын “Эцэс төгсгөл романы хоёр монгол орчуулгыг харьцуулсан судлал” (БаХҮИС, 2018 он) гэх магистрын өгүүлэлд тус романы хоёр зүйлийн монгол орчуулгын бичвэрийг үндэстний хэл соёл, шүлэглэх хэл жич хийсвэр нууц орон зай зэрэг талаас нь харьцуулан шинжилжээ.

Орчуулгын шүүмж судалгаанд Ринчений “Монгол орчуулгын шүүмжийн тухай бодолхийлэл” (Монгол хэл бичиг, 1993.5) гэх өгүүлэлд монгол орчуулга дахь тусгай шүүмжийн эгнээ буй болгохыг санаачлав. Эрдэмтийн “Уран зохиолын орчуулгын шүүмжийн төрөл хэлбэрийн тухай” (Монгол хэл бичиг, 2015.12) гэх өгүүлэлд номын шүүмж захидал сул тэмдэглэл ба эрдэм шинжилгээний өгүүлэл тусгай бүтээл хэмээн уран зохиолын орчуулгын шүүмжийг нарийн шинжилж, өмнөх нь хойнохдоо нөлөөлвөл зохино гэх үзлээ дэвшүүлжээ. “Уран зохиолын шүүмжийн шинж чанар төрөл хэлбэр ба нөлөө чадамжын тухай” (Өвөр Монголын нийгмийн шинжлэх ухаан, 2016.1) гэх өгүүлэлд уран зохиолын орчуулгын шүүмжийн шинж чанар, төрөл хэлбэр жич нөлөө чадамжын тухай өгүүлж, орчуулгын шүүмжид шинжлэх ухаанч чанарыг

THE CULTURAL WAY

буй болгох, судалгааны агуулга ба үр бүтээлийг дүрэмжүүлэх зэргээр санаачлага гаргасан байна.

Тоймлон өгүүлэхэд, монгол утга зохиолын орчуулгын онол судалгаа нь онтологи судлалаар голлож, гадаад судалгаанд хэдийгээр олон зүйлийн туршилт илэрч байх боловч зөвхөн хөврөл буюу эхлэлийн шатандаа байсаар байна. Өнөөгийн монгол орчуулагчийн тоо хэмжээ ба монгол утга зохиолын орчуулгын үйл ажиллагааны үр бүтээл (орчуулгын бичвэр)-ээс үзвэл, энэ талын судалгаа нэлээд хомс байна.

(Хоёр) Монгол орчуулгын утга зохиол ба түүхийн судалгаа

Монгол орчуулгын үйл ажиллагааг анх ажиглаж, утга зохиолын түүхийн үүднээс өгүүлсэн эрдэмтдэд Б.Содном, Ц.Дамдинсүрэн нарыг дурдаж болно. Тэд “Монголын утга зохиолын түүхчилсэн төлөв”, “Монгол уран зохиолын тойм” бүтээлдээ орчуулгын утга зохиол хэмээх нэрийг анх дурдан гаргасан байна [Кань Хай Ин, 2014, х.2]. Үндэстний утга зохиолын системд, орчуулгын утга зохиолыг хүлээн зөвшөөрөх нь эцэстээ хоёр талаар үнэлэгдэнэ. Нэгд, улс (үндэстэн)-ын ялгаатай уран зохиолын түүх бичлэгт орчуулгын утга зохиол нь байваас зохих байр сууриа олох, хоёрт, харьцангуй тусгаар орчуулгын утга зохиолын түүх найруулж бичих болно [谢天振, 2020, х.186].

Доор монгол уран зохиолын түүх бичлэг хийгээд монгол орчуулгын утга зохиолын түүх судалгааны байдлаас үзвэл:

1. Монгол уран зохиолын түүх бичлэг дэх орчуулгын утга зохиол

Монгол уран зохиолын түүх бичлэгт монгол улсын Б.Содномын “Монгол утга зохиолын хөгжлийн түүхчилсэн төлөв” (Шинжлэх ухаан, 1946. УБ №12-13), Ц.Дамдинсүрэнгийн “Монгол уран зохиолын түүх” (ӨМАХХ, 1957 он), Ц.Дамдинсүрэн, Д.Цэнд нарын “Монгол уран зохиолын тойм” (ӨМАХХ, 1983 он), Д.Цэрэнсодномын “Монгол уран зохиол” (ҮнХХ, 1989 он), Мансангийн “Монголын уран зохиолын түүх” (Өвөр Монгол сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо, 1980 он), Т.Сайнбаярын “Дундад улсын монгол үндэстний өнөөгийн утга зохиолын түүх” (ӨМСоХХ, 1988 он), Б.Сүх, Буянтогтохын “Монгол уран зохиолын хөгжлийн товчоо” (ЛяҮХХ, 1996 он), Б.Сүхийн “Монгол уран зохиолын хөгжлийн түүхийн удиртгал” (ӨМСоХХ, 2000 он), Рүн Сүх нарын “Монгол уран зохиолын түүх” (хятад) (ӨМАХХ, 2000 он), “Монгол судлалын нэвтэрхий толь, утга зохиолын боть” (ӨМАХХ, 2002 он) зэрэг бүтээлд монгол уран зохиолын түүхэн дэх энэтхэг, төвөд, хятад

THE CULTURAL WAY

уран зохиолын монгол орчуулгын тухай адил бус хэмжээний тэмдэглэл байдаг. Дээрхээс “Монгол уран зохиолын түүх” (Мансан, 1980 он) “Монгол уран зохиолын хөгжлийн товчоо” (Б.Сүх, Буянтогтох 1996 он), “Монгол уран зохиолын түүх” (Рүн Сүх нар, 2000 он) зэрэг гурван бүтээлд орчуулгын утга зохиолын тухай адил бус талаас шинжилсэн байна. Нэгдүгээр бүтээлд, хятад улс дахь монгол уран зохиолын түүх судлалын хүрээ хэмжээнд анх удаа энэтхэг төвөд уран зохиолын орчуулгын хөгжлийг уран зохиолын түүхийн нэг хэсгээр үзсэн байдаг. Хоёрдугаар бүтээлд, энэтхэг төвөд хятад орчуулгын уран зохиолд адилхан байр суурийг олгож, онолын өндөрлөгөөс хөгжлийн жам хуулийг нээх гэж оролдсон байна. Гуравдугаар бүтээлд, орчуулгын уран зохиол бол монгол уран зохиолын түүхийн бодит бүтэц дэхь чухал бүрэлдэхүүн хэсэг хэмээн үзэж, чухал бүхий зохиол бүтээлийг нарийн, гүнзгий судалж, монгол уран зохиолын түүх судлалыг шинэ өндөрлөгт түлхэн ахиулсан байна [乌日斯嘎拉, 2003, х.9].

2. Монгол орчуулгын утга зохиолын түүх судалгаа

1986 онд ӨМАХХ-оос хэвлүүлсэн Ринченкавагийн “Монгол орчуулгын түүхийн хураангуй тойм” хэмээх жижиг товхимол бол монгол үндэстний орчуулгын түүхийг ерөнхийлөн судалсан анхны бүтээл болно. Тус бүтээлд хятад уран зохиолын монгол орчуулгыг тусгасан боловч монгол орчуулгын утга зохиолын түүхийг тусгайлан судалсан бүтээл биш юм.

С.Урсгалын ӨМИСЭШС –ийн 1999 оны №4 нийтэлсэн “Монгол орчуулгын утга зохиолын түүх жич ач холбогдол” гэх өгүүлэлд анх удаа орчуулгын утга зохиолын ухагдахуун, байр суурь жич хөгжлийн хандлагыг өгүүлж, монгол орчуулгын утга зохиолын түүхийг шинжлэх нь, монгол утга зохиолын түүх зүйг цогцлоох чухал явц мөн хэмээх үзлээ дурджээ. Тус өгүүлэл нь хойшид монгол орчуулгын утга зохиолын түүхийг системтэй судлахад арга зүйг тавьж өгчээ.

Кань Хай Ин-ий “Лү Шюнь-ий зохиол бүтээлийн монгол орчуулга жич нөлөө тусгал” (ӨМИС, 2005 он) гэх магистрын өгүүлэлд хятад улсын орчин үеийн том зохиолч Лү Шюнь-ий зохиол бүтээлийн монгол хэлэнд орчуулагдсан байдлыг баялаг материал цуглуулгад суурилан, бүх талаас нь тоочин өгүүлж, Лү Шюнь-ий зохиол бүтээлийн монгол орчуулга, утга зохиол дахь нөлөө тусгалыг шинжилсэн байна. “Монгол үндэстний хятад улсын орчин үеийн орчуулгын утга зохиолын

THE CULTURAL WAY

түүх судлал (1947-1976)” (ӨМИС, 2008 он) бол түүний докторын зэрэг хамгаалсан өгүүлэл болно. 2014 онд ӨМАХХ-оос хэвлүүлжээ. Тус бүтээл нь тусгай сэдэвт үечилсэн түүх, 1947-1976 оны хоорондох хятад улсын орчин үеийн утга зохиолын монгол орчуулгын судалгаа юм. “Хятад улсын орчин үеийн утга зохиолын монгол орчуулгын түүх судлал (1976-2013) хэмээх бүтээл (кирилл, УБ 2021 он) бол Кань Хай Ин-ий 2021 онд биелүүлсэн, улсын гүн ухаан нийгмийн шинжлэх ухааны төсөл байж, дээрх бүтээлийн цаг үеийн талаарх үргэлжлэл хийгээд агуулгын талаарх гүнзгийрүүлсэн судалгаа болно. Энэ хоёр бүтээл нь өнөөгийн монгол орчуулгын утга зохиолын түүх туурвилын анхны туршилт болсны хувьд, өнөөгийн монгол орчуулгын утга зохиолын түүхийн судалгаанд нэг зүйлийн хэв загвар болж өгсөн байна. Кань Хай Ин-аас монгол орчуулгын утга зохиолын хөгжлийн түүхэн төрхийг сэргээхээр хичээж, орчуулгын утга зохиолын монгол утга зохиол дахь нөлөө тусгалыг харьцуулсан утга зохиолын онолын аргаар судалсан нь маш бүтээлч оролдлого болжээ.

Линь Чүнъянь-ий “Шинэ хятад улс байгуулагдсаны сүүлээр 17 жилийн турш дотоод гадаадын уран зохиолын монгол орчуулгын судлал” (БХҮНИС, 2016 он), Саруулын “Соёлын хувьсгалын үеийн монгол орчуулгын ажлын судалгаа” (БХҮНИС, 2015 он), Бао Линлин-ий “Хятад гадаадын уран зохиолын шинэ цаг үе дэх монгол орчуулгын судалгаа” (БХҮНИС, 2016 он) зэрэг магистрын цол хамгаалсан цуврал өгүүлэлд, 1949-1997 оны хоорондох хятад уран зохиолын монгол хэлэнд орчуулагдсан байдлыг тоймлон өгүүлж, орчуулгын онцлог шинжийг дүгнэсэн байна. 2020 онд ҮнХХ-оос хэвлүүлсэн Тэнгисийн “Монгол үндэстний орчуулгын түүх судлал” (хятад) гэх бүтээлийн дэд хэсэг – “БНХАУ байгуулагдсаны дараах монгол орчуулга”-ын өмнөх гурван бүлэг ба дээрх гурван өгүүллийн агуулгын давхцлын хэсэг болох юм.

Үүнээс гадна, Хасчулуугийн “Монгол уран зохиолын түүх бичлэг дэх орчуулгын уран зохиолын байр суурийн тухай” (ӨМНШУ, 2019.5) гэх өгүүлэлд монгол орчуулгын уран зохиолыг монгол уран зохиолын түүх бичлэгт багтаан оруулж, монгол орчуулгын уран зохиолын түүх туурвин бичвэл зохино гэх үзлээ дэвшүүлжээ. Дорнохүүгийн “БНХАУ-ын уран зохиолын монгол орчуулгын ном бүтээл ба судлал (1947-1965)” (ӨМИСЭШС, 2021.4) гэх өгүүлэлд 1947-1965 оны хоорондох хятад уран зохиолын монгол орчуулгын ном хэвлэлээр тархаасан байдлыг хэд хэдэн

THE CULTURAL WAY

шат үед хуваан шинжилж, орчуулгын онцлог жич монгол утга зохиол дахь нөлөө тусгалыг шинжилжээ.

Монгол уран зохиолын түүх бичлэгт орчуулгын уран зохиолыг багтаан оруулж байсан уламжлалтай. Гэвч энэхүү уламжлал нь түүхэн хөгжлийн явцдаа тасалдсан байна. Одоогоор эрдэмтдээс орчуулгын уран зохиолын түүх бичлэг дэх байр суурийг сэргээх буюу тусгай судалгаа өрнүүлэхийг хичээж байна. Монгол уран зохиолын түүхэнд харилцан адилгүй байр суурь байдаг. Эдүгээ хятад уран зохиолын монгол орчуулгын тухай судалгааны байдлаас үзвэл, судлагдахууны хувьд БНХАУ-ын орчин үеийн утга зохиолын монгол орчуулга буюу хятад уран зохиолын монгол орчуулга хэмээх хоёр төрлийн хязгаарлалт (界定 *jiè dìng*) байдаг. Орчуулгын зохиол бүтээлийн тархалтын дамжуулагчийн хувьд уламжлалт ном хэвлэлээр дамжин орчуулагдсан байдлын тухай судалгаа хангалттай биш байна. Орчуулгын утга зохиолын монгол утга зохиол дахь нөлөө тусгалын шинжлэлийн туршилт илэрч байх боловч, мөн үргэлжлүүлэн гүнзгийрүүлэх нь чухал юм.

(Гурав) Өнөөгийн монгол хятад уран зохиолын харьцуулсан судалгаа

Өнөөгийн монгол хятад уран зохиолын харьцуулсан судалгаа нь монгол утга зохиолынхны харьцуулсан утга зохиол судлалын онол аргыг хүлээн авсан байдалтай шууд холбогдоно. Чэнь Ганлүн профессорын 2009 онд нийтэлсэн “Өөрчлөлт нээлтийн гучин жилийн монгол харьцуулсан утга зохиол судлалын эргэцүүлэл ба бараалал” (改革开放三十年蒙古比较文学研究回顾与展望 *gaige kaifang sanshi nian menggu bijiao wenxue yanjiu huigu yu zhanwang*) (ӨМБИСЭШС, хятад, 2009.1) гэх өгүүллээс харж болох нь өмнөх үеийн монгол харьцуулсан утга зохиол судлал өрнө дорнын харьцуулал, эртний уран зохиол, ардын аман зохиолын харьцууллын хүрээнд төвлөрч, орчин үеийн Лү Шюнь-ий зохиол бүтээл ба монгол уран зохиолын харьцуулсан судалгааг гаргавал, өнөөгийн монгол хятад уран зохиолыг харьцуулан шинжилсэн бүтээл маш хомс байжээ. Гэвч 2009 оны наана цаана, өнөөгийн монгол хятад уран зохиолын харьцуулсан судалгаа нэгэнт хөвөрч эхэлсэн байна.

1. Судалгааны бүтээл

Баярын найруулсан “Харьцуулсан утга зохиолын өгүүлэмж” (ӨМАХХ, 1993 он) бол монгол утга зохиолынхны хамгийн анхны харьцуулсан утга зохиолын тусгай бүтээл болно. Тус бүтээлийн тэргүүн

THE CULTURAL WAY

хэсэгт харьцуулсан утга зохиолын үндсэн ухагдахуун (Хэтцахиур), судлалын агуулга (Яан Баяр) жич үүсэл хийгээд хөгжлийн тухай өгүүлж, дэд хэсэгт Гэрэл, Хэтцахиур, Ч.Баатар, Ринчендорж нарын монгол утга зохиол ба дэлхийн утга зохиолыг харьцуулан шинжилсэн 6 өгүүллийг хураангуйлжээ. Үүнд, Хэтцахиурын “Монгол орчуулгын уран зохиол – нөлөө судлалын чухал сэдэв” гэх өгүүлэлд харьцуулсан утга зохиолын нөлөө судлалын талаас орчуулгын утга зохиолын шинж чанарыг өгүүлж, монгол орчуулгын утга зохиолын монгол уран зохиол дахь төрөл хэлбэрийн талаар нөлөөллийг маш нарийн задалжээ. Ч.Баатарын “Харьцуулсан утга зохиол ба монгол утга зохиол” (ӨМАХХ, 2002 он) гэх бүтээлд харьцуулсан утга зохиол ба монгол утга зохиолын хамтын хөгжлийн хандлага, харьцуулсан утга зохиолын судалгааны хүрээ хэмжээ, арга, онолын тэлэлт хийгээд монгол утга зохиол дахь үйлдэл туршилт, монгол шүлэг зүй ба харьцуулсан шүлэг зүй, соёл алсалсан судалгаа ба монгол уран зохиол зэрэг агуулгыг хамруулжээ. Энэ хоёр бүтээл нь монгол утга зохиолынхонд харьцуулсан утга зохиол судлалын онол аргыг авч ирсэн чухал бүтээл болох боловч өнөөгийн монгол хятад утга зохиолын харьцуулсан судалгааны тусгай бүтээл биш юм.

Намиагийн “Өнөөгийн монгол туужийн тайлал (1949-1966)” (ӨМИС, 2005 он) гэх бүтээл нь арга зүйн санаачлалыг зорих үүднээс 17 жилийн монгол туужис ба хятад уран зохиолын харьцаа холбоог харуулсан утга зохиолын аргаар шинжилжээ. Хайрханы “Өнөөгийн монгол шүлгийн ерөнхийлсөн судлал” (ӨМИС, 2005 он) хэмээх бүтээлийн хөндлөнгийн нөлөөл ба шинэчлэлийн асуудал гэх тавдугаар бүлэгт монгол шинэ шүлгийг эрт эдүгээ гадаад дотоодын утга зохиолын системд байршуулан шинжлэхдээ өнөөгийн монгол хятад шүлгийн нөлөөллийн харьцааны тухай шинжилсэн байна.

Дээрх хоёр бүтээл дэх өнөөгийн монгол хятад утга зохиолын харьцуулсан утга зохиол судлалын туршилт нь хойшдын судалгааны суурийг тавьжээ.

2. Судалгааны өгүүлэл

Өнөөгийн монгол хятад уран зохиолын харьцуулсан утга зохиол судлалд нэг бүлэг магистрын цол хамгаалсан өгүүлээр гол болгожээ. Хуарын “Шинэ эриний монгол туужийн орчуулгад холбогдсон соёл зүйн асуудал” (ӨМИС, 2007 он), Бао Хөгжилтийн “Хятад үндэстний роман бичлэг дэх монгол дүрийн судлал – Жинь Юн ба Жян Рун-ий зохиол

THE CULTURAL WAY

бүтээлээр жишээлэх нь” (ӨМИС, 2010 он), Ван Сараанын “Чоно тотемын адил бус соёлын тойрог дундах хүлээлт” (ӨМИС, 2012 он), Яргуйгийн “Жан Чэнжы-ийн туужис хүүрнэл дэх тал нутаг” (ӨМИС, 2013 он), Улаантуяагийн “Сэхээтэн залуучуудын туужис хүүрнэл дэх Тал нутаг – Лао Гүй-ийн Цуст өнгөтэй шар бүрий роман хийгээд Жян Рун-ий Чоно тотем романаар жишээлэх нь” (ӨМИС, 2013 он), Үзэсгэлэнгийн “Соёлын хувьсгалын сэдэвт монгол хятад туужийн харьцуулал – зохиогчийн үзэл ойлголтыг туурвих нь” (ӨМИС, 2013 он), Ли Соргогийн “Цагаан бугатын шил монгол уран зохиолд” (ӨМИС, 2014 он), Чэн Рэнь-ий “Монгол хятад уран зохиолын харьцаан дахь А.Одсэр” (ӨМИС, 2014), Хасчимэгийн “Нөлөө судлалын байдалд Б.Бүрэнбэхийн шүлэг туурвил” (ӨМИС, 2015 он), Амилангийн “Харьцууллын байдалд монгол үндэстний соёл мөрдлөгийн туужис” (ӨМИС, 2017 он), Учралсайханы “Монгол үндэстний 17 жилийн утга зохиолын хятад үндэстний утга зохиолын хүрэн дэх тархалт ба хүлээлт” (ӨМИС, 2018 он) зэрэг арваад өгүүлэл нь харьцуулсан утга зохиолын дүр зүй судлалын аргаар хятад уран зохиол дахь монгол дүр буюу монгол уран зохиол дахь хятад дүрийг шинжлэх, харьцуулсан утга зохиолын сэдэв судлалын аргаар адил утга сэдвийн монгол хятад уран зохиол дахь адил бус илрэлийг шинжлэх, орчуулга – тархаалт – хүлээлт – нөлөө тусгал хэмээх үндсэн логигоор монгол хятад утга зохиолын хос чиглэл (монгол-хятад, хятад-монгол) солилцоог шинжлэх, харьцуулсан утга зохиолын үзэл урсгал судлал зэрэг агуулгыг хамарсан байна.

Хайрханы “ 17 жилийн монгол хятад уран зохиолын адилсах харьцааны ажиглалт” (Тайлал ба залгамжлал: ӨМХУЗСБЭШХ, Хөх хот 2020 он) гэх өгүүлэлд 17 жилийн монгол хятад утга зохиолын Мао Зөдун-ий “Хэлсэн үг”-ээр хөтөлбөр болгосон “Дүрэмжүүллийн тогтолцоо”-оос болж, адилсалын харьцаа буй болсон тухай өгүүлж, өргөн талын ойлгогдохуун – зохион бүтээх арга, хөгжих чиглэл жич гоо сайхны дээд баримжаа зэргийн нэгтгэл, бичил талын агуулга – урлагийн загварын адилсал, хүүрнэлийн далд бүтцийн адилсал зэрэг харьцуулсан утга зохиолын нөлөөлөлцлийн үзэгдлүүдийг анх дурджээ.

Үүнээс гадна, Чимэгийн “БНХАУ-ын эмэгтэйчүүдийн уран зохиол ба монгол үндэстний эмэгтэйчүүдийн уран зохиолын судалгааг харьцуулан ажиглах нь” (Дундад улсын монгол судлал, 2005.3), Оюунцэцэгийн “20 дугаар зууны 50, 60-аад оны хятад монгол

THE CULTURAL WAY

найрууллыг харьцуулан шинжлэх нь” (ӨМНШУ, 2011.4), Сацрангуйн “Хар шороон газар ба Тафу-ийн харьцуулал” (ӨМҮНИСЭШС, 2021.3), Аясын “Өлзийбүрэнгийн Наргүй 20 өдөр ба Янь Лянькө-ийн Амьдрахуйн харьцуулал” (Алтан гарди, 2021.5) зэрэг өгүүлэл нийтлэгджээ.

Өнөөгийн монгол хятад уран зохиолын харьцуулсан судалгаа нь зөвхөн арваад жилийн түүхтэй боловч, өмнөх үеийн судалгаанд олон зүйлийн туршилттай бөгөөд зарим үнэ цэнэтэй үзлүүд дурдагдсан байна. Энэ нь хойшдын судалгаанд чухал суурь дэвсгэр болж өгчээ.

Гурав. БНХАУ-ын өнөөгийн утга зохиолын монгол орчуулгын тойм байдал (1976-2000)

Тус өгүүлэлд 1976-2000 он хүртэлх хугацаан дахь БНХАУ-ын өнөөгийн утга зохиолын ном, сэтгүүл, сонин (Өвөр Монгол өдрийн сонин) зэрэг дамжуулагчаар дамжин монгол хэлэнд орчуулагдсан байдлыг шинжилжээ. БНХАУ-ын өнөөгийн утга зохиол гэх судлагдахуунд, хятад зохиолчийн хятад туурвил жич онц зарим нөлөө ихтэй цөөн тоот үндэстний зохиолч (төвөдийн Алай, хотонгийн Жан Чэнжы, эвэнкийн Үрэлт)-ийн зохиол бүтээлийн монгол орчуулгыг хамруулсан байна. Монгол зохиолчийн хятад хэлээр туурвисан зохиол бүтээлийн монгол орчуулгыг багтаахгүй. Орчуулгын зохиол бүтээлийн загвар төрлийг дөрөв ангилах аргаар шүлэг, туужис, найруулал, жүжиг хэмээн хуваарилсан суурин дээр, онол шүүмжийн бүтээлийн орчуулгыг багтаан судалжээ.

1. Орчуулгын ном хэвлэгдсэн байдал




Бүрэн бус бүртгэлийг үндэслэвэл, 1976-2000 он хүртэлх хугацаанд БНХАУ-ын өнөөгийн утга зохиолын монгол орчуулгын ном нийт 112 дэвтэр хэвлэгджээ. Орчуулгын номын тоо хэмжээний өөрчлөлтөөс монгол орчуулгын хөгжлийн хандлагыг шинжилбэл, 70-аад

THE CULTURAL WAY

оны үед 39 дэвтэр орчуулгын ном хэвлэгдэж, богино хугацаан дахь огцом өсөлт буй болжээ. Тэр мөртөө 1979 онд 17 дэвтэр орчуулгын ном хэвлэгдсэн нь судлан буй бүх үе дэх нэг жилийн орчуулгын хамгийн өндөр цэг болно. 80-аад онд 62 дэвтэр орчуулгын ном хэвлэгджээ. Энэ хэсэг хугацаанд хэдийгээр жил бүрийн орчуулгын бүтээлийн тоо хэмжээ нь 0-15 хооронд хэлбэлзэх боловч ерөнхий тоо хэмжээний талаар 70-аад оныг бодвол нэмэгдсэн болохоор хөгжлийн шат хэмээн үзэж болох юм. 90-ээд онд нийт 11 дэвтэр орчуулгын ном хэвлэгдэв. 70, 80-аад оны орчуулгын байдлыг бодвол, ерөнхий тоо хэмжээ нэлээд буурсан байна. Жил бүрийн орчуулгын номын тоо хэмжээ нь 0-3 хооронд оршиж, хэлбэлзэл бага, үндсэндээ бууралтын шатанд оржээ.



Загвар төрлийн хувьд, роман 52 дэвтэр, туужийн түүвэр 18 дэвтэр, найрууллын түүвэр 24 дэвтэр, шүлгийн түүвэр 4 дэвтэр, жүжиг зохиолын 3 дэвтэр, шүлгийн шүүмж 11 дэвтэр орчуулагджээ. Үүнд романы орчуулгын тоо хэмжээ хамгийн олон, бүх тооны 46% хувийг эзэлнэ. Хэрэв роман хийгээд туужийн түүврийн орчуулгыг хамтад нь бодвол бүх тооны 62%-ийг эзэлнэ. Жагсаавал, найрууллын түүвэр 21%, онол шүүмжийн ном 10%, шүлгийн түүвэр 4%, жүжгийн зохиол 3%-ийг тус тус эзэлж байна.




THE CULTURAL WAY

БНХАУ-ын өнөөгийн утга зохиолын монгол орчуулгын ном хэвлэлд ӨМАХХ чухал нөлөө үзүүлжээ. 1976-2000 оны хооронд нийт 70 дэвтэр ном хэвлүүлж, бүх орчуулгын номын 63%-ийг эзэлж байна. Жагсаавал, Үндэстний хэвлэлийн хороо 12 дэвтэр, Өвөр Монголын сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо 10 дэвтэр, Гириний ардын хэвлэлийн хороо 9 дэвтэр, Хар мөрний ардын хэвлэлийн хороо, Өвөр Монголын соёлын хэвлэлийн хороо, Өвөр Монголын шинжлэх ухаан техник мэргэжлийн хэвлэлийн хороо зэрэг бусад хэвлэлийн хороо нийт 11 дэвтэр хэвлүүлжээ.

Орчуулгын ном хэвлэгдсэн байдлаас монгол орчуулгын онцлогийг тоймлон үзвэл: Нэгд, хөгжлийн хандлага чиглэлийг ажиглавал, 70-аад оны сэргэлтийн шат, 80-аад оны хөгжлийн шат жич 90-ээд оны бууралтын шат хэмээх үндсэн логикт нийцэж байна. Хоёрт, орчуулгын бүтээлд туужийн зохиолын орчуулгын эзлэх харьцаа хамгийн өндөр, онцгойлон романы орчуулга нь бүх тоо хэмжээний 46%-ийг эзэлсэн байна. Гуравт, орчуулагчийн хувьд хэвлэлийн хорооноос орчуулах, ажлын чөлөөний орчуулгын дугуйлангаас орчуулах, олон хүн хамтран орчуулах, хоёр хүн хамтран орчуулах, ганц хүн орчуулах зэрэг үзэгдэл хамтдаа оршиж байна.

2. Сэтгүүл дэх орчуулгын байдал


1976-2000 он хүртэлх хугацаанд, БНХАУ-ын өнөөгийн утга зохиолын сэтгүүл дэх монгол орчуулгын ерөнхий тоо хэмжээ нь 262 зохиол байна. Орчуулгын зохиол бүтээлийн тоо хэмжээний хувиралаас монгол орчуулгын хөгжлийн хандлагыг шинжилбэл:



70-аад онд үндсэндээ хоосон байна. Зөвхөн 1979 онд 1 зохиол орчуулагдсан байна. 80-аад онд 104 зохиол бүтээл орчуулагдаж, өрнөлтийн байдал ажиглагджээ. 90-ээд онд 157 зохиол бүтээл орчуулагдаж, онцгойлон 2000 он болоход дан нэг жилийн орчуулгын

THE CULTURAL WAY

хамгийн өндөр цэг болж, жилд 47 зохиол бүтээл орчуулагдсан байна. Сэтгүүл дэх орчуулгын тоо хэмжээ нь 80-аад оноос 90-ээд он болоход илэрхий нэмэгдэх хандлагатай болжээ. Бодит сэтгүүлийн орчуулгын тоо хэмжээнээс үзвэл, Жиримийн уран зохиолд 38, Цолмонд 36, Хилчдэд 35, Шар мөрөнд 29, Өвөр монголын залуучуудад 29, Хөлөн буйрт 24, Хун галууд 22, Тураг сараанад 18, Өнөр цэцэгт 11, Дэлхийн утга зохиолд 10, Алтан гардид 4, Шилийн голд 4, Цэлгэр талд 2 зохиол бүтээл орчуулагджээ.




Загвар төрлийн хувьд, роман 11, тууж 14, өгүүллэг 78, найруулал 62, шүлэг 62, жүжиг 6, онол шүүмж 29 орчуулагджээ. Ерөнхийд нь үзвэл, өгүүллэгийн зохиолын орчуулгын тоо хэмжээ хамгийн өндөр, бүх тооны 30%-ийг эзэлнэ. Жагсаавал, шүлэг ба найрууллын орчуулгын тоо хэмжээ адил, тус бүр бүх тооны 24%, онол шүүмж 11%, тууж 5%, роман 4%, жүжиг 2% хувийг эзэлж байна.

Сэтгүүл дэх орчуулгын байдлыг ажиглан монгол орчуулгын онцлогийг хураангуйлбал: Нэгд, хөгжлийн хандлага чиглэлээс үзвэл, 80-аад оноос эхлэн өрнөж, 90-ээд оны эхэн дунд үеэр хөгжлийн байдал харьцангуй тогтуун, 90-ээд оны сүүлээр илэрхий нэмэгдэх хандлагатай, 2000 он болоход хамгийн өндөр цэгтээ хүрчээ. Энэ нь орчуулгын ном хэвлэгдсэн байдлын хөгжлийн хандлагаас зөрөөтэй байдаг. Хоёрт, сэтгүүл дэх орчуулга нь өгүүллэг, найруулал, шүлэг зэрэг төрлийн зохиол бүтээлийн орчуулгаар голлосон байна. Энэ нь сэтгүүлийн хуудас хэмжээний хязгаарлалтай шууд холбогдоно. Гуравт, орчуулагчдын хувьд ихэнх нь роман ба туужийг олон хүн хамтарч орчуулж, өгүүллэг, найруулал, шүлэг зэргийг нэг хүн дангаараа орчуулсан байна. Орчуулагч нь сэтгүүлийн ажилчдаас голлон бүрджээ.

3. Өвөр Монгол өдрийн сонин дахь орчуулгын байдал


THE CULTURAL WAY



1976-2000 он хүртэлх хугацаанд, Өвөр Монголын өдрийн сонинд орчуулагдсан зохиол бүтээлийн ерөнхий тоо хэмжээ нь 238 зохиол буй. Орчуулгын зохиол бүтээлийн тоо хэмжээний хувиралаас монгол орчуулгын хөгжлийн хандлагыг шинжилбэл, 70-аад онд 112 зохиол орчуулагдаж, 1977 онд 62 бүтээл орчуулагдсан нь судлан буй хугацааны хамгийн өндөр цэг болно. 80-аад онд 106 зохиол бүтээл орчуулагдаж, ерөнхий тоо хэмжээ нь багасаж, бууралтын хандлага илэрчээ. 90-ээд онд зөвхөн 20 зохиол бүтээл орчуулагдаж, үндсэндээ багасах шатанд оржээ.

Загвар төрлийн хувьд, шүлэг 127, найруулал 76, онол шүүмж 31, өгүүллэг 1, жүжгийн зохиол 1 орчуулагджээ. Роман ба туужийн орчуулга байхгүй. Ерөнхийд нь үзвэл, шүлгийн орчуулга хамгийн олон, бүх тооны 53%-ийг эзэлж байна. Туужийн зохиол ба жүжгийн зохиолын орчуулга нь мартагдах хэмжээнд хүрчээ.

Үүнээс гадна, судлан буй хугацаанд Өвөр Монголын өдрийн сонинд БНХАУ-ын өнөөгийн утга зохиолд холбогдсон сонин мэдээ нийт 70% нийтлэгдсэн байна.




Өвөр Монголын өдрийн сонин дахь орчуулгын байдлаас монгол орчуулгын онцлогийг тоймлон ажиглавал: Нэгд, хөгжлийн хандлага чиглэлээс үзвэл, ерөнхийдөө бууралтын хандлагатай байна. 70-аад он ба 80-аад оны орчуулга нь ерөнхий тоо хэмжээний талаар тийм ч их

THE CULTURAL WAY

зөрөөгүй боловч, 70-аад онд зөвхөн 4 жилийн цаг хугацаанд багтаж, 80-аад оны 10-аад жилд багтаж байгаа учраас мөн ч нэлээд хэмжээгээр буурчээ. Хоёрт, сонины орчуулгад шүлэг ба найрууллын загвар нь хамгийн идэвхтэй. Гэвч анхаарууштай нэгэн үзэгдэл нь 70, 80-аад онд хамгийн олон орчуулагдаж байсан шүлгийн загвар нь 90-ээд он болоход үндсэндээ зогсонгуйрч, 10 жилийн хугацаанд зөвхөн 1 шүлэг орчуулагджээ. Гуравт, 90-ээд оноос эхлэн Өвөр Монголын өдрийн сонин дэх дундад улсын өнөөгийн утга зохиолд холбогдох сонин мэдээ нэлээд олширчээ. Энэ нь монгол хятад утга зохиолын солилцоонд идэвхтэй нөлөө үзүүлсэн байна.

1976-2000 он хүртэлх хугацаанд БНХАУ-ын өнөөгийн утга зохиол нь ном, сэтгүүл, сонин зэрэг адил бус дамжуулагчаар дамжин монгол хэлэнд орчуулагджээ. Адил бус дамжуулагчийн монгол орчуулгын хөгжлийн хандлага нь харьцангуй будлиантай юм. Онцгойлон 80-аад оны сүүлээр уламжлалт ном хэвлэлийн орчуулга ба тус сонин дахь орчуулга нь бүгд бууралтын хандлагатай, харин сэтгүүл дэх орчуулга үргэлжлэн нэмэгдсэн байна.



Адил бус дамжуулагчдад адил бус давуу тал ба дутагдалтай тал байдаг. Орчуулгын утга зохиолын систем дэх тухайн зохиол, тухайн зохиолын зохиогч, найруулагч, орчуулагч, хэвлэлийн компани, уншигч, үзэл ухамсрын хэлбэр, орчуулагдах хэлний утга зохиол, соёлын систем жич төрийн бодлого зэрэг чухал элементүүд нь адил бус дамжуулагчийн орчуулгын ажиллагааг адил бус хэмжээнд нөлөөлнө. Дээрх тоо бүртгэл нь бидэнд нэг зүйлийн үзэгдэл буюу үр дүнг харуулсан бол үүний ар дахь гүн давхаргын үндэс шалтгааныг сүвэгчлэх нь дараачийн алхамд шаардагдаж буй ажил юм.

THE CULTURAL WAY

ДҮГНЭЛТ

БНХАУ-ын өнөөгийн утга зохиолын монгол орчуулга бол монгол орчуулгын утга зохиолын нэгэн онцгой бүрэлдэхүүн хэсэг, орчуулгын утга зохиолын түүхийн талаас системтэй судалгаа хийх нь чухал юм. Тус судлагдахууны эргэн тойронд өмнөх хүмүүсийн утга зохиолын орчуулга, орчуулгын утга зохиолын түүх жич харьцуулсан утга зохиол судлал зэрэг талаас шинжилсэн нь бидний судалгаанд ашигтай нөхцөлөөр хангаж өгчээ. 1976-2000 оны хоорондох цаг хугацаанд хятад улсын өнөөгийн утга зохиол нь ном хэвлэл, уран зохиолын сэтгүүл жич сонин зэрэг олон дамжуулагч сувгаар монгол хэлэнд орчуулагдан тархаагджээ. Энэ нь монгол утга зохиолынхонд хэрхэн хүрч байгаа, ямар нөлөө тусгал үзүүлж, аль давхаргын харьцаа холбоо бүрэлдсэн тухай улам лавшруулан судлах хэрэгтэй байна.

THE CULTURAL WAY

НОМ ЗҮЙ

1. Ц.Дамдинсүрэн. “Монгол уран зохиолын түүх”, ӨМАХХ, 1957, 2016
2. Хайрхан. “17 жилийн монгол хятад уран зохиолын адилсах харьцааны ажиглалт”, Хөх хот, 2020
3. Кань Хай Ин. “Монгол үндэстний орчин үеийн орчуулгын утга зохиолын түүх судлал”, ӨМАХХ, 2014
4. 云峰: 《蒙译汉在蒙汉文学交流中的重要地位》，《前沿》，1994 年
5. 查明建, 谢天振著: 《中国 20 世纪外国文学翻译史》(上卷), 湖北教育出版社, 2007 年
6. 谢天振主编: 《当代国外翻译理论》，南开大学出版社, 2018 年
7. 杨乃乔: 《比较文学概论》北京大学出版社, 2014 年
8. 谢天振: 《翻译文学新视野》，福建教育出版社, 2015 年
9. 谢天振: 《译介学概论》，商务印书馆 2020 年
10. 王向远: 《翻译文学导论》北京师范大学出版社, 2015 页
11. 乌日斯嘎拉: 《蒙古族翻译文学史研究述评》，《内蒙古师范大学学报》，2003 年

ABSTRACT

Mongolian translation of contemporary Chinese literature is a special component of Mongolian translation literature, and it is important to conduct a systematic study of the history of translated literature. An analysis of previous subjects in terms of literary translations of previous people, as well as comparative literary studies of the history of translated literature, provided a useful environment for our study. Between 1976 and 2000, contemporary Chinese literature was translated into Mongolian through a number of channels, including books, literary magazines, and newspapers. There is a need to study in more detail how this is reaching Mongolian literature, what impact it has had, and which strata have been formed.

Key words: *Translated literature, Mongolian translation, historical research*

**ДӨРВӨЛЖИН ҮСГИЙН ХИЧЭЭНГҮЙ ТИГ БА ТҮҮНИЙ БИЧЛЭГ
ЗУРЛАГЫН ОНЦЛОГ****Ургаа *****ХУРААНГУЙ**

Дөрвөлжин үсэг нь улсын үсгийн хувьд Юань улсын дотоод төв засаг захиргаа, цэргийн явдал, аж ахуй, шашин суртахуун зэрэг төр засгийн аливаа үйл ажиллагаанд үгийг дааж хэргийг нэвтрүүлэх үүрэг чадамжаар хэрэглэгдэн, төрийн эрх тушаал, сүр хүчний бэлгэдэл болжээ. Иймээс Юань улсын дотоодод төрийн зарлигийг дамжуулах гэрээ пайз, захиа бичиг, эрх тушаалын төлөөлөл болсон тамга тэмдэг, шашны үйлд холбогдох сүм хийдийн чимэглэл бичээс, хөшөө дурсгал зэрэг бүгдэд дөрвөлжин үсгийг хэрэглэж байв.

Түлхүүр үгс: Дөрвөлжин үсэг, хичээнгүй тиг, бичлэг зурлага

Нэг. Дөрвөлжин үсгийн хичээнгүй тигийн үүсэл гарал

Дөрвөлжин үсгийн цагаан толгойн тухай сурвалж бичигт тэмдэглэснийг үндэслэвэл “Юань улсын түүх”-д: “Жунтун-ы анхдугаар (1260) онд Шизу хаан сууринд суусны хойно Пагва ламыг улсын багшаар өргөмжилж, хас тамга шагнан, монгол шинэ үсгийг зохиотугай хэмээн зарлиг буулгасанд үсгээ зохиогоод өргөжүхүй. Түүний үсэг нь 1000 гаруй байж, цагаан толгойн үсэг нь дөчин нэг болой”⁴⁸ хэмээн дөрвөлжин үсгийн цагаан толгойн тоог дөчин нэг гэж тэмдэглэжээ. Гэхдээ цагаан толгойн үсгийг жагсаагаагүй ажээ.

Монгол үсгийн дуудлага бол Юань улсын үеийн дөрвөлжин үсгээр хятад хэлийг галиглан бичих чухал хэрэгсэл болох бичиг болно. Тэр нь дөрвөлжин үсгээр хятад хэлийг галиглах хэлбэр ба арга зарчимыг бүх талаар системтэй харуулсан байна. Монгол үсгийн дуудлагад


* Хэл утга зохиолын докторант (ӨМИС-ийн Монгол Судлалын Дээд Сургууль).

⁴⁸ 宋濂等：《元史》，中华书局，1987年


THE CULTURAL WAY

жагсаасан цагаан толгойд хичээнгүй тигийн цагаан толгой жич харгалзсан гур тиг тэмдэглэгдсэн байдаг.

Монгол үсгийн дуудлага дахь хичээнгүй тигийн цагаан толгойн жагсаалт:



(Зураг 1.)



(Зураг 2.)

Монгол үсгийн дуудлага нь одоогоор олоод байгаа дөрвөлжин үсгийн цагаан толгойг тэмдэглэсэн сурвалж бичгийн хамгийн эртний бичиг болно. Түүний зохиогдсон цаг хугацааны тухай Сун Хунминь, Нин Жифу, Зуунаст, Лю Жэньюй зэрэг эрдэмтдийн судалгаа болон дөрвөлжин үсгээр бичигдсэн хятад хэл дээрх сурвалж бичигт шинжилгээ хийсний дүнд “дөрвөлжин үсгийн материалаас < монгол үсгийн дуудлага >-ын зохиогдсон цаг хугацааг ажиглах нь”⁴⁹ хэмээх өгүүлэлдээ монгол үсгийн дуудлага нь 1275 оны үед нэгэнт зохиогдсон болохыг тодорхойлжээ. Энэ нь монгол үсгийн дуудлагад тэмдэглэгдсэн дөрвөлжин үсгийн цагаан толгой нь тус үсгийн анхны цагаан толгойг болно гэдгийг батлах боломж юм.

Дөрвөлжин үсгийн цагаан толгой нь Юань улсын харьяа Көчи улсын уйгур гаралтай уран бичээч Шэн Шимин-ий “Дүрэмжит бичгийн магадлал”⁵⁰, Мин улсын эхэн үеийн Тао Зун И-ийн “Бичгийн түүхийн чухал хураангуй”⁵¹ зэрэгт мөн тэмдэглэгдэн үлджээ. Эдгээр бичиг материал нь дөрвөлжин үсгийн цагаан толгойг тэмдэглэсэн чухал эх сурвалж болох материалууд юм. Юань улсын түүх, хэл шинжлэлийн

⁴⁹ 宋洪民：《从八思巴字文献材料看‘蒙古字韵’成书时间》，《语言研究》，2010年第4期，页22

⁵⁰ 盛熙明：《法书考》，Хасбагана “Монгол хэлний түүхэн улирал хувирал ба сурвалж бичгийн судлал” х 5

⁵¹ 陶宗仪：《书史会要》，Хасбагана “Монгол хэлний түүхэн улирал хувирал ба сурвалж бичгийн судлал” х 5

THE CULTURAL WAY

бичиг монгол үсгийн дуудлага, бичиг түүхийн чухал хураангуй дахь цагаан толгойг үсэг нь 41 байж, “Бичлэг үлгэрийн шинжлэл” дэх цагаан толгойн тоо нь 43 болно. Бичлэг үлгэрийн шинжлэл дэх гурвыг хасах дөрвийг нэмэх гэх тэмдэглэлээс үзэхэд мөн дөрвөн үсгийн цагааг толгой нь 41 болно.

Хичээнгүй тигийн үсгийн бүтэц тогтолцооны тухай эрдэмтэд анхааран судалсаар иржээ. Эрдэм шинжилгээнд дөрвөлжин үсгийн тухай энэтхэг санскрит цагаан толгой ба төвөд үсгийн цагаан толгойг үндэслэсэн, үсгийн дүрс хэлбэрийг төвөд үсгээр жишээ болгосон, цагаан толгойг ажиглавал төвөд үсгийн нэгэн зүйлийн өвөрмөц бичлэг гэж андуурам, монгол хэлийг тэмдэглэсэн эгшиг үсэгтэй төвөд үсэг гэх мэтийн адил бус хандлагаар нэрлэсэн нэрийдэл байдаг.

Дөрвөлжин үсгийн үсгийн хэлбэр дүрсийн үүсэл гарлыг ажиглавал тус үсэг төвөд санскрит үсэгт үндэслэн зохиогдсон нь тодорхой. Юань улсын сүүлч, Мин улсын эхэн үеийн Тао Зун И-ийн “Бичгийн түүхийн чухал хураангуй”-д тэмдэглэсэн нь “*Хааны багш Пагва бол төвөд улсын хүн, цол нь ... язгуур нь умард газар байгуулсан тул эртний борогиуу хэв заншлыг эрхэмлэдэг, модыг сийлж итгэмж болгох нь улсыг зангидах лугаа адил болой. Түүний дараа, умард оронд хонины арьсан дээр бичиг бичих нь хулсан бичиг лүгээ адил ажгуу. Сүүлд нангиад эзэлж, санскрит үсгүүдийг цуглуулж улсын үсэг зохиохыг Пагвад тушаажээ, түүний гавьяа бага бус. Үсэг нь 41 ажгуу*”⁵² хэмээн цагаан толгойн үсгийг жагсаажээ. Эрдэмтэн Зуунаст “*Дөрвөлжин үсэг нь төвөд үсэг болон санскрит үсэгт үндэслэгдэн зохиогджээ. Түүний бүх цагаан толгой нь цөм энэхүү хоёр үсгээс гаралтай. Ихэнх нь төвөд үсгээс үүсэлтэй. Санскрит үсгээс үүсэлтэй гурван үсэг буй*”⁵³ гэж дөрвөлжин үсэг болон төвөд, санскрит үсгийн цагаан толгойн харгалзсан хүснэгтээр жагсаан үзүүлсэн байдаг. Үүгээр үл барам дөрвөлжин үсгийн үсэг бүтээх дараалал нь уйгуржин монгол үсгийн үсэг зүйн зарчимыг баримталсан байна.

Үүний тухай эрдэмтэн Ш.Лувсанвандан “Дөрвөлжин, тод үсгийн зөв бичих дүрэмд монгол хэлний урт эгшгийг хэрхэн тэмдэглэсэн бэ?”⁵⁴

⁵² Ө.Мандах: “Пагва лам ба дөрвөлжин үсэг”, ӨМЭШС, 1987 № 2, х 60

⁵³ 照那斯图: 《八思巴字母表和藏文梵文关系的认定》, 《蒙古语言文化学论丛》(第一卷), 民族出版社, 2009年, 页194

⁵⁴ Ш.Лувсанвандан: “Дөрвөлжин, тод үсгийн бичих дүрэмд монгол хэлний урт эгшгийг хэрхэн тэмдэглэх вэ?”, Орчин үеийн монгол хэлний тухай өгүүллүүд, ӨМСХХХ, 1986, х 203

THE CULTURAL WAY

гэх өгүүлэлдээ “Төвөд энэтхэг үсгийн зөв бичих дүрэм, түүгээр үл барам уйгуржин монгол үсгийн зөв бичих дүрмээс жишээ авсан газар цөөнгүй байна ...”⁵⁵ гэжээ. Эрдэмтэн Жалсан “Дөрвөлжин үсэг ба энэтхэг төвөд үсгийн харьцаан асуудал” гэсэн өгүүлэлдээ дөрвөлжин үсгийн хэлбэр бүтцийн асуудлыг шинжлэн, энэтхэг төвөд үсгийн бичлэгийн хэлбэрээс эх авсан газар буй хэмээв.

Эрдэмтэн Зуунаст “Монгол үсэг болон дөрвөлжин үсгийн элементийн задлал”⁵⁶ гэх бүтээлдээ “Уйгуржин монгол үсэг болон дөрвөлжин үсэг нь үүсэл гарлын хувьд адил бус байсан ч авиа илтгэх арга хэлбэрийн хувьд бага бус нийтлэг онцлог байдаг. Үүнд зарим нь дотоод харьцаа холбоотой байдгаар үл барам шууд уламжлах харьцаа ч байж болох бололцоотой”⁵⁷ хэмээжээ.

Эрдэмтэн Жарчуудай Жараннэг дөрвөлжин үсгийн үсгийн бүтцийг үүсэл гарлын хувьд мөн маш нарийн тайлбарласан билээ. Тэрбээр дөрвөлжин үсгийн эгшгийн тэмдэг болон төвөд үсгийг харьцуулан шинжин, дөрвөлжин үсгийн эгшиг үсэг ба түүний үсгийг тэмдэглэсэн аргын тухай өмнөх эрдэмтдийн үзлээс өөр үзлийг дурджээ. Тэрээр “Дөрвөлжин бичгийн эгшиг тэмдэглэх аргын учир” хэмээх өгүүлэлдээ дөрвөлжин бичигт төвөд бичгийн гийгүүлэгчийг тэмдэглэх аргыг үндэслэн, монгол хэлэнд гийгүүлэгч байхгүй байдлаар төвөд бичгийн «-ийн аймгийн үсгээр дөрвөлжин үсгийн эгшиг үсгүүдийг боловсруулсан байна хэмээн үзжээ. Төвөд үсгийн «-ээр суурь үсэг, төвөд үсгийн бусад эгшгийн тэмдгээр нэмэлт тэмдэг болгон уйгуржин монгол үсгийн гол барилаар бичиглэх аргыг хэрэглэн эгшиг үсгийг бичиглэсэн гэж үзсэн байна. Эрдэмтэн Жарчуудай Жараннэгийн эгшиг үсгийн бүтцийн тухай үзлийг хураангуйлан үзүүлвэл: 1. Үсгийн эхний эгшгийг тэмдэглэсэн байдал

⁵⁵ Ш.Лувсанвандан: “Дөрвөлжин, тод үсгийн бичих дүрэмд монгол хэлний урт эгшгийг хэрхэн тэмдэглэх вэ?”, Орчин үеийн монгол хэлний тухай өгүүлүүд, ӨМСХХХ, 1986, х 203

⁵⁶ 照那斯图: 《八思巴字母表和藏文梵文关系的认定》, 《蒙古语言文化论丛》(第一卷), 民族出版社, 2009年, 页194

⁵⁷ 郑尚芳: 《〈蒙古字韵〉所代表的音系及八思巴字一些转写问题》, 《李新奎教授纪念文集》, 中华书局, 1998年

THE CULTURAL WAY

Эрдэмтэн Жарчуудай Жараннэг дөрвөлжин үсгийн анхны хэлбэрийг доорх мэтээр таамаглажээ: \mathfrak{B} , \mathfrak{BT} , \mathfrak{BT} , \mathfrak{BT} , \mathfrak{BT} , \mathfrak{BT} , \mathfrak{BK} , \mathfrak{BT} , \mathfrak{BT} зэрэг үсгүүд болно.

2. Үгийн дунд адагт орох эгшигийг тэмдэглэсэн байдлыг доорх мэтээр таамаглажээ. Үгийн дунд, адагт орох дүрсэд \mathfrak{L} -ийг хэрэглэн, \mathfrak{L} , \mathfrak{LT} , \mathfrak{LT} , \mathfrak{L} , \mathfrak{L} , \mathfrak{L} , \mathfrak{L} гэх дүрс зохиосон болов уу хэмээн таамагласан байдаг.

Энэхүү суурин дээр эрдэмтэн Жарчуудай Жараннэг дахин үзлээ лавшруулан, үүнийхээ дараа Пагва лам эгшиг үсгийн үгийн эхэнд орох дүрсэд зохих хялбарчлал хийсэн нь дан нэмэлт тэмдэгтэй үсгийн \mathfrak{B} -ийг хөндлөн (–) зураасаар илтгэж, түүнээ нэмэлт тэмдэгтэй нь холбоосоор холбосноор эцэстээ дөрвөлжин бичгийн эгшиг үсгүүдийн сүүлийн үед хүмүүст харагддаг, үгийн эхэнд орох тэдгээр дүрс боловсрон тогтсон гэдгийг онцолсон байна. \mathfrak{L}

үсгийн тухай: “нэмэлт тэмдэг \mathfrak{L} -ийг \mathfrak{L} -тэй нь холбоосоор холбохдоо бусдаач нь ялгаатайгаар зүүн талыг нь холбожээ. Тэгээд ингэж холбож үүсгэсэн \mathfrak{L} нь нэмэлт тэмдгээр ч хэрэглэгдэх болж угийн \mathfrak{L} хэлбэрийг бүрэн орлосон байна. Энэ нь \mathfrak{L} -ийг энгийн үсэгтэй адилхан том бичихээс болж дөрвөлжин хэлбэртэй болгох гэсэн санаа бололтой”⁵⁸ жишээ болгон хүснэгтэд үзүүлвэл:

⁵⁸ 照那斯图:《八思巴字字母表和藏文梵文关系的认定》,《蒙古语言文化学论丛》(第一卷),民族出版社,2009年,页194

THE CULTURAL WAY

Хичээнгүй тигийн эгшиг үсэгт дундад зууны монгол хэлний эгшиг авиа [a]-г тэмдэглэх тусгай тэмдэг байхгүй. Түүнийг дан хэлбэрээр илтгэдэг. Дөрвөлжин үсэгт 𐰃(𐰄) 𐰅 𐰆 𐰇 гэх таван үндсэн тэмдэг байдаг.

Дугаар		1	2	3		4	5	6	7	8
ᠮᠤᠰᠤᠯᠢᠭ	Үгийн эхэнд	ᠮ	ᠮᠣ	ᠮᠤ		ᠮᠡ	ᠮᠢ	ᠮᠦ	ᠮᠦ	ᠮᠦ
	Хялба р хэлбэр	ᠮ	ᠮ	ᠮ		ᠮ	ᠮ	ᠮ	ᠮᠦ	ᠮᠦ
	Эхэн бус	ᠮ	ᠮ	ᠮ		ᠮ	ᠮ	ᠮ	ᠮᠦ	ᠮᠦ
Галиг		ᠮ	ᠮ	ᠮ		ᠮ	ᠮ	ᠮ	ᠮᠦ	ᠮᠦ

Энэхүү
үндсэн таван
эгшиг
тэмдэг нь
тус тус
дундад
зууны
монгол
хэлний [e],
[è], [i], [o],

[u] зэрэг авиаг тэмдэглэнэ. Дундад зууны монгол хэлний [ö][ü] эгшгийг эдгээр үндсэн тэмдгийн нийлмэл хэлбэр 𐰃ᠬ 𐰃ᠬᠦ -ээр тэмдэглэдэг. Бүтцийн хувьд тэдгээр нь хятад үсгийн элементээс бүтсэн нийлмэл үсэг болно. 𐰆, 𐰅, 𐰆, 𐰃 зэрэг үндсэн тэмдгийн эхний | нь 𐰃 -ийн нэг зүйлийн хувилбар бөгөөд түүний хялбарчилсан хэлбэр болно. Эдгээр нь тус тус төвөд үсгээс гаралтай. Үсэг болон төвөд үсгийн хоорондох харьцаа нь дараах мэт байна. 1 – 𐰅 нь төвөд хэлний ᠡ-аас үүсэлтэй, 2 – 𐰆 нь ᠢ-ийн доош хандсан хэлбэр, 3 – 𐰃 үсэг нь төвөд үсгийн ᠣ-ийн доош хандсан хэлбэр, 4 – 𐰄 үсэг тэмдгийн үүсэл гарлын тухай адил бус хоёр үзэл байдаг. Зарим эрдэмтэд түүнийг ᠡ-ийн хувилбар гэдэг. Зарим нь ᠡ-ийн доош хандсан хэлбэр хэмээн үздэг байна. Үүгээр үл барам дөрвөлжин үсгийг дээрээс доош гол мөрөөр, зүүнээс баруун тийш мөр дараалан бичдэг нь уйгуржин монгол үсгийн бичиглэлийн дарааллаас эс авсан болохыг илтгэж байна.

Хичээнгүй тигийн гийгүүлэгч үсгийн ихэнх нь төвөд үсэгтэй их зөрөө байхгүй, эдгээр гийгүүлэгч үсэг нь үгийн эхэн, дунд, адагт орохдоо адил дүрсээр бичигдэнэ. Дөрвөлжин үсгийн цагаан толгойн бүрэлдэхүүнд 34 гийгүүлэгч үсэгтэй байдаг. Гийгүүлэгч үсэг нь хойноо **а** –ийн тиг хэлбэрийг авч **а** –тай дуудагдана. Үүнд 27 гийгүүлэгч үсэг нь төвөд үсгийг шууд тухайн хэлбэрээр нь шилжүүлэн авсан буюу зурлага нэмэх ба хасах байдлаар бага зэрэг өөрчилсөн байдаг. Дөрвөлжин үсэг нь улсын үсэг болсны хувьд олон үндэстний хэлийг тэмдэглэх

THE CULTURAL WAY

зорилготой байжээ. Иймээс 27 гийгүүлэгч үсгийн дээр бас 4 шинэ гийгүүлэгч нэмэгдсэн байна. Үүнд хэлний угийн авиа ᠠ kg, ᠠ g –ээс улиран гарсан хүүхэн хэлний авиа ᠠ q ᠠ G ᠠ kh ᠠ g зэрэг дөрвөн үсэг тэмдгийг шинээр нэмэв. Нөгөө шинээр нэмэгдсэн хоёр үсэг нь ᠠ ᠠ, ᠠ ᠠ –ээс бүрэлдсэн шинэ үсэг болно.

Хоёр. Хичээнгүй тигийн бичлэг зурлагын онцлог

Хубилай хаан Жунтун-ы анхны онд дөрвөлжин үсэг зохиох зарлиг буулган, Жи Юань-ий зургадугаар (1269) оноос эхлэн хэрэглэжээ. Энэ мэтчилэн уг зарлигт Хубилай хаанаас шинэ үсэг зохиох түүхэн ахуй байдал ба хэрэгцээг дурдан гаргахын хамт шинэ үсгийн нэрийдэл хэрэгцээ ба байр суурийг тогтоожээ. Дөрвөлжин үсгийн хичээнгүй тиг нь анх зохиогдсон суурь үсэг болж, хөгжлийн явцад нь гур тиг, дөрвөлжин тиг болон хоё гогт тиг гэх мэтээр урлагжив. Одоогоор олоод байгаа хичээнгүй тигийн сурвалж бичигт монгол хэлний материал, хятад хэлний материал, төвөд хэлний материал, уйгур хэлний материал зэрэгт байдаг. Материалын төрөл зүйлд голдуу хөшөө сийлмэл, тамга, пайз тэмдэг, албан бичиг, ном судар зэрэг багтах юм.

(Нэг) Хичээнгүй тигийн эгшигийн тэмдгийн бичлэгийн онцлог

Дөрвөлжин үсгийн эгшиг үсгийн үндсэн тэмдэг нь төвөд үсгийн эгшигийн тэмдгийг эгц тэгшхэн хэлбэртэй болгосноос хүмүүст төв, хурц дөрвөлжин бөгөөд хатуу харагддаг.

1. ᠠ үсгийн дүрс зурлага

Тус эгшиг үсгийн тухай эрдэмтэд бүх талаас нь судалсаар иржээ. Тус үсгийн тухай “төвөд үсгийн ᠠ эгшигийн тэмдгээс үндэслэн зохиогдсон”, “хагас эгшигийг илтгэх ᠠ үсгээс үндэслэгдсэн” гэх мэтийн үзлүүд буй. Эрдэмтэн Зуунастаас тус үсгийн тухай мөн анхааран судлахдаа доорх мэт хэдэн шатанд хуваан үзжээ.

Нэг. Анхан тус үсгийн дээд талын хөндлөн зураас ᠠ нь үгийн титэмтэй адилхан, баруун талын босоо зураас нь дөрвөлжин үсгийн холбоостой адилхан, доод талын зурлага нь төвд хэлний эгшигийн тэмдэг ᠠ -тэй адил байна. Иймээс тус үсгийг нийлмэл зурлагаас бүтсэн үсэг болно гэж үзэж байжээ.

Хоёр. Сүүлийн үед эрдэмтэн Зуунастаас Жэнжан Шанфан-ий дөрвөлжин үсгийн ᠠ эгшиг ᠠ (i)-ийн хувилбар болно гэх энэхүү үзлийг

THE CULTURAL WAY

зөвшөөрөн, хэдэн талаас нь нотолсон байна. “Нэгд - 𐎠 болон 𐎡 -ийн бичлэг зурлага нь нэлээд адилавар. Хоёрт - дөрвөлжин үсгийн 𐎠 нь биеэ даан хэрэглэгдэхгүй, үгийн эхэнд илрэхгүй, харин гийгүүлэгчийн ард хэрэглэгдэнэ. Тус үсгийн үүрэг чадамж нь бусад дөрвөн нийлмэл үсэг (𐎢, 𐎣, 𐎤) үсгээр эрс өөр юм. Гэвч тусгаар хагас эгшигийг илтгэх 𐎡 (𐎢) үсэг нь үүрэг чадамжийн хувьд 𐎠-тэй нэлээд адил. Гуравт - хятад үсгийг галиглахад төгсгөлийн авиа -п, -п -ийн өмнө зөвхөн хагас эгшиг 𐎡 илэрнэ, харин 𐎠 биш юм. Иймээс 𐎠 болон 𐎡 нь сэлгэн илрэх үзэгдэл буй. Жишээ нь g[an] ~geŋ. Дөрөвт - гур тигийн бичлэгт тус хоёр үсгийн бичлэг зурлагын хэлбэр нь бараг ялгаа байхгүй. Тэдгээр нь иймэрхүү нөхцөлдөх харьцаанд оршно. Иймээс дөрвөлжин үсгийн 𐎠 нь хагас эгшиг 𐎡 -ээс үүсэлтэй гэж үзэж болно”⁵⁹ хэмээжээ.

Хятад эрдэмтэн Жэнжан Шанфан-аас: “Дөрвөлжин үсгийн 𐎠 эгшиг 𐎡 (i)-ийн хувилбар болно”⁶⁰ гэж үзжээ. Жалсангийн зүгээс тус үсэг нь төвөд үсгийн 𐎢 -ээс үүсэлтэй хэмээв. Жарчуудай Жараннэгээс тус үсгийг төвөд үсгийн 𐎢 -ээс гаралтай гаралтай гэж үзэн, 𐎢 үсгийн хялбарчилсан хувилбар | -тэй холбоосоор холбохдоо бусдаас ч ялгаатайгаар зүүн талыг нь холбожээ. Тэгээд ингэж холбож үүсгэсэн 𐎠 нь нэмэлт тэмдгээр ч хэрэглэгдэх болж тухайн 7 хэлбэрийг бүрэн орлосон байна. Энэ нь 7-ийг энгийн үсэгтэй адилхан том бичихээс болж дөрвөлжин хэлбэртэй болгох гэсэн санаа бололтой гэжээ.

Бид Жарчуудай Жараннэг багшийн үзлийг дэмжиж буй. Учир нь дөрвөлжин үсэг нь анхандаа монгол хэлэнд зориулан зохиогдсон юм. Иймээс анх зохиогдсон дөрвөлжин үсгийн 𐎠 үсэг нь дундад зууны монгол хэлний [e]-г тэмдэглэх тэмдэг болохоор төвөд хэлний e-тэй харгалзсан үсэг байх ёстой. Тус үсэг нь хятад хэлний [é,i] –тэй харгалзсан байдал нь тухайн үеийн хятад хэлний авиалгын байдалд холбогдсон байх боломжтой юм.

2. 𐎢 (𐎣) үсэг

⁵⁹照那斯图：《八思巴字字母表和藏文梵文关系的认定》，《蒙古语言文化学论丛》（第一卷），民族出版社，2009年，页194

⁶⁰郑张尚芳：《〈蒙古字韵〉所代表的音系及八思巴字一些转写问题》，《李新奎教授纪念文集》，中华书局，1998年

Сурвалж бичиг	Монгол хэлний үгс			
Дөрвөлжин үсэг ба галиг дуудлага	ᠡᠯᠡᠭᠡᠨ (el'ēn) (sh. in)	ᠡᠯᠡᠭᠡᠨ (el'ēn)	ᠡᠯᠡᠭᠡᠨ (el'ēn)	ᠡᠯᠡᠭᠡᠨ (el'ēn)
Өнөөгийн монгол хэлний дуудлага	элэг (el'ēn)	үлэг (il'ēs)	үлэг (il'ēs)	үлэг (il'ēs)
Тайлбар	Монгол хэлний е-тэй үгийн эхэнд өнөөгийн ний	Монгол хэлний и-тэй u ü е-ийн дараа өнөөгийн тохирно.	Монгол хэлний е буюу и-ийн дараа өнөөгийн тэй тохирно.	Монгол хэлний е буюу и-ийн дараа өнөөгийн тэй тохирно.

Дөрвөлжин үсгийн сурвалж бичгээс ажиглавал, тус үсэг нь монгол хэлний е буюу i-тэй, хятад хэлний [é] буюу i-тэй тохирч байжээ. Жишээлбэл:

Н.Поппе тус үсгийг үгийн эхэнд ᠡ буюу ᠡᠯ дүрстэй, үгийн дунд адагт ᠡᠯ дүрсээр бичигдэнэ хэмээн тус үсгийг уйгуржин монгол үсгийн бичлэгийн дүрмийн үүднээс тайлбарлажээ. Японы монгол

судлаач Хаттори Широ-ийн үзэхээр эхний бус ᠡ нь хос эгшиг ai-ээс хувиран ирсэн үсэг гэжээ. Зуунаст 23 хувь дөрвөлжин үсгээр бичигдсэн материалд é үсгийн бичлэгт харьцуулал хийж, тус үсэг нь төвөд үсгийн é-ээс гаралтай гэсэн байна. Жалсан өмнөх эрдэмтдийн төвөд үсгийн i-ээс гаралтай гэгчийг зохисгүй хэмээн, дөрвөлжин үсгийн ᠡ үсэг нь монгол хэлний цөөн хэдэн үгийн i-тэй тохирсныг гаргавал ихэнх нь е-тэй тохирох мөртөө төвөд хэлний ихэнх е эгшгийг галигласан газар бүгд ᠡ эгшгийг хэрэглэсэн байна. Иймээс тус үсэг нь төвөд үсгийн é-ээс гаралтай. Түүний үндсэн дүрс нь ᠡ, даруй төвөд үсгийн é-г тонгоруулан бичсэн үзэгдэл болно. Жарчуудай Жараннэг ᠡ үсэг нь төвөд é-ээс гаралтай гэдгийг зөвшөөрөн, нэмэлт тэмдэг ᠡ-г | -тэй холбоосоор холбохдоо бусдаас нь ялгаатайгаар зүүн талыг нь холбожээ. Тэгээд ингэж холбож үүсгэсэн ᠡ нь нэмэлт тэмдгээр ч хэрэглэгдэх болж анхны ᠡ хэлбэрийг бүрэн орлосон байна. Энэ нь ᠡ-г энгийн үсэгтэй адилхан

THE CULTURAL WAY

том бичихээс болж дөрвөлжин хэлбэртэй болгох гэсэн санаа бололтой⁶¹ гэжээ.

Хятад эрдэмтэн Жэнжан Шанфан “Дөрвөлжин үсгийн [эгшиг] (i)-ийн хувилбар болно”⁶² гэж үзжээ. Бидний үзэхээр дөрвөлжин үсэг нь эхэндээ монгол хэлийг тэмдэглэх зорилготой зохиогдсон мөртөө ихэнх тохиолдолд монгол хэлний е эгшигтэй тохируулжээ. Энэ э, нг нь төвөд үсгийн ᠡ -ээс гэдгийг нотлохоор барахгүй хичээнгүй тигийн нэгэн урлаг тиг болох төвөджин тигт |, 7 зэрэг дүрс, гур тигт |, 4 мэтээр төвөд үсгийн ᠡ -тэй адилавар бүхий дүрсүүдээр ч бичигдэнэ. Хэрэв тус үсэг нь төвөд үсгийн ᠡ -ээс адил болоход хүрвэл гур тиг буюу төвөджин тигийн хичээнгүй тигийн муруй буюу муруй эргэлтийн зурлага нь шууд ба шулуун эргэлтийн зурлага болох гэх бичлэгийн гол онцлогтой тэрсэлдэх болно. Иймээс бидний үзэхээр тус үсэг нь төвөд үсгийн ᠡ -ээс үүсэл гаралтай үсэг болно хэмээн үзэж байна.

(Хоёр) Хичээнгүй тигийн гийгүүлэгч үсгийн бичлэгийн онцлог

Хичээнгүй тигийн гийгүүлэгч үсгийн ихэнх нь төвөд үсгийн хэлбэр дүрсийг дуурайсан хэлбэр болно. [ʈ, ʂ, ʑ] зэрэг гурван үсэг нь санскрит үсгээс гаралтай юм. Дөрвөлжин үсгийн хичээнгүй тигийн гийгүүлэгч үсгийн онцлогийг төвөд үсэгтэй харьцуулан шинжилбэл:

1. Дөрвөлжин үсгийн зарим гийгүүлэгч нь тухайн төвөд үсгийг их хэмжээгээр дөрвөлжлөн буулгажээ. Энэ нь уламжлалт монгол үсгийн дээрээс доош нуруу дагуулан бичих дүрмээр дуурайлал болгон, нуруу зурлагыг нэлээд гүйцэд ашигласан байна. Жишээлбэл, төвөд үсгийн ᠠ, ᠡ, ᠢ, ᠣ зэрэг үсгийг дөрвөлжин үсэгт ᠠᠠ, ᠠᠡ, ᠠᠢ, ᠠᠣ хэмээн бичиглэдэг. Доорх дүгэрэг хэлбэрт пайз дахь бичлэгийн онцлогийг ажиглавал, үсгийн үе бүрийг баруун гар тал (ᠠᠠᠠᠠ ᠠᠠᠠᠠ ᠠᠠᠠᠠ ᠠᠠᠠᠠ) буюу үсгийн дундуур тэгш хэмтэй (ᠠᠠᠠᠠ)-ээр шулуун холбоосын дагуу холбон бичжээ.

2. Төвөд үсэг дэх муруй зурлагыг шулуун зурлага болгосон байна. Жишээлбэл, төвөд үсэг дэх ᠠ, ᠡ, ᠢ, ᠣ, ᠤ, ᠥ, ᠦ, ᠦ зэрэг дөрвөлжин үсэгт бүгд ᠠ, ᠡ, ᠢ, ᠣ, ᠤ, ᠥ, ᠦ, ᠦ хэлбэртэй болжээ. Дөрвөлжин үсгийн

⁶¹ Ж.Жараннэг: “Дөрвөлжин бичгийн эгшиг тэмдэглэх аргын уг учир”, Монгол хэл бичиг, № 8, х 25

⁶² 郑张尚芳: 《〈蒙古字韵〉所代表的音系及八思巴字一些转写问题》, 《李新奎教授纪念文集》, 中华书局, 1998 年

THE CULTURAL WAY

ихэнх үсэг нь шулуун зурлагатай болсноос үсгийн бичлэгийн тиг маяг нь төв ихэмсэг, хурц тодорхой харагддаг. Хичээнгүй тигээр бичигдсэн бичээсэнд хөшөө бичээс, пайз гэрээ бичиг, цаасан дээрх бичмэл зэрэг багтана. Эдгээр зарлигийн бичигт илэрсэн хичээнгүй тигийн бичлэгийн хэв маяг ба онцлог нь төв ихэмсэг, хурц тодорхой байх ажээ.



(Зураг 3.)



(Зураг 4.)



(Зураг 5.)



(Зураг 6.)

Зургийн тайлбар:

Зураг 1. Монгол үсгийн дуудлага дахь хичээнгүй тигийн цагаан толгой

Зураг 2. Монгол үсгийн дуудлага дахь гур тигийн үсгүүд

THE CULTURAL WAY

Зураг 3. Дүгэрэг хэлбэрт пайз. 1881 онд Орос улсын шинжлэх ухааны хүрээлэнгийн сонинд анх нийтлэгджээ.

Зураг 4. Юань улсын цутгамал зоосны бичиг. “Да Юань Тун Бао”

Зураг 5. Буянт хааны барс (1314) жилийн зарлиг бичиг

Зураг. 6. Хичээнгүй тигийн гар бичмэл хэв маяг

ДҮГНЭЛТ

Дөрвөлжин үсгийн үсгийн хэлбэр дүрсийн үүсэл гарлыг ажиглавал тус үсэг төвөд санскрит үсэгт үндэслэн зохиогдсон нь тодорхой байна. Тус үсгийн хичээнгүй тигийн бичлэгийн эх сурвалжийг төвөд үсгийн харгалзсан дүрсээс хайж болох боловч үсгийн бичлэгийг төвөд үсэгтэй харьцуулбал багахан дөрвөлжин хэлбэртэй болгосноос гоёмсог бөгөөд эвсэг намуун, хурц дөрвөлжин бөгөөд цэгцтэй харагдана. Хичээнгүй тигээр бичигдсэн бичээсэнд хөшөө бичээс, пайз гэрээ бичиг, цаасан дээрх бичмэл зэрэг нь өнөөгийн судалгаанд үнэлж баршгүй үнэ цэнэтэй зүйл юм.

THE CULTURAL WAY

НОМ ЗҮЙ

1. 宋濂等：《元史》，中华书局，1987年
2. 宋洪民：《从八思巴字文献材料看‘蒙古字韵’成书时间》，《语言研究》，2010年第4期
3. 盛熙明：《法书考》，Хасбагана “Монгол хэлний түүхэн улирал хувирал ба сурвалж бичгийн судлал”
4. 陶宗仪：《书史会要》，Хасбагана “Монгол хэлний түүхэн улирал хувирал ба сурвалж бичгийн судлал”
5. 照那斯图：《八思巴字字母表和藏文梵文关系的认定》，《蒙古语言文化学论丛》（第一卷），民族出版社，2009年，页194
6. 郑张尚芳：《〈蒙古字韵〉所代表的音系及八思巴字一些转写问题》，《李新奎教授纪念文集》，中华书局，1998年
7. Ө.Мандах：“Пагва лам ба дөрвөлжин үсэг”，ӨМЭШС, 1987 № 2
8. Ш.Лувсанвандан：“Дөрвөлжин, тод үсгийн бичих дүрэмд монгол хэлний урт эгшгийг хэрхэн тэмдэглэх вэ?”，Орчин үеийн монгол хэлний тухай өгүүллүүд, ӨМСХХХ, 1986
9. Ж.Жараннэг：“Дөрвөлжин бичгийн эгшиг тэмдэглэх аргын уг учир”，Монгол хэл бичиг, № 8

ABSTRACT

In the first year of Zhongtun, Kublai Khan issued a decree to compose a square letter, which was used from the sixth year of Ji Yuan (1269). In this order, Kublai Khan described the historical situation and the need to create a new alphabet, and the name and position of the new alphabet. As a state alphabet, the square letter has been used as a symbol of state power and power in the Yuan Dynasty's internal central government, military affairs, economy, and religion. Therefore, in the Yuan Dynasty, square letters were used for all kinds of contracts, such as plaques, letters, official stamps, religious ornaments, and monuments. There is no special symbol for the medieval Mongolian vowel [a] in the diligent letter tig. It is presented in a single form. The fact that the square letters are written in a line from top to bottom, from left to right, indicates that they are not derived from the Uighur Mongolian alphabet.

Key words: *Phags-pa script, diligently, scratch*

**ШАШИН ШҮТЛЭГИЙН НӨЛӨӨН ДЭХ МОНГОЛ ТӨВӨД УРАН ЗОХИОЛЫН
ХҮҮРНЭЛ**

*(Л.Түдэвийн “Оройгүй сүм” ба Жасдаваагийн “Төвөд, нууц он жил”
зохиолын жишээн дээр)*

Билиг*

Кань Хай Ин*

ХУРААНГУЙ

Хүн нийгмийн аливаа бүхэн бол хүүрнэхүйн ажиллагаа мөн. Байгаль нийгмийн орчин буюу ертөнцийн тухай үзэл ойлголтын адил байдлаас болж адилавар оршихуйн бүхий уран зохиолын цаг орон илэрч болдог. Л.Түдэвийн “Оройгүй сүм” ба Жасдаваагийн “Төвөд, нууц он жил” хэмээх хоёр туужсын бүтээлд шашин шүтлэгийн нөлөөн доорх өвөрмөц цаг оронг хүүрнэхээр дамжуулж, онцгой дүрүүдийг бүтээжээ. Оройгүй сүм хэмээх гарчигтай энэхүү роман нь бэлгэдэн туурвиж, Төвөд, нууц он жил тууж нь уншигчдыг содон ертөнцөд оруулдаг юм. Өгүүлэлд орон зайн хүүрнэхүйн талаас шашин шүтлэгийн хоосон чанарыг задлан, цаг хугацааны хүүрнэхүйн зогсоцоос үлгэр үйл явдлын хам цагийн илэрхийллийг мөрдөж, цаг орны дүрс болсон дүрийн тухай шинжлэл хийв.

Түлхүүр үгс: Хүүрнэхүй, Хоосон чанар, Хам цаг, Дүр

Монгол төвөд хоёр үндэстний соёлын харилцааны түүхэн улбаа нь урт удаан, монгол оронд төвөд уламжлалт бурхан шашин дэлгэрснээс монголчуудын амьдралд гүн нөлөөлжээ. Монгол улсын төрийн шагналт зохиолч, эрдэмтэн, нийгмийн зүтгэлтэн Л.Түдэвийн “Оройгүй сүм” бол 1982-1983 оны хооронд бүтээсэн 33 бүлэгт шашны сэдэвт роман болно. Монголчуудын “16 дугаар зуунд маш үнэнч сэтгэлгээгээр угтан авсан бурхны шашин 18 дугаар зуун хүрээд хүмүүст хүйтнээр хандсан байна”

* Хэл шинжлэлийн магистрант (ӨМИС, Монгол Судлалын Дээд Сургууль).

* Доктор, дэд профессор (ӨМИС, Монгол Судлалын Дээд Сургуулийн багш).

THE CULTURAL WAY

[Т.Эрдэнэтогтох, Сүх, 2019, х.311]. 20 дугаар зууны эхэн болоход монгол улс нийгэм журамт замаар замнаснаас, дундад зууны үеийн шашны үзэл суртлын ноёрхлыг халж [Ш.Нацагдорж, 1988, х.111], хүмүүсийн бурхны шашны тухай үзэл ойлголтод түүхч чанартай хувиралт гарчээ. “Оройгүй сүм” роман нь голдуу бурхны замаар замнасан Санжийн амьдралын эргэн тойронд бүтээж, шашны хоосон чанарыг шүүмжлэн, шашин шүтлэгийн бараан сүүдэр дэх гунигт байдлыг харуулжээ. Төвөдийн өөртөө засах орны утга урлагийн холбооны тэргүүлэгч Жасдаваагийн гол төлөөлөх бүтээл болох “Төвөд, нууц он жил” бол 1985 онд төвөд уран зохиолын 6 дугаар хугацаанд нийтлэгдсэн 3 бүлэгт тууж билээ. Тус туужид төвөдийн нэгэн уулархаг орны Гуо кан гэдэг тосгоны эргэн тойрон дахь төвөдчүүдийн соёл иргэншлийн им тамга бүхий эдүгээч ухамсар илэрч байдаг.

Туужсын ур цогцын үзэл гэдэг нь туужсыг ахуйч тусгал, түүхийн бодит илрэл буюу түүхийн дүрслэг хүүрнэл [Хайрхан, Нахиа, 2020, х.52], “Оройгүй сүм” ба “Төвөд, нууц он жил” дэх түүхийн цаг орон ба онцлогт дүрүүдэд уран зохиолын хүүрнэлээр бүтээсэн ур цогцын үзэл илэрч байдаг. Өгүүлэлд, оройгүй дуган ба чулуужсан араг яс, цагийн балархайшил буюу хам цагийн илэрхийлэл, дүрийн зөрчил ба гунигт төгсгөл хэмээх гурван хэсгээр орон зайн хүүрнэхүйн талаас шашин шүтлэгийн хоосон чанарыг задлан, цаг хугацааны хүүрнэхүйн зогсоцоос үлгэр үйл явдлын хам цагийн илэрхийллийг мөрдөж, цаг орны дүрс болсон дүрийн тухай судалгаа хийв.

Нэг. Оройгүй дуган ба чулуужсан араг яс

Монгол төвөд соёлын харилцаанаас шарын шашин монгол оронд уламжлагдан монголчуудыг тус шашинд гүн сүжиглүүлжээ. Оройгүй сүм хэмээх гарчигтай тус роман нь тухайн үеийн монгол орны нийгмийн хураангуй бодит жишээ болно. Л.Түдэвийн бурхны шашны тухай мэдлэг баялаг гэдэг нь романаар гэрчлэгдэж байна. *“Буян залбирах хийдийн гол сүмд нам гүм, бүдэг бадаг, хүж, хөхлийн нялуувтар үнэр сэнгэнэж байлаа. Шүтээний өмнөх зандан ширээн дээр хэдэн эгнээнээр ёс горимоор нь өрсөн тахилын юмс зулын бүдэг гэрэлд сүүтэгнэн хөдлөх шиг эрээлжлэн ярайна. Хамгийн урд нүүрт долоон цөгц эгнүүлсний зүүн хоёр нь устай, гурав дахь нь цэцэгтэй, дөрөв дэх нь хүжтэй, тав дахь нь шар тосон зултай, зургаа дахь нь ус, долоо дахь нь цагаан идээтэй*

THE CULTURAL WAY

ажээ. ... Долоон цөгцнөөс цааш өлзийт найман тэмдэг буюу найман тахил ярайж байна. Нисванисын халууныг буюу элдэв нүгэлт хүслийн шуналыг дарах бэлгэдэл болсон цагаан шүхэр, цагаан алтаар цутгаж хийсэн бодь гөрөөсний дүрс, тус жаргалангийн дунд амьдрах загасны дүрс, яруу дуугаа арван зүгт түгээгч цагаан лавай гэгч дунгар, бохир муухайгаас хагацсан цагаан бадамлянхуа, хүслийн эрдэнээр төгс дүүрэн бумба, аз жаргалын төгсгөлгүй бэлгэдэл өлзий утас, балба, ялгуусны чимэг болох жалсан, мянган хэгээст номын хорол, энэ найманыг өлзийт тэмдэг болгон шүтээнийг чимэглэжээ”. Яг иймэрхүү шашны ёс горим арвин атлаа хатуу орчин байдалд, зохиолын гол баатар, ядуу айлын хүү Санж аав ээжийнхээ хүсэл санаагаар дөрөвхөн насандаа увш сахил хүртэж, долоон насандаа Буян залбирах хийдэд шавь орж банди болсон мөртөө арван тавтайдаа төвөдөд очиж бурхны ном сурчээ. “17-19 дүгээр зууны монгол нийгэм нь нэг талаар манжийн ноёрхолд хүчтэй автаж, нөгөө талаар шашны нөлөө өдөр ирэхүй хэцүүдэж байснаар монголчуудын оюун ухаанд шарын шашны ертөнцийг үзэх үзэл голлох байрыг эзлэн, газар бүрт сүм хийд байгуулж, хүн бүхэн шашны сүсэгтэн болох хэмжээнд хүрчээ [С.Баатар, 2018, х.372]. Иймээс Санжийн учрал тавилан нь тухайн монгол орны түгээмэл үзэгдэл болно. Тэр сахил санваарыг хатуу сахиж, нүгэл алдасыг хичээж, идэр нас болтлоо хүний газар ном сурсны хариуд “Төгсгөлгүй эрдэмт” лхарамба цол хүртэж нутагтаа зугтааж ирээд хамба лам өргөмжлөгджээ. Санж бурхны шашны ном эрдмийг хэдий сурах тутам эргэлзэл бодлогошрол нь төдий нэмэгдэх болсон боловч эцгийнхээ санасан бодсоных нь аяыг нь дагуулж, эхийнхээ ариун сүнсийг нь дурсахын тулд Чойрын дуган босгох болсон байна. Дуган босгох чимээ лам, мөргөлчдийн таашаалд таарсан ч, бороотой шөнө Отгоны гэрт бууж, буруу замаар орсны дээр Ширээт чойвзан, Дэчин унзад, Дэмбэрэл гэсгүй, Дэмцог гавж нараас Санж хамбатайгаа таарахгүй лам нарын тоо нэмэгдсээр энгийн хүн болох л хэрэгтэй болжээ. Санж энгийн хүн болохоор шийдэж, хар хүн болох хүсэлтэй болсон боловч санаа бодол нь бүрмөсөн шашнаас ангижирч чадаагүй, түүний нүдний өмнөх хамгийн чухал ажил нь мөн л Чойрын дуганаа босгох ажил байсан юм. Гэвч, санасан зүйл нь санаагаар нь болсонгүй “Чойрын сүм оройдоо хүрэлгүй дутуу хэвээр үлджээ”.

Сүм оройгүй бол бүрэн төгс оршихуйн учир агуулгаа алдана. Иймээс “Оройгүй сүм” романы гарчигасаа бэлгэдэл утгатай, амьдрал ба

THE CULTURAL WAY

бурхан номын зөрөөг үүсгэсэн хоосон чанарын шүүмжлэл билээ. Санж хар багаасаа бурхны номд орж хоосон чанарыг үзэж гарснаас эгэл хар хүний амьдралыг хүсэх болжээ. Тэр нэг насаараа бурхан шашны үзэл санааны эрхшээлд амь зууж, дөрөвхөн насандаа увш сахил хүртсэнээс хамба өргөмжлөгдтөл эгэл хар амьдралаас буцашгүй зайджээ. Санжийн бүх амьдрал хоосноос үүсэж, Их хөлгөн судар дахь “хүн ном хоёулаа хоосон, шүтэн барилдах мөн чанар хоосон” [Зоригт, 2000, х.27], аливаа юм бол цөм хоосон хэмээх үзэл санаа нэвтрэлцэж байдаг. Түүний бурхны замд орж, судар нам шаргуу суралцсан нь ядуу амьдралыг нь өөрчилж чадсангүйгээр үл барам харамсал зовлонгийн гүн ёроолд түлхэн оруулжээ. Төгсгөлгүй лхарамба цол ба өчүүхэн ч үйлдэл гаргасангүй, оройгүй сүмээс гадна энэ хорвоод үлдээсэн зүйл байхгүй. Оройгүй сүм роман нь Санжгаар гол дүр болгож хоосон орон зайг бүтээхээр дамжиж бурхан шашны хоосон чанарыг шүүмжилсэн нь монголчуудын шашны тухай үзэл ойлголтын хувирал ба зохион бүтээсэн тухайн нийгмийн үзэл санааны хэлбэртэй нягт харьцаатай байдаг.

Жасдаваа өөрөө төвөд үндэстэн, төвөд соёлын гүнзгий ойлголтон дээрээ бодит ахуйч үзлийн арга барилыг гарамгай ашиглаж “Төвөд, нууц он жил” туужийг нууц, нарийн будлиантай болгожээ. Тус тууж нь нэг зүстэй дөрвөн Цэрэнжимийн дүр илэрч, 1910-1985 оны хоорондох дөрвөн цаг үеийн төвөдчүүдийн соёлын орон зайн нээгдсэн үзүүлбэр, төвөдчүүдийн соёл иргэншлийн дүрүүд билээ. Нэгдүгээр Цэрэнжимийн эцэг эх нь Гуо кан тосгонд анх ирснээс хамгийн эцсийн суугуул болж үлдсэн мөртөө 40 жилийн турш агуйд даяанчилж байсан даяанчийг асарчээ. Нямаа Зайсан хоёр зөнтэй байж, Цэрэнжимийг анх төрөхөд нь сахиусны шинжтэй хэмээжээ. *“Цэрэнжим хоёрхон нас хүрмэгц зүйл зүйлээр бусдаас онцгой шинж төлөв илэрч, учиргүй болсоор оцойн сууж, газар дээр элдэв зүйлийн далд нууцгай элсэн зураг зурдаг. Охиныхоо хүний ертөнцийн үхэл амьдралын учралын тотемыг зурж байхыг Нямаа мэдсэнгүй. Хөлд ормогц бараг л замыг нь олдохгүй алхаатай бүжин үсэрч, элсэн дээр үлдээсэн хөлийнх нь ором нь од гарагийн жагсаал зураг, аль эрт төвөдөд уламжлагдахаа больсон гэлэг очирын цам гэдгийг Нямаа мөн ч мэдсэнгүй. ... Эдгээр сахиусны шинж нь Гуо кан тосгонд ирсэн танил бус хүнээс болж бүрмөсөн арилжээ”*. Гэвч эцэг эх нь таалал төгсөхөөсөө өмнө Цэрэнжимийг санваар хүртээж даяанчийг асрах ажлаар Гуо кан тосгонд насаар нь гинжилж тавьжээ. Цэрэнжим

THE CULTURAL WAY

өөрийнхөө хүссэн амьдрал ба бие биедээ хайртай Дэлэг гэдэг ганган залуугийн эхнэр нь болохыг хүснэ. Гэвч Дэлэг эцэг эхдээ хаягдан орхигдож, сэтгэлийг нь шимшрүүлсэн Гуо кан тосгоноос салж, нэн өндөр залан (哲拉山 zhela shan) уулан дээр суурьшжээ. Даяанчийг асрах үүрэгтэй Цэрэнжимийн Дэлэгтэй ханилан амьдрахын хүсэл биелэж үл чадна, *“цагийн ухамсаргүй мөнхийн ганцаардал дунд нам намуухан амьдарна”*. Харин ижил төрхийг авч төрсөн хоёр, гурав, дөрөвдүгээр Цэрэнжим тус тус айлын бүсгүй болсон, цэрэг орсон, гадаадад сурахаар одсон зэргээр нэгдүгээр Цэрэнжимийн хүслийг нь биелүүлсэн ба төвөдчүүд соёл иргэншлийн ахицад урагшилжээ.

Бурхны ариун орон хэмээгдсэн төвөдөд аж төрөн амьдарч байгаа төвөдчүүд нь шашин шүтлэгийн нөлөөллийг гүн хүртэж, өвөрмөц нууц шашны өнгө будагтай билээ. Төвөд, нууц он жил тууж бол үндэстний хураангуй дүр болох удам угсаа, айл тосгон ба хүний хөгжлийн товч түүх [王 緋, 1993, х.79], соёл иргэншлийн ахиц дахь төвөд соёлын далд талын тасралтгүй нээгдсэн хүн соёлын хүүрнэл тайлбар мөн. Нэгдүгээр Цэрэнжим бол бурхан шашны нөлөө доорх уламжлалт соёлын залгамж үе нь мөртөө иргэний нийгмийн хөгжилтэй хөл нийлж эхэлсэн эхлэлийн цэг байж, түүний нэг насны учир утга нь мөн л хоосон орон зайн оршихуйд аргамжлагдсан байна. *“Гэр бүлээрээ агуйн өмнөх зүлгэн дээр сөгдөж, эцэг эх нь хэд дахин удаа охиноо увсанз сахил хүртэхийг даяанчаас түтгэнэн гуйж байв. ... бараг бүрэг үзэгдэх нэг цагаан юм агуйн амсараас дэгдэн гарч ирээд Цэрэнжимийн хүзүүнд цул цагаан ас хадаг өлгөгдөв. ... Цэрэнжим цахилгаанд цохиулсан мэт сулран унав. ... Тэр шөнө зулын бүдэг гэрэлд олон жил болсон ч ир нь мөн л хурц илдээр цахилдаг мэт тас хар үсийг нь хусав”*. Жаран нэгэн настай эх нь жирэмслээд хоёрхон сар болмогц түүнийг хөнгөжсөн нь шашны л төлөө төрсөн мөртөө шашны л төлөө нэг насыг нь нөгцөөжээ. Уг нь юугийн явдалт эхийн эргэх төрөл нь байсан Цэрэнжим хоёрхон насандаа үхэл амьдралын учралын тотемыг зурж чадах ба хөлд ормогц гэлэг очирын цамыг харайж чадах байсан боловч английн нэгэн цэргийн ноёд үнсэгдээд сахиус шинж нь бүрмөсөн арилжээ. *“Цэрэнжим Н. Т Мүскэт ахлах дэслэгчид үнсүүлснээс баруун хацар нь нэг хэсэг улайн хавдаж, болд зүү мэт бүдүүн хатуу сахал нь хэлэн жижиг нүх шивж, зогсошгүй идээ гоожиж байжээ. Нямаа уурлахдаа англи хүнийг ихээр хараав. Хөдөлж барих нь амаргүй болсон Зайсан хадан доор мөлхөн очиж,*

THE CULTURAL WAY

хаанаас олсныг нь мэдэхгүй хээрийн өвсийг чулуун дээр няцлан шүлсээрээ зуурч, охиныхоо хацар дээр нь шавсан бөгөөд өдөр шөнөгүй наминчилснаас гурван хоногийн дараа Цэрэнжимийн хацар дээрх улайж хавдсан нь эдгэрэв. Гэвч түүний нүдний харц нь анхных шиг сахиус гэгээнтний саруул ухаан бадрах нь больж, элсэн зураг ч зурж чадахгүй болж, гэлэг очирын цам харайж чадахгүй, нэн ч хэлиггүй арилжээ. Юу ч гэсэн түүний бие дээрх эл зүйлийн ерын явдалд эхийн бүрэлбаагийн им нь бүрмөсөн арилсан бөгөөд хацар дээр нь гүв гүйхэн хэдэн мэнгэ үлдээжээ”. Эцэг эх нь нас барахаас өмнө даяанчийг асрах үүргийг Цэрэнжимд албаар уламжилж, харж ч байгаагүй даяанчийг асрахын төлөө итгэл найдвараа тэвчиж, өөрийн хүсэл хайр дурлал ба эрх чөлөөт амьдралын төлөө явсангүй. “Нүдний өмнө нь маш явцуу агуй харагдаж, өвдөг чинээ тайзан дээр нэг иж бүрэн бүтэн хүний араг яс байна. ... Тэр бүрэн араг яс нь аль эрт чулуужин, хадан ханан дээрх хөдүүр сийлмэл мэт болж, агуйн ханатай нийлжээ. Араг ясны доор хагдтай, хажууд нь гуулин очир хонхтой, дээр нь зэсэн зэвийн ногоон домботой. Бас нэг модон аяга ба хэдэн гуулин бурхантай. Араг ясны арын ханан дээр нь маш олон гар хөлийн ором үлдээгээстэй. ... Анх алхамын магадлалыг үндэслэвэл энэ нь эрэгтэй хүний араг яс, нас жил нь хорн дөрөв тав орчим ...”. Түүний нэг насаараа шүтэн асарч, бишрэн үнэмшсэн даяанч нь аль эрт чулуужсан араг яс байж, нууц чанартай, мөн ч амьдралыг нь талаар хоосон чанартай болгожээ. Хүн төрөлхтний шашин суртахуун нь нийтгэч чанарын төөрөгдөл [佛洛依德著, 傅雅芳, 郝冬瑾译, 1987, х.22], хүслийг байгуулахаар дамжин хүмүүсийн хүлээн авч үл чадах бодь хэсгээ зөвтгөдөг мөртөө төөрөгдлөө бодь байдалд шингээдэг [佛洛依德著, 傅雅芳, 郝冬瑾译, 1987, х.21]. Эцэг эхээс нь өмнө нэгэн хөгшний тахиж байсан агуйн даяанчийг эцэг эх нь нүгэлээ арилгахын тусад 40 жил асарч, Цэрэмжимийг нэг насаар нь асруулж тахиулсны дүнд 24, 25 насны эрэгтэй хүний араг яс байжээ. Тэр хоосон агуйн ид шид нь төвөдчүүдийн уугал сэтгэхүйнх нь түшиг тулгуур нь байсан мөртөө оюун санааг нь аргамжиж байжээ. Жасдаваа хоосон орон зайг шуун бүтээхээр дамжуулж төвөд орны шашин шүтлэгийн нөлөлөл доорх нууц өнгө будгийг үзүүлж, дөрвөн Цэрэмжимээр бэлгэдэл болгож, нууц зүйлс задарсан, орон зайн нээгдсэн явц буюу төвөдчүүдийн соёл иргэншлийн явцыг товойлгожээ.

Шашны ертөнц бол хүн төрөлхтний оюун санааны мөн чанарын ондоошуулсан ертөнцөд тооцогддог [Т.Эрдэнэтогтох, 2017, х.2]. Орон

THE CULTURAL WAY

зай бол хүн төрөлхтний оршихуйн үндэс болох газар байж, хүмүүс өдөржин орон зай дунд амьсгалж, хөдөлгөөн хийж амьдарна. Аливаа хувь хүний сэтгэхүй ба хамт нийтийн ажиллагаа эрхбиш нэгэн бодитой орон зайд сая явагдаж чадна [龙迪勇, 2015, х.27]. Санж ба нэгдүгээр Цэрэнжимээр агшаамал дүр болгосон орон зайн оршихуй бол үндэс гүн сурвалж урт шашин шүтлэгийн нөлөөлөл доорх түүхийн ур цогцын хүүрнэхүй, тэд хоосролын шалчигт гүн шигджээ. Санж бол шарын шашны тоглоом шиг хувь заяагаа шашинд эзэмшүүлж, нэгдүгээр Цэрэнжимийн нэг нас нь шашин шүтлэгийн хойлгын эд шиг Гуо кан тосгонд булшлагджээ. “Хүмүүсийн нийгмийн хөдөлгөөн дунд, өдөр тутмын амьдрал дунд соёлын ур дүрийн илрэл нь хурц тод байдаг” [程金城, 2008, х.265]. Монгол төвөд хоёр үндэстний нийгэм нь шашны эзэмшилд байсан нь түүхэн үнэн билээ. Иймээс Санж ба нэгдүгээр Цэрэнжим бол тухайн нийгмийн нийтэч өртгийн магадлалтай соёлын хэвшмэл ур дүр мөн бөгөөд хагас босгосон сүм ба чулуужсан араг яс нь тухайн нийгмийн ур цогцын бэлгэдэл мөн. Орон зай ба цаг хугацаа бол аливаа хэрэг бодисын орших хэлбэр мөн бөгөөд аливаа урлагийн үндсэн бүтэц [Хайрхан, 2021, х.21], Оройгүй сүм ба Төвөд нууц он жил хоёр туужсын бүтээлийн тухайн нийгмийн түгээмэл орших “хоосон” орон зайг дахин илэрхийлсэн буюу хүүрнэж, хэлбэрийн талын гурвалсан хэмнэлээр хүүрнэхүй утга ба нэн гүнзгийрүүлжээ. Хоёр бүтээлийн бичвэрийг ажиглахад гурваар хэмнэсэн онцлогтой, хэлбэр агуулга нь уялдлаа олжээ. Хэрэг үзэгдлийн ямар нэгэн онцлог шинж ба зарим нэгэн учир ёсыг нэлээд хураангуй оновчтой харуулдаг [Мандах, 2017, х.177] монголчуудын аман уламжлалын хэлбэр болох ертөнцийн гурваар бүлэг бүрийг хураангуйлан удиртгал болгосон Оройгүй сүм нь 33 бүлгээр зохиомжилсон бүлэгт роман, ертөнцийн гуравт гурав гурваар нэгчилж ярих бол монгол үндэстний ард түмний сэтгэхүйн талын онцлог болон дадал [Баатар, Цэцэг, 1985, х.246] болох мөртөө монгол утга соёлын орон зайг гурваар хэмнэхдээ зааг завсар, саад бэрхшээл гэсэн бэлгэдэл утгыг илэрхийлдэг [С.Дулмаа, 2009, х.72] учраас амьдралын хар ухаан, цуу ухаан ба уугал сэтгэхүйгээс шашныг шүүмжилсэн урлагийн онцлогийн илрэл мөн. “Төвөдчүүдийн үргэлж гурав буюу гурвын дахин тоогоор цаг хугацааны урт, орон зайн их ба тооны олныг илэрхийлнэ [范春文, 王琼, 2010, х.63]. Иймээс Төвөд нууц он жил туужийн гурван бүлэг нь төвөд үндэстний даяаршлын хөг аяс дахь хүн соёлын хязгаарлашгүй өргөн

THE CULTURAL WAY

уудам цаг орны боломжит бэлгэдэл болно. Ур цогцын оршихуй орон зайн утгыг тээсэн бичвэрийн гурвалсан орон зай нь Оройгүй сүм ба Төвөд нууц он жил хоёр тууж бүтээлийн урлагийн амин сүнс нь бадарсан мөртөө уран бүтээлийн сэтгэлгээний гадаад хэлбэрээр баялаг агуулгатай болгожээ.

Хоёр. Цагийн балархайшил буюу хам цагийн илэрхийлэл

“Халхын засагт ханы нутгаас гарсаар хоёр сар гаруй явж байгаа ажээ”, “Алшаагийн оршин суугчид ихэнхдээ өөлдүүд юм. Өөлдийн хошууг тэнд анх чин ван Лувсандорж гэгч хүн 100 гаруй жилийн өмнө байгуулан захирчээ. Чин улсын хааны гүнжтэй сууж, хүргэн нь болсны учир хошой захирах чин вангийн зэрэг хүртжээ”. Оройгүй сүм романыг уншихад их төлөв чингийн ноёрхлын үеийн нийгмийн түүхэн байдал төлвийг үзэхээс биш бодитой цаг хугацаа нь тодорхойгүй, роман нь тухайн үеийн цаг хугацааны хэрэглэгдэхүүнээр хүүрнэн хам цагийг илэрхийлсэн байна. Гол дүр Санж *“Ум нам, шад, сууха”* хэмээх амны уншлагатай, *“эр усан гахай жилийн хаврын эхэн сарын арван тавны өдөр ривади одноо тохион төрсөн”* мөртөө 13 дугаар дүр далай ламд бараалхан золгож байсан гэх мэт баримтаас 1863 оны хүн гэдгийг мэдэж болно. Санж 4 настай (1867 он)-даа увш сахил хүртэж, 7 настай (1870 он)-даа банди болж, *“улаан гал барс жилийн зуны эхэн сарын шинийн наймны өдрийн тахиа цагт долоон араат, гурван хулын шүүдэрт гэсэл сахиус хүртсэн”* (1878 он) гэх мэтээс жишээлвэл үйлийн бодитой он тооллыг мэдэж болно. Шарын шашин монгол оронд түгээмэл дэлгэрсэн шалтгаанаас цаг хугацааны хүүрнэл нь дутмаг боловч төвөд он тоолол буюу шарын шашны цаг хугацааны хүүрнэлтэй нягт харьцаатай байдаг.

Төвөд нууц он жил туужийн эдүгээч ойлголт дунд цаг хугацааны хүүрнэлийг уран нарийн хэрэглэж, дөрвөн Цэрэнжимийн дүрээр харгалзсан төвөдийн 4 цаг үеийг харуулжээ. Нэгдүгээр цаг үе бол харьцангуй уламжлалын, эртний, эдүгээч цаг хугацааны ухамсаргүй байж, Гуо кан тосгон бол аж үйлдвэрийн хөгжлээс харьцангуй зайтай, битүү орчин байжээ. *“Цэрэнжим нэг ширхэг өвс үгтгээж аваад эрхий хурууныхаа ар талын гүн атираанд тавьж, хурууны үеэ асган сунгахад өвс нь чанга хавчигдаж, унахгүй болжээ. Тэр орондоо эргэн хуруугаараа уулан доорх хараа уудам өмнө зүгийг заагаад, өвсний сүүдэр нь аль тийш тусахаар цагийг хэмжээлдэг”.* Зэрлэг хүнийг дагаж явсан, лам чавганц

THE CULTURAL WAY

буюу даяанч болсон, тухайн үеийн энэтхэг төвөдийн сураг мэдээг мэдэх хүнийг дагаж явсан, англи хүн ирсэн, орос буутай болсон ба ерөнхий менежерийн хатагтайг булааж авч ирсэн, эндсэн нислэг буусан, чөлөөлөх цэрэг төвөдөд орсон, уулнаас бууж цэрэг болсон, ядуучуудын зөвлөлийн эрхлэгч болсон, UFO-ийн судлаач ирсэн ... гэх мэт соёл иргэншлийн өөрчлөлтийг дагалдан Гуо кан тосгон тасралтгүй нээгдэж, хоёр гурав дөрөвдүгээр Цэрэнжим илэрсэн буюу Гуо каг тосгонд “1970 оны 10 сарын 8-ны өдөр” хэмээх шинжлэх ухаанч цаг илэрчээ. 1910-1927, 1929-1950 ба 1953-1985 хэмээх гурван бүлгийн гарчигтай Төвөд нууц он жил тууж нь хэдийгээр 1910 оноос 1985 оны хоорондох үйл явдал боловч 1928, 1951 ба 1952 оныг орхигдуулсан байна. 1928 оны 3 сарын 21-ний өдөр иргэний засгийн газраас монгол төвөдийн хэргийг шийдэх хурал хийж, 1951 оны 5 сарыг 23-ны өдөр төвөдийг найрамдлаар чөлөөлж, 1952 оны 1 сарын 10-ны өдөр дундад улсын эв хамт намын төвөд дэхь зөвлөлийн хурал байгуулагджээ. Иймээс гурван жилийн гээгдлийг дамжин нууц байсан төвөд орон аажмаар нууц чанараа алдаж, нээлттэй чанартай болж, эцэстээ соёл иргэншлийн нийгэмд шилжив.

Оройгүй сүм романы цаг хугацааны хүүрнэлийн дараалал нь зохиогчийн тонгоруу тоочилт аргагүйн эрхэнд даяанч буюу эхлэл хэмээх бүлгээр хүүрнэлээ эхлэн, гэсэлийн сахил хүртсэн нь хэмээх бүлгээр үйл явдлыг эхлүүлэн, оройгүй сүм буюу төгсгөл хэмээх бүлгээр бүх зохиолын эхлэл төгсгөлийн ам сээрийг золгуулжээ. Тэр нь монголчуудын нийтлэг цогцын гоо сайхны үзэл ухамсар болох хүүрнэл зүйн эхлэлтийн цэг болон төгсгөлийн цэгийг нэгтгэн бичих томьёололд хүрсэн байна [Хархүү, 2004, х.53]. Төвөд нууц он жил туужийн цаг хугацааны хүүрнэлийн дараалал нь хэсэг бусаг, ерөнхийдөө шууд тоочилт боловч хүүрнэгдэж байгаа цаг хугацаа нь харин тойрог бүтэцтэй. Маанийн үрэл бүр нь нэг хэсэг он жил мөртөө, үрэл бүр нь Цэрэнжим байж, тэр бол аливаа эмэгтэйн төлөөлөл мөн. Насаараа даяанчийг асраад хөгшиг болсон нэгдүгээр Цэрэнжим, дөрөвдүгээр Цэрэнжимтэй уулзсан ба ярилцсан нь “төвөдчүүд аль эрт мянга илүү жилийн өмнө амь насны явцыг хүрдний хөдөлгөөнтэй холбодог байсан [张洋, 2014, х.5] соёл сэтгэхүйн шууд илрэл билээ.

Хүмүүсийн цаг хугацааны туршлага буюу мэдрэмж нь хүүрнэлийн бичвэр дунд илрэн гардаг [谭君强著, 2014, х.104] учраас Оройгүй сүм ба Төвөд нууц он жил нь цаг хугацааны хүүрнэлийн тухайд

THE CULTURAL WAY

балархайшуулсан боловч урлагийн арга барилаар тухайн нийгмийн хам цагийг илэрхийлэн, бүтээлийнхээ цаг хугацаат хүүрнэлийг хөгжөөсөн байна. Бидний цаг хугацааны мэдрэмж нь бидний соёлоос үүсэлтэй, адил бус соёл нь цаг хугацааны тухай адил бус дүрслэлтэй мөртөө адил бус түүхэн цаг үе, адил бус газар оронд адил бус үнэ цэнэ ба утга агуулга олгоно [阿雷恩, 鲍尔德温等著, 陶东风等译, 2004, x.181]. 19 дүгээр зууны 60-аад оноос монголын нийгэм ахуйн соёл сэтгэлгээ ба 20 дугаар зууны эхний төвөдийн нийгэм ахуйн соёл сэтгэлгээг тээсэн түүхч хам цагийн хэрэглээ нь хоёр туужсын бүтээлд тусгагдсан мөртөө зохиогчийн уран үзэг дор гоо сайхны хүчтэй ур цогц илэрчээ.

Гурав. Дүрийн зөрчил ба гунигт төгсгөл

Оройгүй сүм романы гол дүр Санж хар багаасаа шашны ном их сурсан боловч амьдрал ба бурхны номын ялгааг үзэж шашны хоосон чанарт аль эрт эргэлзэх болжээ. Төвөдийн гуман дацанд мацаг барьж муужирсан үед золиг гаргаж, сүнс дуудаж, оточын ухаанаар засаж, бөх гүртэмийн засалтаар засаж чадаагүй байхад “зор үгүй лам зовсон чавганц дээр” гэдгээр халх нутгийн хөгшин хүн гэрийг нь цэвэрлэж, хоол цай бэлдэж, аргалын утаа үнэртүүлж, цахилдагийн шүүсээр хоёр долоо хоног засаж Санжг тэнхрүүлжээ. “Бурхны ариун орон гэгдсэн утай, гүмбүм, лхас жоу-аар хэрэн тэнүүчилж өнгөрсөн энэ жилүүдэд ганцхан л юм ухаарсан. Тэр минь юу вэ гэвэл бурхны гүн ухаанаас амьдралын хар ухаан дээр нь байна гэдгийг л мэдсэн” байжээ. Тэр шашны хоосон чанарыг үзэж гарсан боловч мөн л сүм байгуулах дурдалт гаргажээ. Сүмийн дотоод чимэглэлийг яаж хийлгэх тухай “Байхгүй болгоныг байдаг мэтээр номлон бүх нийтээ мэхэлсээр бид олон он элээжээ. Сүжигтний сүжиг буурах цөвүүн цаг ойртжээ. Гавжтаны хэлдэг улаан хоншоорт шувуу хөлөглөж, цусан дадар долгиуулан, хүний зүрх сэгсэрч сурсан тийм амьтан хааш хэзээ ч байдаггүйг мэдэх тийм хүмүүс олирох тусам бидний номлолд байтугай сүм хийдэд минь ч бишрэхгүйд хүрнэ шүү дээ. Ядаж орон хийдээ хүний ахуй, хорвоогийн явдалд ойртуулмаар биш үү, тэгэхгүй цагт дан зохиомол хуурмаг юмаар чимсэн сүм хийдийг тоохоо болих үе тохиох биз. Далан худалчийг хүн тоодоггүй шиг хаалга хатавчнаасаа аваад хаана ч байхгүй зохиомол юмаар эрээлж будсан сүмийг яг л худалч хүнээс доорд үгүй тийм цаг ирвэл яана. Сүм хийд бол урт настай, үеийг элээн орших учиртай” хэмээн Санж хэлжээ. Тэр

THE CULTURAL WAY

хэдийгээр шашны хуурмаг чанарыг таньсан боловч хуурмаг чанараас бүрмөсөн ангижрахыг бодсонгүй, харин шашны зарим талыг өөрчлөхөөр хичээжээ. Эцэг эхээсээ, эмгэнээс, Өлзийт бадарчингаас, Отгоноос, сүжигтэн олноос сурсан амьдралын хар ухаанд нүд нээсний дараа буюу Отгоныг бие давхар болгосны хойно хар болох бодол төрсөн ч сүмийг барьж дуусгахыг юун түрүүнд бодож, сүмийг бүрэн бүтэн болгох нь хүсэл мөрөөдөл нь байсан юм. *“Явуулга, хөдөөлгө элдэв юмсаа хийж л байг. Сүмээ бариулж дуусгая. Дуусгаж аравнайлмагц би хөдөө гарч үс тавьж, хар болоод Отгонтой суух минь. Хайран өнгөрсөн өмнөх насаа нөхөж чадахаар сайхан амьдрах юмсан”* хэмээн бодож байжээ. Тэрчлэн хамба ламын ширээнээсээ хөөгдөж, хараагаа авахуулж, тарчлагдан чөлөгдсөн ч *“хорвоо дэлхий одоо түүнд тас харанхуй гүн нүх шиг”* болсон боловч хагас барьсан Чойрын дугандаа санааширч байсан юм. Нутгийнх нь ч гэсэн хоёр хүнд *“Өө тийм үү? яасан түргэн барив аа? оройг нь яаж барих вэ?”*, *“та нар тэр дуганд орж үзсэн үү?”*, *“Яаж барьсан байна?, ямар өнгөөр будсан байна?”*, *“дотор нь ном өгүүлэгчийг байлгах арслант дөрвөн ширээ засаж уу?”*, *“за тэгж үү?”*, *“ээ тэгж үү?”* ... хэмээн асуулт тавьж байсан билээ. Иймээс Санж бол шашинд үнэмшилгүй болсон боловч шашны үйлсэд зүтгэх явах зөрчилт дүр мөн.

Төвөд нууц он жил туужийн гол дүр Дэлэгийн зөрчилт чанар нь нэгдүгээр Цэрэмжим дэх хайр дурлалын тал дээр илэрдэг. *“Дэлэг бүргэд шиг өндөр хадны оргил дээр зогсож, Цэрэнжим гэрээсээ гарч ирэхийг нэг ч үг хэлэлгүй дув дуугүй хүлээнэ. Гурван цаг хүлээсэн түүнийг хурц нар шарж, нүд ба цээжийг нь хөлс бүрхэж байсан ч нэг ч хөдлөлгүй хатан зоригоор зогсож байжээ. Цэрэнжим толгойн унжсийлган алгуур гарч ирж, гарт нь нэг иж гуулин бурхантай, үүднийхээ өмнө зогсоод түүнийг харахаас зүрхшээнэ. Дэлэг түүний тов тов улаан цусан дусал нэвчин гоожиж байгаа нүцгэн толгой хийгээд гартаа барьж байгаа бурхны шуумал жич хүзүүндээ өлгөсөн цав цагаан нүд булаам хадгийг нь үзээд сэтгэл шимширэн уйлжээ. Тэнгэр өөд тэр хоолой мэдэн бархирав. Хуйхны үсийг овоортол уйлан чарлах дуу нь арван найман жилийн турш амссан зовлон зүдгүүр ба урт удаан хүслийн эвдэгдэл бүхний аврал билээ”*. Дэлэг арван найман жил хүлээсэн Цэрэнжимдээ хайртай боловч мөн түүнийг зовоож явжээ. *“Дэлэг уулын оройд гарч амьдрахдаа түүний арван дөрвөн ямааг нь хөөж авчрав. Өөр юуг нь ч хөдөлгөсөнгүй, тэрчлэн түүнийг хамгийн эцсийн удаа ч тоосонгүй”*. Дэлэг хэдийгээр хатуу

THE CULTURAL WAY

сэтгэлтэй боловч Цэрэнжим дэх хайр нь гүн зузаан, залан ууланд гарч амьдарсан боловч Цэрэнжимийг санасаар байжээ. *“Дэлэг ганцаараа хонио хариулж хоёр жилийн дараа тэсэж ядан, өдөр бүр ихэнх цагаа зарцуулан тэгш тал ба цаст хайрхны уулзварт, булгийн усан хавцалд урсаж орох амсар хурч, хавцлын гүн дэх Гуо кан тосгоныг дээрээс нь харна”*. Түүнчлэн Дэлэгийн булаан аварч ирсэн бүсгүй нь ч Цэрэнжимийг орлогч байжээ. *“Үз, бид ганцаардмал биш. Дэлэг халуумсагаар бүсгүйн тосорхог хүйтэн мөрнөөс нь тэвэрч, залан уулаа, тэр бурхан сахиус мэт бидэнд олон зүйлийг соёрхсон, бидний ойр хавьд газар сайгүй амь нас оршиж байдаг, газар сайгүй сэрэл мэдрэмж илэрч байдаг, бидний толгой дээр, биеийн дэргэд, хөл доор, юунд ч түүнийг заавал нүдээрээ үздэг”*. Иймээс Дэлэгийн Цэрэнжимийг гэх хайр дурлал нь маш ээдрээтэй болжээ.

Оройгүй сүм романы Отгон бол шашны бараанд бүтээгдсэн амьдралын гаслан зовлонг амссан дүр мөн. Үрийн хутаг гуйж ламаар айлдуулсны хариуд хоёр удаа төвөд орж мөргөл хийсэн ч тус эс олж, удаа дараа нөхрөө алджээ. Отгоны *“гэрийн дотор их л ядуу байдалтай, хойморт ганц авдар, зүүн талд бараг газар шахам зассан ор, түүний цаана бас нэг авдар, эргэнэг ийм л хогшилтой айл ажээ”*. Нутгийнхаа муу гэрт салхи бороонд цохиулж, ганцаараа амь зуун амьдарч байсан Отгоныд бороотйо шөнө зүгээ алдсан Санж хамба гэрт нь буужээ. Тэр шөнө *“орчлон хорвоо тийнхүү байхгүй юм шиг болж, гагцхүү Отгон хүүхэн хажууд нь байгааг Санж осолдохгүй мэдэрч, сэтгэлийн хямралд дуншуулан, гэрэвшиж байтал уруул дээр нь Отгоны улаа бутарсан зөөлөн хацар аяархан наалдаж”* бурхны шавь буруу замаар оржээ. *“Би чамдаа гялайлаа, гялайлаа ! гэж Отгон шивнээд яах ийхийн зуургүй Санжийн хацар дээр хэд хэд үнсээд авлаа”*. Гэвч түүний баяр удаан үргэлжилж чадсангүй, Санжаас үртэй болох мөрөөдөл биелэхийн цагт Дэмцог гавжийн дохиураар туйлуулжээ. Тиймээс шашны том савар түүний амьдралыг харлуулснаар барахгүй хэврэг амь насыг нь ч харлуулжээ.

Төвөд нууц он жилийн нэгдүгээр Цэрэнжим бол *“хайр дурлал дундах хялбарчилсан шашин (соёл)-ы загварын бэлгэдэл”* [王緋, 1993, х.79], түүний нэг насыг нь шашин суртахуунаар хашсан Гуо кан тосгоны өдөр хоногууд л мэднэ. *“Цэрэнжим хонины арьсан дэвсгэр дээрээ намуухан хэвтэж, хацар нүүрийг нь тайвуу, адурьяа бүрхсэн царайд нь*

THE CULTURAL WAY

нүдний зааг нь ч үзэгдэхгүй шахам болжээ. Шингэрсэн тосон хар богино гээг нь хялгасан утас мэт болж, аль эрт өнгө нь үзэгдэхгүй болсон англи маягийн цэргийн хувцасаа өмссөөр байж, хаан угсааны цэргийн оёсон хувцасны ханцуй захыг нь ширхэглэг болтол элэгджээ. Хөлдөө хуруу нь цуурсан өөрөө хийсэн оймсоо өмсжээ. Зул нь анивчлан, цөгцнийх нь тос дуусах шахаж, цаг мөчийг хүч шавхан өнгөрөөж байгаа мэт ...” тэр оюун ухаанаа агуйн даяанчаас аргамжиж, ганцаардлын дунд нэг насыг эцэслэжээ. Цэрэнжим хайр дурлалын хүсэлтэй, эрх чөлөөт амьдралыг хүсэх боловч аргагүй эрхэнд үе залган асарч байсан даяанчийг асрах “алба”-ын залгамжлагч болжээ. Тэрээр зүүдэндээ хүртэл хайрт хүнтэйгээ амьдрахыг хүсэж, шүтлэг бишрэл нь гуйвалзсан боловч шүтлэг бишрэл нь түүний хүслийг хашин хорьж, үхэн үхтэл хүсэл нь биелээгүй байна.

Хувь хүний уг санаатай нягт харьцаатай нь нийгмийн орчин буюу нийгмийн нөхцөл болно [弗兰克, 戈布尔著, 吕明, 陈红雯译, 1987, х.48]. Санж, Отгон, Дэлэг, Цэрэнжим нарын гунигт учрал нь хоёр эрэгтэй гол баатрн зөрчилт зан авир ба тухайн нийгмийн ахуйд үндэслэгдсэн юм. Санж хэдийгээр шашны хоосон чанарыг таньсан боловч шашныг өөрчлөхөөр дамжуулан өөр би-гийн хүсэмжлэлээ биелүүлэхээр сэтгэж байв. Дэлэгийн Цэрэнжимтэй ханилах хүсэл үгүй болсны дараа булаан авч ирсэн бүсгүйтэйгээ гэрлэжээ. Тэр хэдийгээр хүний хамгийн доод давхаргын физиологийн хүсэл болох ур би-гийн хүслээ биелүүлсэн ч, өөр би, тэрчлэн хэт би-гийн хүсэл нь мөн л шашны нөлөөнөөс биелэгдэж чадсангүй. Отгон ба Цэрэнжим тухайн нийгмийн ард түмний ур цогцын хэвшмэл дүр, гунигт учрал нь шашны хоосон чанарыг гүйцэд үл ойлгосон нийгмийн их орчин ба дүрийн өвөрмөц араншингаас болжээ.

ДҮГНЭЛТ

Монгол улсын уран зохиолч Л.Түдэвийн “Оройгүй сүм” роман ба төвөд үндэстний зохиолч Жасдаваагийн “Төвөд, нууц он жил” тууж нь түүхийн ур цогцын үзлээр оройгүй дуган хийгээд чулуужсан араг яс хэмээх шашны хоосон орон зай ба тухайн нийгмийн балархай цагийн хэрэглээний онцлогийг хадгалсан хам цагийн хүүрнэхүй цаг орныг бүтээжээ. Хоёр бүтээлийн адилавар цаг оронд дүрүүдийн зан араншин ба хувь заяа нь ч төстэй болж санасан бодсон, үл биелэсэн гунигт төгсгөлөөр эцэслэжээ. Зохиогчийн зохион бүтээсэн нийгмийн үзэл

THE CULTURAL WAY

суртлын адил бусаас болж утга санааны талаар зөрөөтэй болж, Оройгүй сүм нь шүүмжлэлийн талаас бүтээн, Төвөлд нууц он жил нь соёл иргэншилд хандах талаас чухалчлан туурвижээ. Тус хоёр бүтээл нь тухайн нийгмийг уран зохиолоос ойлгоход зохих дэм болох мөртөө, өөр бусад үндэстний уран бүтээлчдийн бүтээж үл чадах өвөрмөц уран нарийн үзэл ойлголтын агуулгатай болсон байна.

НОМ ЗҮЙ

1. Т.Эрдэнэтогтох, Сүх. “Монголчуудын гүн ухааны үзэл санааны түүх”, ӨМАХХ, 2019
2. Ш.Нацагдорж. “БНМАУ-ын соёлын түүх”, ӨМСХХ, 1988
3. Хайрхан, Нахиа. “Өнөөгийн монгол туужсын түүхийн ур цогцын үзэл”, ӨМИСЭШС, 2020, №1
4. С.Баатар. “Монгол үндэстний ёс зүйн үзэл санааны түүх”, ӨМАХХ, 2018
5. Зоригт. “Бурхны шашны соёл мэдлэг”, ЛяМУБСХГ, 2000
6. Хайрхан. “Өнөөгийн монгол уран зохиолын орон цагийн загварын шинжлэл”, 2021, №3
7. Мандах. “Монгол ардын аман зохиолын тойм”, ӨМСХХ, 2017
8. Баатар, Цэцэг. “Монгол ардын аман зохиолын тухай”, ӨМСХХ, 1985
9. С.Дулмаа. “Монгол бэлгэдэл зүй”, ӨМАХХ, 2009
10. Т.Эрдэнэтогтох. “Монголчуудын уламжлалт онолын сэтгэхүй”, ӨМАХХ, 2017
11. 王绯：《魔幻与荒诞：攥在扎西达娃手心儿里的西藏》，当代作家评论，1993年，第4期
12. 佛洛依德著，傅雅芳，郝冬瑾译：《文明及其缺憾》安徽文艺出版社，1987年
13. 龙迪勇：《空间叙事学》，生活，读书，新知三联书店，2015年
14. 程金城著：《原型批判与重释》，甘肃人民美术出版社，2008年
15. 范春文，王琼：《藏族传统数字文化探析》，《西藏大学学报》，2010年
16. 张洋：《论新时期的轮回转世母体小说》，西南大学硕士学位论文，2014年，转引自：扎西达娃：《西藏，隐秘岁月》，长江文艺出版社，1995年
17. 谭君强著，《叙事学导论：从经典叙事学到后经典叙事学》（第二版），高等教育出版社，2014年
18. 弗兰克，戈布尔著，吕明，陈红雯译：《第三思潮-马斯洛心理学》上海文艺出版社，1987年

THE CULTURAL WAY

ABSTRACT

The historical roots of Mongolian-Tibetan cultural relations have a long history, and the spread of traditional Tibetan Buddhism in Mongolia has had a profound effect on the lives of Mongolians. These are works that detail how religious influences affect people's lives in Mongolia and Tibet. Tibetans living in Tibet, the holy land of God, are deeply influenced by religion and have a unique secret religion. These works are a brief history of individuals, genealogies, families and their development.

Key words: *Narrate, Emptiness, Joint, Appearance*

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

NEWS



THE CULTURAL WAY CENTER FOR CULTURAL STUDIES

“СОЁЛЫН ЖИМЭЭР” Соёл Судлалын Төвийн тухай

Анх 2015 онд монгол судлаач залуу эрдэмтдийн судалгааны ажлыг дэмжих, харилцан туршлага солилцох зорилготойгоор “Содон Соёд” эрдэм шинжилгээний нэгдэл байгуулагдаж байв.

2020 оноос “Соёлын Жимээр” соёл судлалын төв болгон өргөтгөв. Тус төвийн үйл ажиллагааны цар хүрээ улам өргөжин, судалгаа шинжилгээний ажлыг сурталчлахын сацуу орчуулга, хөрвүүлгийн ажлыг гүйцэтгэх боллоо. Эрдэм шинжилгээний өгүүллийг хөрвүүлж найруулан, монгол улсад хэвлэгдэх стандартад нийцүүлэх, тухайн ажлыг сэтгүүлд хэвлүүлэх ажлыг гүйцэтгэсээр ирэв. Мөн тусгай төслийн хүрээнд бичигдсэн судалгааны ажлыг хөрвүүлж, орчуулан монгол улсад хэвлүүлэх ажлыг зохион байгуулсаар байна. Үүнээс гадна бидний бас нэг онцлох үйл ажиллагаа бол монгол судлаач эрдэмтдийн судалгааны ажлыг дэмжих зорилгоор эрдэм шинжилгээний сэтгүүлийг монгол улсад эрхлэн хэвлүүлэх ажлыг өрнүүлсээр байна.

2022 оны 1 дүгээр улирлаас манай сэтгүүл **ISSN** буюу олон улсын эрдэм шинжилгээний номын санд албан ёсоор бүртгэгдэн цаашид улирал тутам хэвлэхээр төлөвлөн ажиллаж байна.

РЕДАКЦ

© Тус сэтгүүлийг хэвлэх эрх хуулиар хамгаалагдсан болно.

“СОЁЛЫН ЖИМЭЭР” Соёл Судлалын Төвөөс
кирилл үсэгт хөрвүүлсэн судалгааны бүтээлээс


1400 ЖИЛИЙН ӨМНӨХ ӨВӨГ
МОНГОЛ ХЭЛ

1400 жилийн өмнөх Өвөг
Монгол хэл
НТГ-ний судалгаа

Салонгол Л.Хурибаатар


Салонгол Л.Хурибаатар / Салонгол Л.Хурибаатар / ④

Салонгол Л.Хурибаатар / Салонгол Л.Хурибаатар / ④




Elias Verlag IMoFiF e.V.
Cologne Germany 2020

ᠠᠨᠠᠨᠠ ᠮᠣᠭᠤᠯᠤᠰ ᠪᠤᠴᠢᠨ ᠲᠤᠨᠤᠯᠤᠰ



МОНГОЛ УЛАСЫН ХУУЛЬ, ЗАСАГ, ЭРХИЙН ЗӨВӨӨН



“СОЁЛЫН ЖИМЭЭР” эрдэм шинжилгээний сэтгүүлд
ISSN: 2791-1446 өгүүлэл хүлээн авах

Ерөнхий шаардлага:

- Урьд өмнө хэвлэгдээгүй байх
- Монгол судлал ба түүх, соёлын чиглэлийн асуудлыг хөндсөн байх
- Шинжлэх ухааны үндэслэлтэй, шинэлэг үзэл санаа дэвшүүлсэн байх
- Судалгааны логик уялдаа, дэс дараалал тодорхой байх

Техник шаардлага:

- Кирил үсгээр бичигдсэн байх (үүний хамт гарчиг, товч агуулга, түлхүүр үг зэргийг англи хэл дээр бичих)
- Хэл зүй хийгээд найруулга зүйн ямар нэг алдаагүй байх
- Үг үсгийн алдаагүй байх
- Цаасны хэмжээ В5
- Үсгийн өндөр 12
- Эшлэл зүүлтийг тухайн хуудсанд хийх эсвэл АРА форматаар бичсэн байх (үсгийн өндөр 10)
- Нүүрийн тоо – 8-20

Судалгааны ажлын бүтэц:

Гарчиг

- Гарчиг англи хэл дээр (content)
- Судлаачийн овог нэр, эрдмийн цол зэрэг, эрхэлж буй ажил, и-мэйл хаяг, утасны дугаарыг бичих
- Товч агуулга
- Товч агуулга англи хэл дээр (summary)
- Түлхүүр үг
- Түлхүүр үг англи хэл дээр (key word)
- Судалгааны үндсэн хэсэг
- Дүгнэлт
- Ном зүй
- Дагалдуулал (хэрвээ шаардлагатай бол үйлдэх)

Өгүүлэл хэвлэгдэх явц:

- Өгүүлэл хүлээн авна.
- Өгүүллийг редакцийн гишүүд шүүн хэлэлцэнэ.
- Хэвлэх ба үл хэвлэхийг шийднэ.
- Хэвлэгдэх боломжтой засварлах, өөрчлөх зүйлс буйг мэдэгдэнэ (тодорхой хугацаа өгнө).
- Өгүүлэл хэвлэгдэнэ.

- 8-20 – ז'ומה למ מפתח -
- 10) מפתחה למ רחמנא) פסקה למרנרנר מפתח APA רנה רנה פה למרפמנר למ סומה פ' למתנר למרנר -
- 12 מפתחה למ רחמנא -
- B5 נרנרנר ו למרנרנר -
- פסקה ררנר נרנרנר למ רחמנא רחמנא -
- פסקה ררנר נרנרנר רנר נרנר נרנרנרנר למ רנר רחמנא (פסקה נרנר רחמנא)

ז'ומה ררנר רחמנא פסקה למרנרנרנר סר רחמנא למרנא -

נרנרנרנרנר רחמנא :

- פסקה ררנרנרנר למרנרנר ררנר , נרנרנרנר למרנר ו למרנרנר -
- פסקה למרנרנרנרנרנר נרנרנר , למרנר למרנרנרנרנר ו למרנרנר רחמנא -
- פסקה למרנרנרנרנרנר למ רחמנא , רחמנא רנה למרנרנר למרנרנר -
- פסקה ררנרנר רחמנא ררנרנרנר ר' למרנרנר למ רחמנא -

נרנרנרנרנרנר :

סומה למרנרנרנרנרנר פה למרנרנר למרנר רחמנא ר' למרנר רחמנא»

